

## ГАРЧИГ

	Хуудас
Эрх зүйн тайлбар.....	7
Талархал.....	7
Эмхтгэлийн тухай танилцуулга/Оршил.....	7-8

### **БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС**

Тээврийн эрх бүхий байгууллага .....	9
Автотээврийн тухай гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцдаг эрх бүхий байгууллагууд.....	9
Автотээврийн салбарын удирдлага, зохион байгуулалтыг хариуцдаг эрх бүхий байгууллагууд.....	9-10
Зөвшөөрлийн бичгийг олголт болон хяналтыг хариуцдаг эрх бүхий байгууллагууд.....	10
БНХАУ-д тээврийн хэрэгсэл жолоодход тавигдах ерөнхий шаардлагууд .....	10-12
Тээврийн хэрэгслийн хамгийн их овор хэмжээ, жингийн зохицуулалт .....	12-15
Тогтоосон овор хэмжээ, жингийн хэмжээг дагаж мөрдөөгүй тохиолдолд ногдуулах торгууль .....	15-17
Зам дээрх хяналт, шалгалт .....	17
Овор хэмжээ ихтэй болон хүнд даацын тээврийн хэрэгсэлд хамаарах зохицуулалт .....	18
Аюултай ачаа тээвэрлэхэд тавигдах шаардлага	
Аюултай ачааны тодорхойлолт .....	18-19
Аюултай ачаа тээвэрлэхэд тавигдах шаардлагууд .....	19-21
Автотээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэх онцгой зөвшөөрөл .....	21
Авто замаар аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх .....	21-22
Жолоочийн хөдөлмөр болон амралтын цагийн зохицуулалт	
Хяналт, шалгалтын байгууллагууд .....	22
Зөрчилд хүлээлгэх хариуцлага .....	23
Тээврийн хэрэгсэлд зориулсан хөдөлгөөнийг хянах хиймэл дагуулын системд тавих шаардлагууд болон дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын нэмэлт хэрэгслүүд	23
Тээврийн хэрэгсэлд суурилуулсан хиймэл дагуулын байршил тодорхойлох систем .....	23

Электрон түгжээ .....	23
Онцгой байдлын үед дуудлага өгөх утасны дугаарууд	23
Авто замын засвар, арчлалтын ажил	
Авто замын засварын ажил болон тэдгээрийн талаарх мэдээлэл ....	23-24
Авто замын ажил гүйцэтгэх үед замын болон мэдээлэх тэмдэгүүд ...	24
Улирлын хязгаарлалтууд .....	24-25
Авто замын аюултай хэсгүүд болон тэдгээрийн талаарх мэдээлэл .....	25
Төлбөр төлөх аргууд .....	25
Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто зам	
АН-3 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл .....	25
Хилийн шалган нэвтрүүлэх “Эрээн” боомт .....	26
Хилийн шалган нэвтрүүлэх “Эрээн” боомтын дэд бүтэц .....	26-28
АН-3 чиглэлийн авто зам дээрх ослын болон туслах байгууллагууд	28-32
Төлбөртэй авто замаар зорчих төлбөр .....	32-34
Төлбөр төлөх аргууд .....	34
Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто зам	
АН-4 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл .....	34-35
Хилийн шалган нэвтрүүлэх “Такашкен” боомт .....	35
Хилийн шалган нэвтрүүлэх “Такашкен” боомтын дэд бүтэц .....	35-36
Шалган нэвтрүүлэх Хонгираф боомт (Хонгираф дүүрэгт орших) .....	36
Хонгираф боомтын дэд бүтэц .....	36-37
Хилийн боомтод хийгддэг гаалийн бүрдүүлэлтийн үндсэн үе шатууд	37-38
АН-4 чиглэлийн авто зам дээрх ослын болон туслах байгууллагууд	38-41
АН-4 чиглэлийн авто замаар зорчиход төлөх төлбөр, хураамж .....	41-42
Төлбөр төлөх аргууд .....	42

## МОНГОЛ УЛС

Тээврийн эрх бүхий байгууллага	
Автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тээврийн салбарын удирдах болон зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагууд .....	43
Тээврийн хэрэгслийн хамгийн их овор хэмжээ, жин, даацын талаарх зохицуулалт	43-44
Тогтоосон овор хэмжээ, жингийн хэмжээг хэтрүүлсэн зөрчилд оногдуулах торгууль .....	44
Зам дээрх хяналт, шалгалт .....	45

Овор хэмжээ ихтэй болон хүнд даацын тээврийн хэрэгсэлд хамаарах зохицуулалт .....	45
Авултай ачаа тээвэрлэхэд тавигдах шаардлагууд .....	45-46
Авто замаар юултай ачаа тээвэрлэх онцгой зөвшөөрөл .....	46
Аюултай ачаа тээвэрлэх .....	46
Жолоочийн хөдөлмөр амралтын цагийн зохицуулалт	46-47
Хяналт, шалгалтын байгууллагууд .....	47
Хяналт, шалгалт хийх аргууд .....	47
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах хиймэл дагуулын системд тавих шаардлагууд болон дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын нэмэлт хэрэгслүүд .....	47
Тээврийн хэрэгсэлд суурилуулсан хиймэл дагуулын байршлыг тодорхойлох систем .....	47
Түргэн тусламжийн албадын утасны дугаарууд .....	47-48
Авто замын засвар, арчлалт .....	
Авто замын засварын ажлууд болон тэдгээрийн талаарх мэдээлэл .	48
Улирлын чанартай хязгаарлалтууд .....	48-49
Авто замын аюултай хэсгүүд болон тэдгээрийн талаарх мэдээлэл .....	49
Төлбөр төлөх аргууд .....	49
Замын төлбөр, хураамж .....	49-50
АН-3 болон АН-4 чиглэлийн авто зам дээрх шалган нэвтрүүлэх хилийн боомтууд .....	50
Монголын хил дээрх хяналт, шалгалтын байгууллагууд .....	50-51
Хилийн боомтоор нэвтрүүлэхийг зөвшөөрсөн бараа бүтээгдэхүүнүүд .....	51-56
Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто зам	56
АН-3 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл .....	56
Хилийн шалган нэвтрүүлэх Алтанбулаг боомтын дэд бүтэц болон мөрдөх журам .....	56-57
Олон улсын тээвэрлэлтийн үед хийгддэг хяналт, шалгалтын журам	57-58
Хилийн шалган нэвтрүүлэх Замын-Үүд боомтын дэд бүтэц болон журам .....	58-60
Авто замын тэмдэг болон тэмдэглэгээ .....	60
Замын төлбөр хураах цэгүүд .....	60-61
АН-3 чиглэлийн авто замын дагуух түргэн тусламжийн байгууллагууд .....	61-63
АН-3 чиглэлийн авто замын дагуух үйлчилгээний төвүүд .....	63-66

Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто зам	
АН-4 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл .....	66
Хилийн шалган нэвтрүүлэх Цагааннуур боомтын дэд бүтэц болон журам .....	66-68
Хилийн шалган нэвтрүүлэх Булган боомтын дэд бүтэц болон журам .....	68-70
Замын тэмдэг болон тэмдэглэгээ .....	70-71
Замын төлбөр хураах цэгүүд .....	71
АН-4 чиглэлийн авто замын дагуух түргэн тусламжийн байгууллагууд .....	71-72
АН-4 чиглэлийн авто замын дагуух үйлчилгээний төвүүд .....	72

### **ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС**

Тээврийн эрх бүхий байгууллага	73
Автотээврийн гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тээврийн салбарыг удирдах, зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагууд .....	73
Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл олгодог байгууллага ..	73
Тээврийн хэрэгслийн хамгийн их овор хэмжээ, жингийн зохицуулалт .....	73-75
Тогтоосон овор хэмжээ, жингийн хэмжээг хэтрүүлсэн зөрчилд оногдуулах торгууль .....	75
Авто зам дээрх хяналт, шалгалт .....	75-76
Овор хэмжээ ихтэй болон хүнд даацын тээврийн хэрэгсэлд хамаарах зохицуулалт .....	76
Аюултай ачаа тээвэрлэхэд тавигдах шаардлагууд .....	
Жолоочийн хөдөлмөр, амралтын горимтой холбогдсон журмууд .....	77
Хяналт, шалгалт хийдэг байгууллагууд .....	77
Хяналт, шалгалт хийх журам .....	77
Түргэн тусламжийн байгууллагуудын утасны дугаарууд .....	77
Авто замын засвар, арчлалт .....	77-78
Авто замын засварын ажил болон тэдгээрийн талаарх мэдээлэл .....	78
Авто замын ажил гүйцэтгэх үед замын болон мэдээллийн тэмдэгүүд	78
Улирлын чанартай онцгой хязгаарлалтууд .....	78
Авто замын аюултай хэсгүүд болон тэдгээрийн талаарх мэдээлэл .....	78
Үндэсний баярууд .....	78-79
Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто зам .....	79

АН-3 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл .....	79
Замын нөхцөл.....	79
Төлбөртэй замын мэдээлэл .....	79
Хилийн шалган нэвтрүүлэх Хиагт боомтын дэд бүтэц болон журмууд .....	79-80
Хилийн шалган нэвтрүүлэх Хиагт боомтын гаалийн болон бусад шалган нэвтрүүлэх журам .....	80-81
Авто зам дагуух түргэн болон бусад тусламжийн байгууллагууд .....	81
Гал туймрээс урьдчилан сэргийлэх тусламжийн уйлчилгээ .....	81
Эруул мэндийн тусламжийн уйлчилгээний байгууллагууд .....	81
Авто засварын газрууд .....	81-82
ШТС-ууд .....	82
Байрлах байр .....	83
Хувийн ариун цэвэр (бие засах газар) болон нийтийн хоолны газрууд (цэвэр ус) .....	83-84
Банкууд болон АТМ-ууд .....	84-85
Жингийн хяналтын цэг (пүү) .....	85
Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто зам .....	85
АН-3 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл .....	85-86
Замын тодорхойлолт .....	86
Хилийн шалган нэвтрүүлэх «Ташанта» боомтын дэд бүтэц болон шалган нэвтрүүлэх журам .....	86-87
Хилийн шалган нэвтрүүлэх «Ташанта» боомтын гаалийн болон бусад шалган нэвтрүүлэх процессын журам .....	87-88
Авто зам дагуух түргэн тусламжийн байгууллагууд .....	88
Эмнэлгийн байгууллагууд .....	89
Засварын газрууд болон ШТС .....	90-93
Байрлах байр, зочид буудал .....	93-100
Банкууд болон АТМ-ууд .....	100-101
Онц байдлын үед холбогдох холбооны газрууд .....	101-103
Хавсралтууд .....	104-116

## **Эрхзүйн тайлбар**

Энэхүү эмхтгэлд дурдагдсан санаанууд нь зөвхөн уг эмхтгэлийн зохиогчдын санаа бөгөөд ямар нэгэн байдлаар НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын байр суурийг илэрхийлээгүй болно. Уг эмхтгэлд гарч буй бүхий л санаа, тоон үзүүлэлтүүд болон дүгнэлт, үнэлгээнүүд нь мөн адил зохиогчдын эх үүсвэр болоод хариуцлагынх бөгөөд НҮБ-ын үзэл бодлыг илэрхийлээгүй ба НҮБ-ын зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзэхгүй болно.

Уг эмхтгэлд дурдагдаж буй аливаа улс орны талаарх бүхий л мэдээлэл нь (тайлбар), тодруулбал аливаа улсын эрхзүйн статус, нутаг дэвсгэр, хот суурингууд, дүүргүүд, болон тус улсын эрх баригчид болон аливаа улсын хил хязгаар тогтоохтой холбоотой бүхий л мэдээлэл/тайлбар нь НҮБ-ийн нарийн бичгийн даргын нарын газартай хамааралгүй болно.

Эмхтгэлд нэр нь дурдагсан байгууллага болон худалдааны бүтээгдэхүүнүүд нь НҮБ-аар баталгаажсан, хүлээн зөвшөөрөгдсөн гэсэн үг биш.

Уг номонд тусгагдсан газрын зураг дээрх хил, хилийн зурвас, тэдний нэр нэршил нь НҮБ-аас албан ёсоор баталгаажсан, хүлээн зөвшөөрөгдсөн гэж ойлгохгүй.

Энэхүү хэвлэл нь албан ёсоор редакторлагдаагүй хэвлэл болно.

## **Талархал**

Энэхүү эмхтгэлийг биеллээ олж хэвлэгдэхэд туслан үнэт хувь нэмрээ оруулсан БНХАУ, Монгол Улс, ОХУ-ын холбогдох байгууллагуудад, тэдний ажилчдад/мэргэжилтнүүдэд сайн дураар хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллээр ханган бүхий л талаар дэмжин ажилласанд НҮБ-ийн ESCAP-ын нарийн бичгийн холбооны зүгээс талархалаа илэрхийлж байна. Мөн онцгой талархлыг энэхүү төслийг дэмжин санхүүжилтээр хангаж ажилласан БНХАУ-ын Засгийн газарт талархал дэвшүүлье.

## **Оршил**

2016 оны 12-р сарын 08-ны өдөр БНХАУ, Монгол улс, ОХУ “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан. Энэ нь Азийн авто авто замуудыг олон улсын авто замын тээвэрт ашиглахаар тусган баталсан анхны хэлэлцээр болсон. Энэхүү хэлэлцээр нь БНХАУ, Монгол улс, ОХУ-ын гурван талт хамтын ажиллагааны хамгийн дээд түвшиний илэрхийлэл төдийгүй ба гурван улсын цаашдын харилцаа хамтын ажиллагааг сайжруулаад зогсохгүй, шинэ гадаад хамтын ажиллагааны үндэс суурь болсон юм. Тус хэлэлцээр нь бодит хэлэлцээр бөгөөд улс хоорондын, дан ялангуяа далайд гарцгүй Монгол улсын хувьд худалдаа болон тээврийн сүлжээг хөгжүүлэх хөгжлийн гол түлхэц, суурь болох юм. Мөн түүнээс гадна уг хэлэлцээр батлагдсанаар Монгол Улс далайд гарцтай болохоос гадна, Монгол Улсын төв болон баруун бүсийн авто замаар дамжин ОХУ болон БНХАУ-ыг холбох шинэ гарцуудыг хөгжүүлж байгаа юм. Ингэснээр энэхүү хэлэлцээрийг тус бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны хөгжлийн үндсэн талбар болж байна гэж үзэж байгаа юм.

Хэлэлцээр батлагдсанаар АН-3 зам буюу Улаан-Үд (ОХУ) хотоос, Улаанбаатар (Монгол Улс) болон Бээжин (БНХАУ) хотуудаар дамжин Тяньжин боомт (БНХАУ) хүрэх маршрут, мөн АН-4 зам буюу Новосибирск (ОХУ) хотоос, Үрэмчи (БНХАУ) болон Кашигаар (БНХАУ) дайран Хонгираф (БНХАУ болон Пакистан Улсын хил) орох маршрутыг тус тус нээсэн. Тус замууд нь Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн хамтын ажиллагааны санаачлагын хүрээнд хүрсэн хамгийн бодит үр дүнтэй ажил юм. Энэхүү хэлэлцээрт “Азийн авто замын сүлжээний хэлэлцээр”-т нэгдсэн орсон бусад улс орнууд нэгдэх боломжтой. Ингэснээр бүс нутгийн цаашдын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжран хөгжих юм.

Хэлэлцээрийг баталгаажуулсны дараа гурван улсын зүгээс уг хэлэлцээрийг бодитоор хэрэгжихэд туслалцаа үзүүлж, дэмжиж ажиллах хүсэлтийг НҮБ-ын АНДЭЗНК-н Нарийн бичгийн дарга нарын газарт ирүүлсэн. Энэхүү гарын авлага нь АН-3 болон АН-4 замуудын дэд бүтэц болон хилийн шалган нэвтрүүлэх боомтуудын хяналт, шалгалтын үйл ажиллагаа, мөн дээрх замуудын дагуух бусад тусламж, үйлчилгээний байгууламжууд гэх мэт бодит мэдээллийг агуулахаас гадна Азийн авто замын 3 болон 4 дүгээр замуудаар олон улсын авто тээврийг нэвтрүүлэх, эдгээр замуудыг идэвхтэй ашиглах ажлын хэрэгжилтийн эхлэл болон хэвлэгдэж буй эмхтгэл юм.

## **БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС**

### **Тээврийн эрх бүхий байгууллагууд**

**Авто тээврийн Хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцаж, хангаж ажиллах эрх бүхий байгууллагууд**

БНХАУ-ын Авто замын тээврийн журам болон холбогдох эрх зүйн зохицуулалтын дагуу Тээврийн яам, аймгийн тээврийн эрх бүхий газар нь олон улсын автотээврийн удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр дараах үүргийг хэрэгжүүлдэг.

**Автотээврийн тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллагууд**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Автотээврийн дүрэм болон Тээврийн яамнаас гаргасан холбогдох баримт бичгийн дагуу бүс нутгийн тээврийн байгууллага нь олон улсын автотээврийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр дараах үүргийг хэрэгжүүлнэ.

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон холбогдох улсуудын Засгийн газар хооронд гарын үсэг зурсан хэлэлцээрийн хэрэгжилт;
2. Холбогдох засаг захиргааны бүс нутгуудад олон улсын автотээврийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах;
3. Тээврийн яам, эсхүл Ардын Засгийн ордноос зөвшөөрөл олгосны дагуу муж/аймаг/-ийн түвшинд хоёр талын автотээврийн хамтын ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагууд болон орон нутгийн удирдлагуудтай яриа хэлэлцээ хийх;
4. Тээврийн яамнаас чиглэл болгосны дагуу холбогдох төрийн байгууллагуудтай хамтран олон улсын автотээвэртэй холбоотой хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, зохицуулах;
5. Холбогдох засаг захиргааны нутаг дэвсгэр болон хөрш орнуудын хүрээнд олон улсын автотээврийн маршрутын дагуу хяналт, шалгалт хийх;
6. Орон нутгийн удирдлагатай хамтран өөрийн засаг захиргааны нутаг дэвсгэрийн хүрээнд олон улсын автотээврийн зохион байгуулалтын асуудлаар хилийн шалган нэвтрүүлэх боомтод зөвлөл байгуулах талаар Тээврийн яам болон улсын удирдах байгууллагуудын түвшинд саналаа хүргүүлэх;

**Тээврийн салбарын удирдлага, зохион байгуулалтын асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллагууд**

БНХАУ-ын Автотээврийн дүрэм, холбогдох эрх зүйн зохицуулалтын дагуу Тээврийн яам, түүнээс эрх олгосон зам тээврийн салбарын эрх бүхий алба нь өөрийн засаг захиргааны бүсэд олон улсын авто тээврийн үйл ажиллагааг



удирдан зохион байгуулах бөгөөд олон улсын автотээврийн чиглэлээр дараах үүргийг хүлээнэ:

- (1) Олон улсын автотээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох.
- (2) Олон улсын тээвэрлэлтэд ашиглах жолооны үнэмлэхийг хэвлэх, солилцох, түгээх, ашиглах ажлыг удирдан зохион байгуулах зэрэг асуудлыг хариуцдаг.
- (3) Олон улсын тээврийн бичиг баримт болон харьяалах тэмдгүүдийг хэвлэх, түгээх асуудлыг хариуцдаг;
- (4) Хөрш орнуудын холбогдох байгууллагуудтай тээврийн аж ахуйн нэгжүүд, тээврийн хэрэгсэл, жолооч нарын талаар мэдээлэл солилцох, олон улсын авто тээвэртэй холбоотой асуудлыг зохицуулах, хэлэлцэн шийдвэрлэх чиглэлээр ажиллах;
- (5) Хүнд даацын болон аюултай ачаа тээвэрлэх зорилгоор БНХАУ-ын нутаг дэвсгэрт нэвтрэх гадны тээврийн хэрэгслийн мэдүүлгийг хүлээн авч, олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийг олгох;
- (6) Олон улсын автотээврийн салбарын зах зээлийн харилцааг дэмжих;
- (7) Олон улсын авто тээврийн талаарх статистик мэдээллийг гаргаж, мэдээлэх.

### **Зөвшөөрөл олгох, шалгах ажлыг хариуцдаг эрх бүхий байгууллага**

БНХАУ-ын Авто тээврийн дүрэм болон холбогдох журмын дагуу олон улсын автотээвэрлэлтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь аймгийн тээврийн эрх бүхий газрын хилийн боомтод байрлах орон нутгийн салбар нэгж байх бөгөөд уг салбар нь дараах үүргийг гүйцэтгэдэг:

- (1) Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг, тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар болон бүртгэлийн гэрчилгээ болон бусад олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх холбогдох зөвшөөрлийг шалгана;
- (2) Хилийн боомтод олон улсын автотээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх;
- (3) Хилийн боомтын дотор болон гадна талд тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтийн асуудлуудад зохицуулалт хийх;
- (4) Хилийн боомтод олон улсын тээврийн баримт бичгийг олгох асуудлаар орон нутгийн тээврийн байгууллагад удирдамж, чиглэл өгөх ажлыг гүйцэтгэх.

Үүний зэрэгцээ Нийгмийг аюулаас хамгаалах газрын Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс нь гадны тээврийн хэрэгсэл түр хугацаагаар орж ирэх зөвшөөрөл болон түр хугацааны жолоодох эрхийн үнэмлэх олгох бөгөөд ингэхдээ гадны тээврийн хэрэгсэл болон жолоочийн өмнөх мэдээллийг шалгаж, хэрэв өмнө нь замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, зам тээврийн осол гаргаж байсан нь тогтоогдвол БНХАУ-ынн нутагт түр хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг олгохгүй.

## **БНХАУ-д тээврийн хэрэгсэл жолоодоход тавигдах ерөнхий шаардлага**

БНХАУ-ын нутаг дэвсгэрт байгаа гадны тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэл нь өөрийн улсын бүртгэлийн дугаар болон бүртгэлийн гэрчилгээтэй байна. Жолооч нь жолоодож буй тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирсон өөрийн улсын, эсхүл олон улсын жолоодох эрхийн үнэмлэхтэй байх бөгөөд хэлэлцэн тохирогч нөгөө талын албан ёсны хэл рүү орчуулсан орчуулгатай байна.

Жолооч нь жолоодох эрхийн үнэмлэхэд тодорхой заасан ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох бөгөөд тээврийн хэрэгсэл жолоодож байх үед жолоодох эрхийн үнэмлэхээ биедээ авч явна.

Гадны тээврийн хэрэгсэл нь БНХАУ-ын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ холбогдох газарт хандан өргөдөл гаргах бөгөөд автомашиныг түр хугацаагаар нэвтрүүлэх түр дугаарын тэмдэг болон зөвшөөрлийг авна.

Түр хугацааны улсын дугаарын тэмдэг, эсхүл зөвшөөрөл авахаар өргөдөл гаргаж буй этгээд нь "Тээврийн хэрэгслийн түр дугаарын тэмдэг болон жолооны үнэмлэх олгох өргөдлийн маягт"-ыг хятад хэлээр бөглөж, тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулж, дараах гэрчилгээ болон бусад холбогдох бичиг баримтыг ирүүлнэ:

- (1) Өөрийн улсын эрх бүхий байгууллагаар баталгаажсан автотээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээг, хятад хэл рүү орчуулсан баталгаат орчуулгын хамт (бүртгэлийн гэрчилгээ нь хятад хэлээр илэрхийлэгдээгүй тохиолдолд);
- (2) Автотээврийн хэрэгслийг БНХАУ-ын нутаг дэвсгэрт нэвтрэхийг зөвшөөрсөн тухай БНХАУ-ын гааль, эсхүл бусад байгууллагаас олгосон зөвшөөрлийн бичиг;
- (3) Автотээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, аюулгүй байдлыг хангасан тухай гэрчилгээ, хэрэв эдгээр нь гадны эрх бүхий байгууллагаас олгож, баталгаажуулсан бол хятад хэл дээрх орчуулга;
- (4) Хятад улсад тээврийн хэрэгслийн зам тээврийн ослын хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан тухай гэрчилгээ, хүчинтэй хугацаа нь түр хугацаагаар байх хугацаанаас богиногүй байна.

Нийгмийг аюулаас хамгаалах газрын Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс нь өргөдлийн материалыг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор ирүүлсэн гэрчилгээ, бичиг баримтуудыг судлан үзэж, автомашиныг шалгана. Хэрэв өргөдөл нь шаардлагад нийцэж байвал тээврийн хэрэгсэлд түр хугацааны дугаарын тэмдэг болон түр хугацаагаар нэвтрэх зөвшөөрлийг олгоно.

Гадны тээврийн хэрэгслийн жолооч нь зөвшөөрөл авч түр хугацаагаар орох зөвшөөрөл авсны дараа 2 хоногийн дотор тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг болон жолооны үнэмлэх олгодог орон нутгийн байгууллагад хандан

тээврийн хэрэгслийн түр дугаарын тэмдэг болон тээврийн хэрэгслийг жолоодох түр хугацааны үнэмлэх олгох өргөдөл гаргана.

Автотээврийн хэрэгсэл жолоодох түр хугацааны зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагч нь "Автотээврийн хэрэгслийг түр хугацаагаар ашиглах зөвшөөрөл олгох өргөдлийн маягтыг" хятад хэл дээр бөглөж, дараах гэрчилгээ болон баримт бичгүүдийг ирүүлнэ:

- (1) Иргэний орох, гарах бичиг баримт, үнэмлэх;
- (2) Гадаад жолооны үнэмлэх, хятад хэлээр бичигдээгүй бол хятад хэл дээрх орчуулга;
- (3) Жолоочийн нас, эрүүл мэндийн байдал нь Хятад Улсад тээврийн хэрэгсэл жолоодоход тавигдах шаардлагад нийцэж байгааг нотлох бичиг баримт;
- (4) 1 инчийн хэмжээтэй хоёр ширхэг цээж зураг (ойрын хугацаанд авахуулсан байх, малгайгүй байх, цагаан дэвсгэртэй байх);
- (5) Хэрэв Хятадын холбогдох эрх бүхий байгууллагаас зохион байгуулалттай аялал, уралдаан, эсхүл бусад үйл ажиллагаанд оролцох гэрчилгээ олгосон бол түүнийг заавал ирүүлнэ.

Нийгмийг аюулаас хамгаалах байгууллагын Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс өргөдлийн материалыг хүлээн авснаас хойш гурван хоногийн дотор өргөдлийг судлан үзэх бөгөөд өргөдөл нь шаардлагад нийцсэн тохиолдолд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн талаар сонирхсон этгээдүүдэд сургалт явуулж, тээврийн хэрэгсэл жолоодох түр зөвшөөрлийг олгоно.

#### **Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх хамгийн их жин болон овор хэмжээний талаарх зохицуулалт**

Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх тээврийн хэрэгсэл нь Хятад Улсад холбогдох газраас тогтоосон овор хэмжээний болон тэнхлэг дээр ачаалах даацын шаардлагыг хангасан байна. Хэрэв бусад улсуудтай тээврийн хэрэгслийн овор хэмжээ болон тэнхлэг дээрх даац, жингийн талаар тусгай гэрээ, хэлэлцээр байгуулсан бол уг гэрээ, хэлэлцээрийг дагаж мөрдөнө. [54]

Тээврийн хэрэгслийн гаднах хамгийн их овор хэмжээ: урт нь 20 м, өргөн нь 2,55 м, өндөр нь 4 м;

Тэнхлэг дээрх хамгийн их зөвшөөрөгдөх ачаалал 24000 кг;

Ачаатай үеийн зөвшөөрөгдөх хамгийн их бүх жин 49 тонн [55];

Автомашинаар тээвэрлэж буй ачааны жин нь тээврийн хэрэгслийн үйлдвэрээс тогтоосон даацаас хэтрэхгүй байна.

Ачааны урт ба өргөн нь тээврийн хэрэгслийн овор хэмжээнээс хэтрэхгүй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

1. Том, дунд оврын ачааны автомашин, эсхүл хагас чиргүүлийн ачаатай үеийн өндөр нь газраас 4 м-ээс хэтрэх ёсгүй. (чингэлэг тээвэрлэгч - 4.2 м);
2. Ачаа тээвэрлэж буй бусад төрлийн тээврийн хэрэгслийн өндөр нь газраас 2.5 м-ээс хэтрэх ёсгүй.
3. Мотоциклын хувьд тээвэрлэж буй ачааны өндөр нь газраас 1.5 м, урт нь мотоциклын уртаас 0.2 м-ээс хэтрэх ёсгүй. Хоёр дугуйт мотоциклын хувьд тээвэрлэж буй ачааны өргөн нь мотоциклын гарны /жолооны/ өргөнөөс 0.15 м-ээс хэтрэх ёсгүй. Гурван дугуйт мотоциклын хувьд ачааны өргөн нь мотоциклын өргөнөөс хэтрэх ёсгүй.

Хэрэв задалж болохгүй, овор хэмжээ, эсхүл жин нь авто зам, гүүр, авто замын нүхэн гарц/туннель/-аар тээвэрлэлт гүйцэтгэхэд тогтоосон өргөн, өндөр, уртын хязгаараас хэтэрсэн ачааг авто зам, гүүр, нүхэн гарцаар тээвэрлэх зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд тээвэрлэлтэд оролцох аж ахуйн нэгж, иргэн нь овор ихтэй болон хүнд жинтэй ачаа тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл авах асуудлаар тухайн авто зам хариуцсан холбогдох шатны захиргааны байгууллагад хандана.

Тухайн авто замыг хариуцдаг захиргааны байгууллага нь овор хэмжээ ихтэй, хүнд ачаа тээвэрлэх хүсэлтийг баталгаажуулсан тохиолдолд Төрийн зөвлөлийн дэргэдэх автотээврийн удирдах газраас тогтоосон форматын дагуу холбогдох зөвшөөрлийг олгоно. Овор хэмжээ ихтэй болон хүнд жинтэй ачаа тээвэрлэх зөвшөөрөл авсан тээврийн хэрэгсэл нь тогтоосон замнал, цагийн хуваарийн дагуу тогтоосон хурдыг баримтлан тээвэрлэлт гүйцэтгэх бөгөөд холбогдох ялгах тэмдгээр тоноглогдсон байна. Овор хэмжээ ихтэй болон хүнд жинтэй ачаа тээвэрлэх зөвшөөрлийг түрээслэх, эсхүл өөр этгээдэд шилжүүлж болохгүй. Хуурамч болон хүчингүй зөвшөөрөл ашиглахыг хориглоно. [57]

Хүснэгт 1: Ачааны автомашин, чиргүүл болон тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний зөвшөөрөгдөх хамгийн их овор хэмжээ (мм)

Тээврийн хэрэгслийн төрөл (Т/Х)		Урт	Өргөн	Өндөр	
Автомашин	Гурван дугуйтай автомашин	4600	1600	2000	
	Хурд багатай ачааны автомашин	6000	2000	2500	
	Ачааны автомашин болон хагас чиргүүлийн чирэгч	12000	2550	4000	
	Суудлын автомашин болон автобус	Суудлын автомашин болон хоёр тэнхлэгтэй автобус	12000	2550	4000
		Гурван тэнхлэгтэй автобус	13700		
Угсраа автобус		18000			

Чиргүүл	Хагас чиргүүл	13750	2550	4000
	Төвийн байрлалтай тэнхлэгтэй чиргүүл	12000		
Хосолсон тээврийн хэрэгсэл	Зорчигч тээврийн чиргүүлтэй автомашин	14500	2550	4000
	Угсраа тээврийн хэрэгсэл	17100		
	Ачааны авто угсраа	20000		

Тайлбар:

г. Тээврийн хэрэгслийн уртын хязгаарлалт нь ачаа тээвэрлэхэд зориулагдаагүй тусгай зориулалтын автомашинд хамаарахгүй.

с. хөргүүртэй автомашины зөвшөөрөгдөх хамгийн их өргөн нь 2600 мм байна.

т. Замналаар зорчих хоёр давхар автобусны хамгийн их өндөр нь 4200 мм байна.

и. 45 футийн чингэлэг тээвэрлэж буй хагас чиргүүлийн хамгийн урт нь 13950 мм байна.

v. Төвийн байрлалтай тэнхлэгтэй/чиргүүлтэй чиргүүлийн хамгийн их урт нь 8000 мм байна.

w. хосолмол тээврийн хэрэгслийн хамгийн их урт нь 18100 мм байна.

х. Төвийн тэнхлэгтэй автомашин тээвэрлэгч чиргүүлийн хамгийн их урт нь 22000 мм байна.

Хүснэгт 2: ачааны автомашин, чиргүүл болон тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний зөвшөөрөгдөх хамгийн их жин (кг):

Тээврийн хэрэгслийн төрөл		Хамгийн их жин (кг)	
Автомашин	Гурван дугуйтай автомашин	2000	
	Суудлын автомашин	4500	
	Хоёр тэнхлэгтэй автобус, ачааны автомашин болон хагас чиргүүл чирэхэд зориулагдсан чирэгч	18000	
	Гурван тэнхлэгтэй автобус, ачааны автомашин болон хагас чиргүүл чирэхэд зориулагдсан чирэгч	25000	
	Угсраа автобус	28000	
	Жолоодлогын механизм нь хоёр голтой дөрвөн тэнхлэгтэй автомашин	31000	
Чиргүүл	Чиргүүл	Нэг голтой	18000
		Хоёр голтой	35000
		Гурван голтой	40000
	Чирэх гартай /тяга/ чиргүүл	Дан дугуйтай хоёр голтой	12000
		Нэг гол нь дан дугуйтай, нөгөө гол нь давхар	16000

		дугуйтай хоёр голтой	
		Давхар дугуйтай хоёр голтой	18000
	Төвийн байрлалтай тэнхлэгтэй чиргүүл	Нэг голтой	10000
		Хоёр голтой	18000
		Гурван голтой	24000
Тээврийн хэрэгсэл	Гурван тэнхлэгтэй	27000	
	Дөрвөн тэнхлэгтэй	36000	
	Таван тэнхлэгтэй	43000	
	Зургаан тэнхлэгтэй	49000	

Тайлбар:

i. Хурд багатай ачааны автомашины хамгийн их зөвшөөрөгдөх жин нь 4500 кг байна.

m. хөтлөх тэнхлэгийн хоёр

n. дугуйны өргөн нь 425 мм-ээс багагүй тээврийн хэрэгслийн хамгийн их зөвшөөрөгдөх жин нь 18000 кг байна.

o. хийн нумтай, тэнхлэг хоорондын зай нь 1800 мм, тэнхлэг бүр нь хоёр талдаа давхар дугуйтай угсраа тээврийн хэрэгслийн хамгийн их бүх жин нь 38000 кг байна.

### **Жин, овор хэмжээний нормыг хэтрүүлсэн зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээ**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тээврийн яамны 2016 оны 62 дугаар тушаалаар баталсан “Авто замаар хүнд болон овор хэмжээ ихтэй тээврийн хэрэгсэл зорчуулах тухай дүрэм”-д: Хэрэв тээврийн хэрэгслийн овон хэмжээ болон жин нь тогтоосон хязгаараас хэтэрсэн бол зөрчил гарсан газар зүйн байршил, учруулсан хохирол болон зөрчлийн нөхцөл байдлаас шалтгаалан дээрх дүрэмд заасны дагуу торгууль ногдуулна:

- Хэрэв ачаатай тээврийн хэрэгслийн нийт өндөр нь 4,2 м-ээс бага, нийт өргөн нь 3 м-ээс бага, нийт урт нь 20 м-ээс бага бол тухайн этгээдийг 200 юаниар торгоно. Хэрэв ачаатай тээврийн хэрэгслийн нийт өндөр нь 4,5 м-ээс бага, нийт өргөн нь 3,75 м-ээс бага, нийт урт нь 28 м-ээс хэтрээгүй бол тухайн этгээдийг 200-аас 1000 юаниар торгоно.
- Хэрэв ачаатай тээврийн хэрэгслийн нийт өндөр нь 4,5 м-ээс их, өргөн нь 3,75 м-ээс их, эсхүл нийт урт нь 28 м-ээс хэтэрсэн бол тухайн этгээдийг 1000-аас 3000 юаниар торгоно.
- Хэрэв ачаатай тээврийн хэрэгслийн жин тогтоосон хязгаараас 1000 кг-аас бага хэмжээгээр хэтэрсэн бол сануулна. Хэрэв ачаатай тээврийн хэрэгслийн жин нь тогтоосон хэмжээнээс 1000 кг-аас дээш хэмжээгээр

хэтэрсэн бол жолоочийг хэтэрсэн 1000 кг тутамд 500 юаниар торгоно. Торгуулийн дээд хэмжээ 30000 юанаас хэтрэхгүй.

- Дээр дурдсан зөрчил болгонд торгуул оногдуулах бөгөөд нийт торгуулийн хэмжээ 30 000 юаниас хэтрэхгүй.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу хурдны авто замын удирдлагын газар, эсхүл Нийгмийн аюулаас хамгаалах газрын Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс нь холбогдох шаардлагыг хангаагүй тээврийн хэрэгслээр авто замаар зорчсон зөрчилд хариуцлага хүлээлгэх эрхтэй.

Тээврийн хэрэгслийн овор хэмжээ, тэнхлэг дээрх ачаалал, эсхүл тээврийн хэрэгслийн нийт жин нь авто зам, гүүр, нүхэн гарц болон гармаар зорчих тээврийн хэрэгсэлд тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд замын хөдөлгөөний удирдлагын газраас дүрэм зөрчсөн этгээдээр зөрчлийг арилгуулж, 30000 хүртэл юанийн торгууль оногдуулах эрхтэй.

Тээврийн хэрэгсэл нь хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэх онцгой зөвшөөрөл авсан хэдий ч заасан хугацаа, тогтоосон маршрут болон тогтоосон хурдыг баримтлан замын хөдөлгөөнд оролцоогүй бол Нийгмийн аюулаас хамгаалах газрын Замын хөдөлгөөний удирдлагын хэлтсээс зөрчлийг арилгах шаардлагыг тавих бөгөөд хэрэв зөрчил гаргагч нь тавьсан шаардлагыг биелүүлэхээс татгалзвал тээврийн хэрэгслийг саатуулна.

Хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл байхгүй тохиолдолд авто замын хөдөлгөөний удирдлагын газраас тээврийн хэрэгслийг саатуулж, жолоочоос хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэлт гүйцэтгэх онцгой зөвшөөрөл болон бусад холбогдох зөвшөөрлийг авч ирэхийг шаардана.

Хэрэв хүн овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэлт гүйцэтгэх онцгой зөвшөөрлийн бичгийг бусдад дамжуулсан бол авто замын хөдөлгөөний удирдлагын газар зөвшөөрлийн бичгийг хураан авч, 1000-аас 5000 юанийн торгууль ногдуулна.

Хүнд жинтэй болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэлт гүйцэтгэх хуурамч болон хүчингүй зөвшөөрлийн бичиг ашигласан нь тогтоогдсон бол авто замын хөдөлгөөний удирдлагын газар зөвшөөрлийн бичгийг хураан авч, 30000 хүртэл юанийн торгууль оногдуулна.

Ачааны автомашин нь жилийн турш 3 буюу түүнээс дээш хууль бус тээвэрлэлт гүйцэтгэсэн бол автотээврийн захиргааны газар тээврийн хэрэгслийн ашиглалтын гэрчилгээг буцаан татна; Овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй ачааны автомашины жолооч нь жилийн турш 3 болон түүнээс дээш хууль бус тээвэрлэлт гүйцэтгэсэн бол автотээврийн захиргааны байгууллагаас ашгийн төлөө төлбөртэй тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно; хэрэв жилийн турш тээвэрлэгч аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийн 10 болон түүнээс дээш хувь нь овор хэмжээ ихтэй ачааг хууль бусаар тээвэрлэсэн тохиолдолд автотээврийн захиргааны байгууллагаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлана; хэрэв нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд түүний тээвэрлэлт гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ тухай олон нийтэд мэдэгдэнэ.

Хэрэв ачсан ачаа нь тээврийн хэрэгслээс нурсан, асгарч гоожсон, үүнээс шалтгаалан авто замын гадаргууд гэмтэл учруулсан, эсхүл хүрээлэн орчныг бохирдуулсан бол автотээврийн захиргааны байгууллага зөрчлийг арилгуулах бөгөөд 5000 хүртэл юанийн торгууль ногдуулна.

Хэрэв дараах байдлаар энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд авто замын удирдах байгууллага тээврийн хэрэгслийг албадан гаргах, эсхүл саатуулах бөгөөд 30000 хүртэл юанийн торгууль оногдуулна:

- Овор хэмжээ, жингийн хяналт, шалгалтаас зайлсхийх зорилгоор шалган нэвтрүүлэх цэгийг тойрон гарсан, эсхүл бусад аргаар тээврийн хэрэгслийг саатуулсан;
- Илүү гарсан ачааг богино зайд өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэн замаар хариуцлагаас зайлсхийсэн.
- Хэрэв тээвэрлэгч аж ахуйн нэгж нь жолоочийг албадан хүнд, овор хэмжээ ихтэй ачааны тээвэрлэлтийг хууль бусаар гүйцэтгүүлсэн.

### **Авто зам дээрх хяналт, шалгалт**

Нэгдүгээр зэргийн төлбөртэй авто зам, гүүр болон хонгил, нүхэн гарцаар замын хөдөлгөөнд оролцсон ачааны автомашин, зорчигчийн тээврийн хэрэгсэл болон ачаа-зорчигчийн автомашинаас тэдгээрийн жингээс хамааран төлбөр авна. Төлбөртэй авто замуудын бүтээн байгуулалтын ажилд зориулан төлбөртэй авто замыг зохицуулах журамд заасны дагуу дараах техникийн түвшин болон масштабыг баримтална:

- Хурдны авто замын хувьд алслалтын зай нь 30 км-ээс их байна;
- Гол замуудын хувьд алслалтын зай нь 50 км-ээс их байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-д заасны дагуу:

69 дүгээр зүйл: Хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж буй Нийгмийг аюулаас хамгаалах цагдаагийн байгууллагаас бусад ямар ч аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл хуулийн этгээд хяналт шалгалт хийх зорилгоор тээврийн хэрэгслийг хурдны авто зам дээр саатуулж болохгүй. Дүрмийн дагуу тусгай хяналт, шалгалт хийх талбайг нийтийн үйлчилгээний байгууламжуудын төлбөртэй зогсоолуудын талбайд байгуулдаг бөгөөд тусгай хяналтын бүсүүдийн үйл ажиллагааг бүс нутгаас баталсан журмаар зохицуулна.

Авто зам дээр автотээврийн хэрэгсэл жолоодох дүрмийн 39 дүгээр зүйлд тусгайлан заасан: Ачааны автомашин авто зам руу орох үед хяналтын тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтээс хамааран шалгалтад хамрагдах бөгөөд даац хэтрүүлсэн тээврийн хэрэгслийг авто зам руу оруулахгүй.

Үүнээс гадна 40 дүгээр зүйлд Замын хөдөлгөөнийг удирдах байгууллага нь авто замыг хамгаалах шаардлагатай тохиолдолд ачааны автомашин авто зам руу ордог гол зам, эсхүл авто зам дээрх чухал гүүр болон уулзваруудад тээврийн хэрэгслийг хянах, шалгах төхөөрөмжүүдийг суурилуулах бөгөөд хуульд заасны дагуу даац хэтрүүлсэн зөрчил илэрсэн тохиолдолд буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэнэ. Тээврийн хэрэгслийн жолооч нь тусгай хяналтын бүсэд хяналтад



орох үед уг хяналтын бүс нь хууль ёсны эсэх талаарх мэдээллийг дараах утасны дугааруудаар холбогдон лавлах боломжтой:

**Тээврийн хэрэгслийн жингийн хэмжээний Хүлээн авах утас хяналт, шалгалтыг удирдах газар**

Бээжин	010-67134378
Тяньжин	022-24139169
Хэбэй	0311-7617925
Өвөр Монголын Өөртөө Засах Орон	0471-6965352
Шинжианы Өөртөө Засах Орох	0991-5852032

**Овор хэмжээ ихтэй болон хүнд даацын тээврийн хэрэгсэлд хамаарах журам**

Автотээврийн хэрэгсэл жолоодох дүрмийн 6 дугаар зүйлд тогтоосон хэмжээнээс хэтэрсэн овор хэмжээтэй тээврийн хэрэгсэл жолоодох бол: авто замаар задлах боломжгүй овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь хуульд заасны дагуу онцгой зөвшөөрөл авах бөгөөд тээвэрлэлт гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа тогтоосон цагийн хооронд, урьдчилан тогтоосон замналаар тогтоосон хурдыг мөрдөн замын хөдөлгөөнд оролцоно.

Аймгууд, автономит мужууд болон хотуудын хооронд тээвэрлэлт гүйцэтгэхийн тулд тээвэрлэлт дайран өнгөрөх мужуудын авто замыг хариуцдаг агентлагт өргөдөл гаргана. Агентлаг нь овор хэмжээ хэтэрсэн ачаа тээвэрлэх чиглэлийн дагуух орон нутгийн авто замын удирдах бүх газруудад мэдээлэл хүргэнэ. Мужийн авто замын удирдах байгууллага нь өргөдөл хүлээн авсны дараа холбогдох зөвшөөрлийг олгох, тээвэрлэлтэд хяналт тавих чиглэлээр тээвэрлэлт явагдах чиглэлийн дагуух авто замын хөдөлгөөний удирдах байгууллагуудад чиглэл өгч тээвэрлэлтийг зохицуулж, зохион байгуулах арга хэмжээг авна. Шаардлагатай тохиолдолд өрөгдлийг Тээврийн яаманд хүргүүлж, хянуулна. Нэг мужийн нэг хотын дүүрэг хооронд, эсхүл автономит бүс нутгийн хооронд, эсхүл дүүргийн засаг захиргааны нэгжийн хооронд тээвэрлэлт хийх өргөдлийг тээвэрлэлт явагдах байршлын дагуух орон нутгийн авто замын удирдах газарт гаргах бөгөөд эдгээр байгууллагууд нь өргөдлийг хүлээн авах ёстой. Үүнээс гадна дүүргүүдийн хооронд тээвэрлэлт хийх өргөдлийг дүүргийн түвшний авто замын удирдах агентлагт гаргах бөгөөд эдгээр байгууллагууд нь өргөдлийг хүлээн авах ёстой.

**Аюалтай ачаа тээвэрлэхэд тавигдах шаардлагууд**

**Аюултай ачааны тодорхойлолт**

Автотээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэх тухай дүрэмд заасан тодорхойлолтод үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгал нь тусгай хамгаалалтын арга хэмжээ шаардагддаг хүн, амьтанд хор хөнөөл учруулах, тэсэрч дэлбэрэх, шатамхай, хортой, халдвартай болон идэмхий бодисыг аюултай

ачаанд хамааруулсан. Аюултай ачааны ангилал (GB12268) гэх мэт үндэсний стандартад дурдагдсан бүтээгдэхүүнүүд аюултай ачаанд тооцогдох бөгөөд энэхүү ангилалд хамрагдахгүй бүтээгдэхүүний талаар холбогдох хууль болон захиргааны дүрмийн хүрээнд Төрийн зөвлөлийн холбогдох газраас гаргасан шийдвэр нь стандарттай адил байна.

Аюултай ачааны ангилал, бүтээгдэхүүний заалт, бүтээгдэхүүний нэршил болон тэдгээрийн тоон кодлолт нь Аюултай ачааны ангилал болон дугаарлалт (GB6944) болон Аюултай ачааны ангилал (GB12268) зэрэг үндэсний стандартын шаардлагад нийцсэн байна.

### **Аюултай ачааны тээвэрлэлтэд тавих шаардлагууд**

Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх өргөдөл гаргаж буй этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

V. Өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжтэй байна:

- Өргөдөл гаргагч нь 5 болон түүнээс дээш тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлтэй (чиргүүлийг оролцуулахгүй) байх, эсхүл химийн маш хортой болон тэсэрч дэлбэрэх бодис тээвэрлэдэг 10 болон түүнээс дээш тээврийн хэрэгсэлтэй (чиргүүлийг оролцуулахгүй) байх;
- Тусгай зориулалтын тээврийн хэрэгслүүд нь Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтын журамд заасан техникийн шаардлагыг хангасан байх;
- Өргөдөл гаргагч нь харилцаа холбооны найдвартай техник хэрэгсэлтэй байх ёстой;
- Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нь дүрс бичлэг хийх функцтэй GPS төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- Өргөдөл гаргагч нь тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг маш хортой, тэсрэх аюултай, химийн аюултай бодис тээвэрлэх бол авто цистерн, фургон, даралт болон тусгай зориулалтын чингэлэгтэй байх;
- Тусгай зориулалтын авто цистерны агуулах сав нь чанарын албаны шалгалтаар орох ёстой бөгөөд ачаалалсны дараах бүх жин нь үйлдвэрээс тогтоосон хэмжээнд нийцэх ёстой. Тэсэрч дэлбэрэх болон онцгой аюултай ачаа тээвэрлэх тусгай зориулалтын автоцистерны эзлхүүн нь 20 куб.м-ээс хэтрэх ёсгүй, харин маш хортой бодис тээвэрлэхэд зориулагдсан үндэсний стандартын шаардлагыг хангасан тусгай даралтат савнаас бусад төрлийн автоцистерны эзлхүүн нь 10 куб.м-ээс хэтрэх ёсгүй;
- Үндэсний стандартын шаардлагыг хангасан чингэлэг тээвэрлэгч хөлөг онгоцноос бусад маш хортой, тэсрэх аюултай болон идэмхий зэрэг аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн цистернгүй үеийн батлагдсан даац нь 10 тн-оос хэтрэх ёсгүй;
- Өргөдөл гаргагч нь тээвэрлэж буй аюултай ачааны төрлөөс хамаарч аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчинг хамгаалах болон гал түймэртэй тэмцэх багаж, техник хэрэгсэлтэй байх.

VI. өргөдөл гарагч нь дараах шаардлагыг хангасан зогсоолын талбайтай байна:

- Зогсоолын талбай нь өргөдөл гарагчийн үйл ажиллагааны онцлог болон хэмжээнээс хамааран өөрийн эзэмшлийн, эсхүл 3-аас дээш жилийн хугацаатай түрээсийн хэлбэрээр байж болох бөгөөд тэр объект нь өргөдөл гаргагчийн бүртгэлтэй засаг захиргааны бүсэд байрлалтай байх;
- Хэрэв маш хортой химийн болон тэсрэх бодис тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл болон тусгай зориулалтын автоцистерны тоо 20 буюу түүнээс бага бол тэдгээрт зориулагдсан зогсоолын талбайн хэмжээ нь тэдгээр тээврийн хэрэгслүүдийн талбайгаас 1,5 дахин их байх ёстой, харин тээврийн хэрэгслийн тоо 20 буюу түүнээс их тохиолдолд заасан тооноос хэтэрсэн тээврийн хэрэгсэл тутамд зориулагдсан зогсоолын талбайн хэмжээ нь тэдгээрийн ортогограф проекцийн талбайгаас багагүй байна. Хэрэв бусад төрлийн аюултай ачааны тээвэрлэлтэд ашиглагддаг тээврийн хэрэгслийн тоо нь 10 болон түүнээс бага тохиолдолд тэдгээрт зориулагдсан зогсоолын талбайн хэмжээ нь тэдгээр тээврийн хэрэгслийн талбайгаас 1,5 дахин их байх ёстой, харин тээврийн хэрэгслийн тоо нь 10-аас их тохиолдолд заасан тооноос хэтэрсэн тээврийн хэрэгсэл тутамд зориулагдсан зогсоолын талбайн хэмжээ нь тэдгээрийн ортогограф проекцийн талбайнаас багагүй байна.
- Зогсоолын талбайн газар нь хашаалагдсан, тодорхой тэмдэгтэй байх ёстой бөгөөд хүний амьдрах очринд нөлөөлөх ёсгүй байхын зэрэгцээ нийгэмд аюул заналхийлэл учруулах ёсгүй.

VII. Өргөдөл гаргагч аж ахуйн нэгжийн бүтцэд дараах шаардлагыг хангасан аюулгүй байдлын мэргэжилтнүүд болон ажилтнууд байна:

- Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл жолоодох жолооч нь тухайн тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхтэй байх бөгөөд жолоочийн нас нь 60-аас хэтрэх ёсгүй;
- Жолооч болон аюултай ачааны ачилт, буулгалтыг удирдан зохион байгуулах этгээдүүд, мөн аюултай ачааг дагалдан явах этгээдүүд зэрэг аюултай ачааны тээвэрлэлтэд оролцох хүмүүс нь Ардын Засгийн ордны хотын түвшний тээврийн эрх бүхий байгууллагад шалгалт өгч, мэргэших сертификат авсан байна. Жолооч болон аюултай ачааны ачилт, буулгалтыг удирдан зохион байгуулах этгээдүүд, мөн аюултай ачааг дагалдан явах этгээдүүд зэрэг маш хортой химийн бодис болон тэсрэх бодисын тээвэрлэлтэд оролцох хүмүүс нь “маш хортой химийн бодисын тээвэрлэлт” болон “тэсэрч дэлбэрэх бодисны тээвэрлэлт” гэсэн чиглэлээр шалгалт өгч, сертификат авсан байна;
- Үйлдвэрт 24 цагийн байнгын харуул хамгаалалт ажиллана.

VIII. Өргөдөл гаргагч нь аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах дүрмүүдтэй байна:

- Аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хариуцан ажилладаг удирдах албан тушаалтнууд, аюулгүй байдлын хэлтсийн ажилтан, бүтэн цагийн хамгаалалтын ажилтнуудын аюулгүй ажиллагааны дүрэм;
- Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм;

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр сургах болон дадлагажуулах дүрэм;
- Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж болон зогсоолын талбайн ажиллагсад зориулсан аюулгүйн ажиллагааны дүрэм;
- Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- Ажлын аюулгүй ажиллагааны дүрэм;
- Аюулгүй ажиллагааны үнэлгээний, шагнал, урамшуулал болон хариуцлагын дүрэм;
- Ослын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон статистик мэдээллийг илтгэх дүрэм.

### **Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тусгай зөвшөөрөл**

Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх өргөдөл гаргагч аж ахуйн нэгж нь холбогдох хуулийн дагуу үйлдвэр, худалдааны захиргааны албанд бүртгүүлсний дараа хотын орон нутгийн Зам-тээврийн удирдах газарт өргөдөл гаргаж, холбогдох материалыг хүргүүлнэ.

Хотын Зам-тээврийн удирдах газар нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Автотээврийн дүрэм болон тусгай зөвшөөрөл олгох журамд заасан хугацаанд үзлэг шалгалт хийж, аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслүүдэд тусгай зөвшөөрөл олгоно.

Асуудал нааштайгаар шийдвэрлэгдсэн тохиолдолд Зам-тээврийн удирдах газар аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх чиглэлээр Захиргааны байгууллагын шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд хүргүүлэх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлөөс гадна тээвэрлэх аюултай ачааны шинж чанар (бүтээгдэхүүний ангилал, нэр төрөл болон хэрэв маш хортой химийн бодис тээвэрлэх бол үүнийг ч мөн тэмдэглэнэ), тоо хэмжээ болон тусгай зориулалтын тээврийн хэрэгслүүд, тэдгээр тавигдах шаардлагыг тэмдэглэсэн байх бөгөөд өргөдөл гаргагч этгээдэд аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг 10 хоногт багтаан олгоно.

### **Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх журам**

Аюултай ачаа илгээгч буюу тээвэрлүүлэгч нь аюултай ачааг тээвэрлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид тэдгээрийг тээвэрлэх эрхийг олгоно.

Аюултай ачаа илгээгч буюу тээвэрлүүлэгч нь холбогдох шаардлагыг хатуу баримтлан, зохих ёсоор ачааг савлаж, сав, баглаа, боодлыг шошгожуулах, мөн аюултай ачааны нэр, төрөл, тоо хэмжээ, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг тээвэрлэгч болон жолоочид өгөх, мөн шаардлагатай бол саармагжуулагчийг тээвэрлэгчид өгч, тэдгээрийг хэрхэн ашиглах талаарх мэдээллээр тээвэрлэгчийг хангана.

Химийн аюултай ачаа тээвэрлэх тохиолдолд аюултай ачааны илгээгч нь аюулгүй ажиллагааны техникийн шаардлага болон шошго, тэмдэглэгээг хийсэн байх бөгөөд тэдгээр нь тээвэрлэж буй аюултай ачааны шинж чанартай яг таарч байх ёстой.

Жолооч нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээг биедээ авч явна. Автотээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэх тухай журам (JM617)-д заасан шаардлагын дагуу жолооч, эсхүл ачааг дагалдан явах этгээд нь аюултай ачаа тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны карттай байна.

Аюултай ачааны тээвэрлэлтийн явцад аюултай ачаа нь жолоочоос гадна дагалдан яваа этгээдийн хараа хяналтад байлгах үүднээс тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг дагалдуулан тусад нь өөр автомашин явуулна.

Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэж буй автотээврийн аж ахуйн нэгж, хуулийн этгээд нь өөрсдийн жолооч болон ачааг дагалдан яваа этгээдээс маршрутын дагуу техникийн шаардлагууд, тогтоосон хугацаа, хөдөлгөөний хурдыг чанд мөрдөх, мөн томоохон үзэсгэлэн яармаг болон баяр ёслолын үеэр хурдны авто замаар маш хортой болон тэсэрч дэлбэрэх аюултай бодисыг тээвэрлэх чиглэлээр холбогдох эрх бүхий байгууллагаас өгсөн заавар, чиглэлийг хэрэгжүүлэхийг шаардах ёстой.

Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэж буй автотээврийн аж ахуйн нэгж, эсхүл хуулийн этгээд нь GPS систем, эсхүл жолоочийн ажил, амралтын горимын мөрдөлт, хурд хэтрүүлэлт болон тогтоосон маршрутын дагуу тээвэрлэлт гүйцэтгэж байгаа эсэх, дүрэм, журмыг зөрчиж буй эсэхийг шууд хянах, зохицуулах хяналтын төвтэй байна. Зам-тээврийн удирдах газрын албан тушаалтнууд нь автотээврийн байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулах ёстой.

Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэж буй тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн эзэмшигч нь шалгалт хийгдэж буй тухайн байршилд бүртгүүлсэн талаарх нотлох баримт бичиг болон бусад шаардлагатай баримт бичгүүдийг зам-тээврийн удирдах газарт гаргаж өгөх боломжгүй тохиолдолд эдгээр тээврийн хэрэгслүүдийг хяналт, шалгалтын явцад саатуулж болно.

### **Жолоочийн ажил, амралтын хугацааны зохицуулалт**

Автотээврийн аж ахуйн нэгжид зориулсан Аюулгүй ажиллагааны дүрмийн 45 дугаар зүйлд: Жолооч нарын хоногт буюу 24 цагийн хугацаанд жолоо барих хугацаа 8 цагаас хэтрэх ёсгүй (онцгой тохиолдолд энэ хугацааг 2 цагаар уртасгаж болох боловч сард 36 цагаас хэтрэх ёсгүй), тасралтгүй жолоо барих хугацаа нь 4 цагаас хэтрэх ёсгүй бөгөөд зогсоол бүрт амрах хугацаа нь 20 минутаас багагүй байх зэрэг шаардлагыг тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд хатуу мөрдөнө.

### **Хяналт, шалгалтын байгууллагууд**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийг аюулаас хамгаалах байгууллага нь улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг хариуцна. Орон нутгийн засаг захиргааны дэргэдэх Нийгмийг аюулаас хамгаалах байгууллага нь өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд, түүнээс дээд түвшний байгууллага нь өөрийн засаг захиргааны нутаг дэвсгэрт холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг хариуцах үүрэгтэй.

Дүүргийн болон түүнээс дээш түвшний Засгийн газрын харьяа Замын хөдөлгөөний болон барилгын ажлын хяналтын газрууд нь өөрт оногдсон чиг үүргийнхээ дагуу замын хөдөлгөөнийг хангах чиглэлээр холбогдох ажлыг хариуцна.

### **Зөрчилд хүлээлгэх хариуцлага**

БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу нийгмийг аюулаас хамгаалах байгууллагын Замын хөдөлгөөний удирдлагын газар нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, журмыг зөрчсөн тохиолдолд тээврийн хэрэгслийн жолооч нарт захиргааны шийтгэл ногдуулна.

Замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж, зогсолтгүйгээр 4 цагаас илүү хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл аяллын явцад амраагүй, зогсолт хийсэн хэдий ч амрах хугацаа нь 20 минут хүрээгүй зэрэг зөрчил гаргасан этгээдэд 19-р зүйлийн 11-т заасныг үндэслэн сануулах, эсхүл 200 юанийн торгууль ногдуулж, жолооны үнэмлэхээс 2 оноог хасна.

БНХАУ-ын нутаг дэвсгэрт тээвэрлэлт гүйцэтгэж буй гадны жолооч нар тээвэрлэлтийн явцад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг дагаж мөрдөнө.

**Тээврийн хэрэгсэлд зориулагдсан хиймэл дагуулын хяналтын системд тавигдах шаардлагууд болон дамжин өнгөрөх тээврийн аюулгүй байдлын нэмэлт хэрэгслүүд**

**Тээврийн хэрэгсэлд суурилуулсан хиймэл дагуулын байршлыг тодорхойлох систем**

Автотээврийн хэрэгсэл жолоодох болох хяналт тавих журамд заасны дагуу суудлын автомашин, аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүд, хүнд даацын хагас чиргүүл болон ачааны автомашин (бүх жин нь 12 тонн болон түүнээс дээш энгийн ачааны автомашин)-д жолоодлогын үеийн бичлэг хийх функц бүхий хиймэл дагуулын байршил тогтоох төхөөрөмж ашиглах ёстой.

### **Цахим түгжээ**

"Цахим түгжээ" гэж танигдсан хамгаалалтын ухаалаг төхөөрөмжийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дэвсгэрт ашиглахыг зөвшөөрдөг. Энэ нь өндөр технологийн бүтээгдэхүүн бөгөөд микро компьютер, RFID (радио давтамжийг тодорхойлох төхөөрөмж), GPS (Global Position System), мэдээллийн аюулгүй байдал, гаалийн хяналт, шалгалтыг хялбаршуулах, тээврийн аж ахуйн нэгжүүдийн гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагддаг хүлээлгийн хугацааг бодитоор богиносгох болон ачаа эргэлтийг хурдасгах зэрэг технологиудыг өөртөө багтаасан байдаг.

### **Яаралтай тусламжийн дугаарууд**

120 - Түргэн тусламжийн төв

110 - Цагдаа

119 – Гал түймэртэй тэмцэх алба

122 - Зам тээврийн ослын дуудлага хүлээн авах дугаар.

### **Зам засварын ажлууд болон тэдгээрийг мэдээлэх**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай журмын 50 дугаар зүйлд заасны дагуу замын захиргааны байгууллага нь зам засварын үеэр замын хөдөлгөөний түгжрэлээс зайлсхийхийн тулд шаардлагатай бүхий арга хэмжээг авна.

Зам засварын ажлын үед замын хөдөлгөөний түгжрэл үүсэж болзошгүй хөрш зэргэлдээ аймгууд, автономит мужууд болон Засгийн газрын харьяа хот, суурьшлын бүсүүдийг холбодог авто замуудад засвар арчлалтын ажил хийх тохиолдолд замын хөдөлгөөний маршрут гаргах болон хамтран авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах зорилгоор тухайн засаг захиргааны авто замын удирдах газар, эсхүл Нийгмийг аюулаас хамгаалах Тээврийн газар нь хөрш аймаг, автономит мужууд болон Засгийн газрын харьяа хот, суурьшлын бүсүүдийн Замын газарт, эсхүл Нийгмийг аюулаас хамгаалах Тээврийн газарт албан бичиг хүргүүлнэ.

Замын засвар ажлын талаарх мэдээллийг аймгийн Авто тээврийн газрын албан ёсны вэб сайтаас олж авч болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай журмын 51 дүгээр зүйлд заасны дагуу авто замын засвар, арчлалтын ажилд зориулан замын хөдөлгөөнийг хаах шаардлага гарсан бол тухайн авто замын засвар хийгдэх хэсгийн хөдөлгөөний аль нэг чиглэлийг хаана. Хэрэв засварын ажил хийгдэх авто замын урт нь 2 км болон түүнээс дээш урттай, зам засварын ажил нь 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжлэх онцгой тохиолдлоос бусад үед тойрог замын маршрутыг баталж, тэмдэг тавих бөгөөд энэ тухай зам засварын ажил эхлэхээс 5 хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ. Хэрэв тойрог замын маршрут гаргах боломжгүй тохиолдолд түр замыг барина.

### **Зам засварын ажлын үеийн замын болон мэдээлэх тэмдэг, дохионууд**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай журамд заасны дагуу зам засварын ажил гүйцэтгэж буй ажилтан нь аюулгүйн тэмдэг бүхий ажлын дүрэмт хувцас өмсөх ёстой.

Зам засварын ажил гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжид ашиглалтын болон аюулаас урьдчилан сэргийлэх гэрэл дохионы хэрэгсэл суурьлагдсан байна.

Замын засвар, арчлалтын ажлын үед барилгын ажил явагдаж буй бүх хэсгүүдэд буй замын засвар, арчлалтын ажлын талаар мэдээлэх самбар, замын тэмдэг, тэмдэглэгээг холбогдох стандарт, нормын дагуу хийж гүйцэтгэнэ.

### **Улирлын чанартай тусгай хязгаарлалтууд**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай журамд заасны дагуу хэрэв тодорхой шалтгаанаар тухайн авто замаар тээврийн хэрэгслийг зорчуулах боломжгүй болсон тохиолдолд авто замын холбогдох байгууллагууд болон Нийгмийг аюулаас хамгаалах газрын Замын хөдөлгөөнийг удирдах газраас холбогдох талуудад бичгээр мэдэгдэнэ.

Иргэд замын хөдөлгөөний талаарх тодорхой мэдээллийг сонин, сэтгүүл, эсхүл Өвөр Монголын Өөртөө Засах Орны болон Шинжиан Уйгарын Өртөө Засах Орны втозамын удирдах газруудыг веб сайтаас авах боломжтой.

### **Замын аюултай хэсэг болон тэдгээрийг мэдээлэх**

Хурдны зам болон нэгдүгээр зэргийн авто зам дээрх аюултай хэсгүүд нь ихэвчлэн цаг агаарын таагүй байдал болон зам-тээврийн ослоос шалтгаалан үүсдэг. Авто зам дээо аюултай хэсэг үүсгэж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд орон нутгийн замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс эдгээр аюултай хэсгүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн албан ёсны вэб сайтад, радио, мэдээ, зарлал хэлбэрээр байршуулна.

### **Төлбөр төлөх аргууд**

- Үйлчилгээний бүсүүд: Ерөнхийдөө бэлэн мөнгө (юань) ашиглах бөгөөд хадгаламжийн Юнион Пэй карт (union pay), зарим тохиолдолд зээлийн (Виза, Мастер) картыг ашиглаж болно.

- Шатахуун түгээх цэгүүд: Ерөнхийдөө бэлэн мөнгө (юань) ашиглах бөгөөд хадгаламжийн Юнион Пэй карт (union pay), зарим тохиолдолд зээлийн (Виза, Мастер) картыг ашиглаж болно.

- Зочид буудлууд: Ерөнхийдөө бэлэн мөнгө (юань) ашиглах бөгөөд хадгаламжийн Юнион Пэй карт (union pay), зарим тохиолдолд зээлийн (Виза, Мастер) картыг ашиглаж болно.

### **Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто зам.**

#### **АН-3 чиглэлийн авто замын тухай**

Хилийн шалган нэвтрүүлэх Эрээн боомтоос Тангу хүртэл – 875.7 км;

G208 авто зам: Хилийн шалган нэвтрүүлэх Эрээн боомтоос Өөртөө засах орны мужийн Сөнидийн баруун хошуу хүртэл: 111.1 км;

G55 авто зам: Өөртөө Засах Орны мужийн Сөнидийн баруун хошуу – Улаанцав: 205.8 км;

G6 авто зам: Улаанцав – Жанжихахүү: 118.6 км;

G2 болон G3 авто зам: Бээжин – Тяньжин –Тангу: 150.1 км.

Хүснэгт 3. Азийн авто замын ангилал



<b>Замын нэр</b>	<b>Азийн авто замын ангилал</b>	<b>Эгнээний тоо</b>	<b>Замын нөхцөл байдал</b>
G208 улсын авто зам	Нэгдүгээр зэргийн зам	4 эгнээ	Сайн
G55 хурдны зам	Хурдны	4 эгнээ	Сайн
G6 хурдны зам	Хурдны	4 эгнээ	Сайн
G2 болон G3 хурдны зам	Хурдны	4 эгнээ	Сайн

### **Хилийн шалган нэвтрүүлэх Эрээн боомт**

Эрээн хот нь Өвөр Монголын Өөртөө Засах Орны хойд хэсэгт Монгол Улсын Замын-Үүд сумаас 9 км-ийн зайд оршдог. Эрээн хот нь G55 хурдны авто зам болон 208 дугаартай улсын авто замын эхлэлийн цэгт байрладаг. Энэ бол БНХАУ-ын авто зам болон төмөр замын хамгийн том зангилаа бөгөөд Евроазиар олон улсын болон дотоодын тээвэрлэлт гүйцэтгэхэд хамгийн тохиромжтой маршрут юм. Гаалийн байгууллагын ажлын цаг нь 08:30-18:00 байна.

### **Эрээн боомтын дэд бүтэц**

Эрээн хотод Ази дахь хамгийн том автомашины дугуйны агуулах болон Н986 галт тэрэгний хяналтын систем байрладаг. Энэ бол Хятадаас Европ руу хүрэх хамгийн дөт зам юм. Мөн энэ нь Жинингээс Эрээн / Эрээнхот чиглэлийн төмөр зам нь Жингбао, Жинсинглинийг холбохын зэрэгцээ Еврази болон Зүүн Европын хооронд төмөр замын гүүр болдог.

Эрээн хилийн боомтын дэд бүтцэд Rui International Mansion олон улсын үйлчилгээний төв, хамтарсан хяналт шалгалтын барилга, авто замын гарцтай төмөр замын буудал болон бусад барилга байгууламжууд багтдаг. Rui International Mansion энэ нь олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг 15040 м.кв талбай бүхий үйлчилгээний төв бөгөөд нийт талбай нь 18282 м.кв. Rui International Mansion-ний үйлчилгээний танхимд ачааны бүрдүүлэлт, санхүүгийн гүйлгээ, мэдээлэл солилцох үйлчилгээ болон бусад үйлчилгээний үйл ажиллагаа явагддаг. Барилгын нэгдүгээр давхарт экспорт болон импортын барааны бүрдүүлэлт хийгддэг; хоёр болон гуравдугаар давхарт төмөр замын буудлын оффис болон хяналт, хорио цээрийн товчоо, мөн гаалийн болон үйлчилгээний танхим байрладаг. Түүнчлэн энэ байранд зочид буудал байрладаг. Хяналт, шалгалтын шинэ барилгын талбай нь 343000 м.кв юм. Жилд нэвтрүүлэх ачааны хэмжээ нь 2.4 сая тонн, харин жилд нэвтрэх зорчигчийн тоо 3 сая хүн. Үндсэн байгууламжид 3889 м.кв талбайн бүхий хяналтын байр, 274 м.кв талбай бүхий гаалийн хяналтын бүс, 534 м.кв талбай бүхий ачааны мэдүүлгийн байр, 2100 м.кв талбай бүхий хилийн хяналт, шалгалтын ажилтнууд байрлах байр болон авто зам руу орох хяналтын бүс багтдаг.

*Гаалийн бүрдүүлэлтийн байр:* Хилийн хорио, цээрийн үзлэгийн бүсэд хорио, цээрийн цонх байрлуулсан бөгөөд орж ирж буй тээврийн хэрэгслийг

халдваргүйжүүлэх үүрэгтэй; хилийн хяналтын цэгт орж ирж хүн, тээврийн хэрэгслийг шалгах үүрэгтэй хяналтын бүс байрладаг; орох болон гарах хэсэгт хилийн хяналт, хорио цээрийн болон гаалийн бүрдүүлэлт хийх нийт 6 цонх байрладаг. Түүнчлэн энд гаалийн хяналтын Н986 системээр тоноглогдсон бүс байрладаг бөгөөд энэ нь орж ирж буй болон гадагш гарч буй тээврийн хэрэгслийг шалгах үүрэгтэй.

*Мэргэжлийн тоног төхөөрөмж:* хорио, цээрийн бүс нь халдваргүйжүүлэлтийн автомат тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг; хилийн шалган нэвтрүүлэх цэг нь хүн болон ачааг шалгах рентген аппарат, паспорт шалгах төхөөрөмж, хүний биеийн үзлэг болон бусад хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг.

Хилийн шалган нэвтрүүлэх цэг нь тэсэрч дэлбэрэхээс хамгаалах багаж хэрэгслээр, гааль нь ачааг шалгах рентген аппаратаар, хорио, цээрийн бүс нь ерөнхий температур хэмжих автомат мэрэгчээр тоноглогдсон байна. Тээврийн хэрэгслийн орох болон гарах хэсэг нь компьютерийн сүлжээгээр холбогдсон, гаалийн бүс нь электрон жин хэмжигчээр тоноглогдсон, үйл ажиллагааны удирдлагын хэсэг нь тээврийн хэрэгслийн бодит(тухайн үеийн) цагийн хөдөлгөөний хянах системээр тоноглогдсон байдаг.

Хүснэгт 4. Хилийн боомтын хяналт, шалгалтын үйл ажиллагаа

№	Хяналтын байгууллага	Хяналтын агуулга	Төлбөр, хураамж
1	Тээврийн эрх бүхий байгууллага	<ol style="list-style-type: none"> <li>1. Тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичиг</li> <li>2. Ачааны дагалдах хуудас</li> <li>3. Албан даатгалын гэрчилгээ</li> <li>4. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ</li> <li>5. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар</li> <li>6. Тээврийн хэрэгслийн хяналтын гэрчилгээ</li> <li>7. Улсын таних тэмдэг</li> <li>8. Бусад холбогдох баримт бичгүүд</li> </ol>	
2	Хяналт шалгалт ба хорио цээр	<ol style="list-style-type: none"> <li>1. Тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлт</li> <li>2. Тээврийн хэрэгслийн жинлэх</li> </ol>	<p>Нэг тээврийн хэрэгсэл 80 юань (намар, өвөл)                      Нэг тээврийн хэрэгсэл 60 юань (хавар, зун)</p>
3	Гааль	<ol style="list-style-type: none"> <li>1. Ачааны хяналт</li> <li>2. Тээврийн хэрэгсэл ба багийн үзлэг</li> <li>3. Ачааг чөлөөлөх</li> </ol>	

4	Гадаадын иргэн, харьяат	1. Паспортад тэмдэг дарах 2. Тээврийн хэрэгслийн үзлэг	
---	-------------------------	---	--

### **Хилийн шалган нэвтрүүлэх Эрээн боомтын гаалийн бүрдүүлэлтийн үндсэн үе шатууд**

#### **Гадаадын иргэн, харьяатын албаны бүрдүүлэлтийн процесс**

- (1) Хилээр нэвтрэн орох тээврийн хэрэгслийг хил нэвтрэхээс нь өмнө хилийн гадна халдваржуулалт хийнэ;
- (2) Хилээр орсны дараа тээврийн хэрэгсэл болон багийн гишүүд хяналтын үйл ажиллагааны шат болгонд нэгэн зэрэг хяналтаар ордог;
- (3) Тээврийн хэрэгсэл болон багийн гишүүдийн хяналт, шалгалтын ажлыг хуулиар тогтоосон хугацааны дагуу хийгддэг.

#### **Гарахад хийгдэж гаалийн бүрдүүлэлт:**

- (1) Хилээр гарч буй тээврийн хэрэгсэл болон багийн гишүүд нь хил гарахаас өмнө тээвэрлэн гарч буй ачааг хяналтын ерөнхий танхимд байрлах мэргэжлийн хяналтын байгууллагаар бүртгүүлж, баталгаажуулна.
- (2) Хяналтын шат болгонд тээврийн хэрэгслийн болон багийн бүрдүүлэлт хяналтын битүү талбайд нэгэн зэрэг явагдана.
- (3) Хилээр гарч буй тээврийн хэрэгсэл болон багийн гишүүдийн хяналт, шалгалтын ажлыг хуулиар тогтоосон хугацааны дагуу хийгддэг.

#### **АН-3 авто замын дагуух ослын болон тусламж үзүүлэх газрууд**

Маршрутын дагуу автомашины зогсоол, супермаркет, хооллох, амрах байр, шатахуун түгээх станц болон авто засварын газар гэх мэт үйлчилгээг багтаасан үйлчилгээний бүсүүд байрладаг.

Эрээн хотоос Тангу хүртэлх АН-3 авто замын дагуу 17 үндсэн үйлчилгээний бүс болон 119 шатахуун түгээх станц байрладаг.

Хүснэгт 5. АН-3 авто замын дагуух үйлчилгээний бүсүүдийн жагсаалт:

<b>№</b>	<b>Үйлчилгээний бүс</b>	<b>Газар зүйн байршил</b>	<b>Авто зам дагуух байршил (км)</b>
G55, Сөнидийн баруун хошуу – Улаанцав			
1	Үйлчилгээний бүс Шилин	Шилин баруун хошуу, Шилийн гол	155-156
2	Үйлчилгээний бүс Чангсванван	Улаанцав хот, Чахар баруун хошуу	239-240
3	Үйлчилгээний бүс Байннао	Улаанцав хот, Чахар баруун хошуу	277-278

4	Үйлчилгээний бүс Жинин	Улаанцав хот, Чахар баруун хошуу	76
<b>G6, Улаанцав – Жанжхүү</b>			
5	Үйлчилгээний бүс Сингхэ	ӨМӨЗО-ны Улаанцав хот, Сингхэ дүүрэг	284
<b>G6, Жанжхүү - Бээжин</b>			
6	Үйлчилгээний бүс Хуаянь	Хэбэй муж, Жанжихүү хот, Хуаянь дүүрэг	218
7	Жанжхүү үйлчилгээний бүс	Хэбэй мужийн Жанжихүү хот, Ван Куан дүүрэг	188
8	Үйлчилгээний бүс Гуантин	Хэбэй мужийн Жанжихүү хот, Хуайлай дүүрэг	87
<b>G2 болон G38 Бээжин - Тяньжин</b>			
9	Үйлчилгээний бүс Мацзюйциа	Бээжин, дүүрэг, Мацзюй гүүрний зам	12
10	Үйлчилгээний бүс Хугуанцун	Тунчжоу, Уцин дүүрэг	73
11	Үйлчилгээний бүс Донгли	Тунчжоу, Донгли дүүрэг	115

Хүснэгт 6. АН-3 авто замын дагуух шатахуун түгээх станциудын жагсаалт:

№	Шатахуун түгээх станц, эсхүл цэнэглэх станцын нэр	№	Шатахуун түгээх станц, эсхүл цэнэглэх станцын нэр
<b>G55 (хурдны), Сонид баруун хошуу-Улаанцав</b>		<b>G6 (хурдны), Жанжхүү-Бээжин</b>	
1	“Чайна петролиум” ШТС (Сонид баруун хошууны ойролцоо)	19	Дүүргийн “Чайна петролиум” ШТС
2	“Чайна ойл Шилин” ШТС	20	Автомашин цэнэглэх газар (Албан ёсны үйлчилгээний бүс)
3	Чангсванван “Чайна петролиум” ШТС	21	“Чайна петролиум” ШТС (Бадалин хот, Сибоцзы тосгон)
4	Байннао “Чайна петролиум” ШТС	22	Автомашин цэнэглэх станц (“Байге” үйлчилгээний бүс)
5	Хуангячун “Чайна петролиум” ШТС	23	“Чайна петролиум” ШТС
<b>G6 (хурдны), Улаанцав-Жанжхүү</b>		24	“Чайна петрохимикал Тотал” Чангпинг
6	Сингхэ “Чайна петролиум” ШТС	25	“Чайна петролиум” ШТС (Хуйлонггуан)
<b>G6 (хурдны), Жанжхүү-Бээжин</b>		26	Автомашин цахилгаанаар цэнэглэх шинэ станц
7	“Чайна петрохимикал Хуайань” ШТС	27	Цахилгаанаар цэнэглэх Star станц (Сисанци үйлчилгээний бүс)

8	Хуайань дүүргийн улсын шатахуун түгээх станциудын сүлжээ	28	“Чайна петролиум” ШТС (Сисанци үйлчилгээний бүс)
9	Юйалианг үйлчилгээний бүс дэх “Синопек” ШТС	29	“Чайна петролиум” ШТС (өмнөд Сисанци)
10	Пингоюань ШТС	30	“Чайна петролиум” Жонгту энерги Мейтуо ШТС
11	Жанжхүү үйлчилгээний бүс дэх “Чайна петрохимикал” ШТС	31	Ляньжуань цахилгаанаар цэнэглэх станц
12	Жанжхүү улсын шатахуун түгээх станциудын сүлжээ	32	Бээжин Ваньтун Хенгай автомашиныг цахилгаанаар цэнэглэх станц
13	Телайдан ШТС	33	Бээжингийн автомашин цахилгаанаар цэнэглэх станц
14	“Чайна ойл гарден” ШТС	34	G2, G3 (Өндөр хурдны) ба S40, Бээжин-Тяньжин-Тангу
15	“Да хуа ойл” хийгээр цэнэглэх станц	35	Мацзюй бридж үйлчилгээний бүсэд байрлах анхны үндэсний шатахуун түгээх станцын сүлжээ
16	Хуайлай дүүргийн хийгээр цэнэглэх станц	36	Майн бридж үйлчилгээний бүсэд байрлах “Чайна петрохимикал” хийгээр цэнэглэх станц
17	Шижяжуан Хуайлай мужийн цэргийн цахилгаан станц	37	Си тосгоны худалдааны бүсэд байрлах “Чайна петрохимикал” хийгээр цэнэглэх станц
18	Чайна петролиум Хуаган хийгээр цэнэглэх станц		

Хүснэгт 7. АН-3 авто замын дагуух эмнэлгийн жагсаалт

Муж	Дүүрэг	Эмнэлгийн байгууллага	Хаяг	Утасны дугаар
Өвөр Монголын Өөртөө Засах Орон	Хөх хот	Өвөр Монголын Анагаахын коллежийн эмнэлэг	Хөх хот, Хойд гудамж, 1	0471-6636643
		Өвөр Монголын эмнэлэг	Хөх хот, Синчен дүүрэг, Жауда роуд, 20	0471-6620907
		Өвөр Монголын Өөртөө Засах Орны	Хөх хот, Синчен дүүрэг, Эрүүл	0471-6921203

	Монголын анагаах ухааны их сургууль	мэндийн гудамж, 11	
	Хөх хот, Сайхан дүүргийн Эмнэлэг	Хөх хот, Жауда роуд, 394	0471-4341647
Хөлөнбуйр хот	Өвөр Монголын ойн эмнэлэг	Фанши хот, Линченг роуд, 81	0471-12320
	Шинэ барга баруун хошууны эмнэлэг	Синюци, Шинэ барга баруун хошуу	0470-6402284
	Хөлөнбуйрын ардын эмнэлэг	Хөлөнбуйр, Хайлаар, Ялалтын гудамж	0470-8254159
Эрээн хот	Эрээн хотын эмнэлэг	Эрээн хот, Ситньхуа	0479-7521304
Шилийн гол	Үзэмчин хошууны эмнэлэг	Үзэмчин хошууны	0479-3222667
	Шилийн хот эмнэлэг	Шилийн хот, Нада гудамж, 9	0479-8224941
	Баруун үзэмчин хошууны ардын эмнэлэг	Улиастай хот, Баруун үзэмчин Донг	0479-3222604
Баяннуур	Баяннуурын эмнэлэг	Линхэ хот, Синьхуа дүүрэг, Барууны гудамжны 35 тоот	0478-8414419
	Төвийн хошууны ардын эмнэлэг	Баяннуурын дундын хошууны Урад	0478-5912586
Баотоу хот	Өвөр Монголын хойд эмнэлэг	Өвөр Монголын Баотоу хот, Чиншан дүүрэг, Нэгдсэн гудамжны 16 тоот	0472-2166120

		Өвөр Монголын Анагаах Ухааны Коллежийн гурав дахь харьяа эмнэлэг	Өвөр Монголын Баотоу хот, Күн дүүрэг, Шаоксианы зам №20	0472-5992834
		Баотоу хотын төв эмнэлэг	Баотоу хот, Донгэ дүүрэг, Хуанжэнгийн зам №61	0472-6955333
	Альшаа	Альшаагийн төв эмнэлэг	Өвөр Монголын Зүүн хошуу, Альшаа, Баруун эпут, №28	0483-8335054
		Альшаагийн ардын эмнэлэг	Эльют Баянхотын Таун роуд	0483-8332831
		Эзний хошууны эмнэлэг	Эзний хошууны Парк роуд	0483-6525665

Хүснэгт 8. АН-3 авто замын дагуух галын ангиудын жагсаалт:

№	Нэр	Хаяг
<b>G55 (хурдны), Сонидын баруун хошуу - Улаанцав</b>		
1	Сайхантал хотын гал түймэртэй тэмцэх хэсэг	Шилийн гол, Шилийн баруун хошуу, Сайхантал хот, Баолига гудамж
2	Жинин дүүргийн гал түймэртэй тэмцэх хэсэг	Чахарын баруун урдын хошуу, Улаанцав хот, Хойд Куаншан роуд
<b>G6 (хурдны), Улаанцав – Жанжхүү</b>		
3	Сэнгхэ дүүргийн гал түймэртэй тэмцэх хэсэг	Өвөр Монголын Өөртөө Засах Орны Улаанцав хот, Сэнгхэ дүүрэг, Сингда замын зүүн талд
<b>G6 (хурдны), Жанжхүү - Бээжин</b>		
4	Жанжхүү хотын гал түймэртэй тэмцэх хэсэг	Хэбэй мужийн Жанжхүү хотын Шеньхуа замын зүүн талд
<b>G2, G3 (хурдны) болон G40, Бээжин – Тяньжин – Тангу</b>		
5	Майжюйцяогийн гал түймэртэй тэмцэх хэсэг	Бээжин, Тунчжоу дүүрэг, Чинхай зам
6	Цюаньчжоугийн зам дээрх галын хэсэг	Тяньжин, Уцин дүүрэг, Йонг Янг зам

7	Донгли нуур дахь галын станц	Жинжонгын зам, Дунли дүүрэг, Тяньжин
---	------------------------------	--------------------------------------

**Авто замын төлбөр:**

Авто замын төлбөрийн хэмжээг зай болон тээврийн хэрэгслийн жингээс хамааруулан тогтоодог.

Ачааны автомашины жингээс хамааруулан хурдны авто зам, нэгдүгээр зэрэглэлийн төлбөртэй авто зам, гүүр болон туннелиэр зорчсон төлбөрийг тооцож авдаг.

Хүснэгт 9. Өвөр Монголын Өөртөө Засах Орны нутаг дэвсгэрт нэгдүгээр ангиллын төлбөртэй замаар зорчсон ачааны автомашинаас авах төлбөрийн ангилал, хураамжийн хэмжээ:

Ангилал	Тодорхойлолт	Төлбөрийн хэмжээ
		(юань) (авто/км)
I	≤2 тонн	15
II	2-5 тонн	20
III	5-10 тонн	30
IV	10-15 тонн, 20 футийн чингэлэг тээвэрлэгч	40
V	15-25 тонн, 40 футийн чингэлэг тээвэрлэгч	50
VI	25 тонноос их (хэтэрсэн тонн тутамд)	2

Хүснэгт 10. Өвөр Монголын Өөртөө Засах Орны нутаг дэвсгэрт хурдны замаар зорчиход төлөх төлбөрийн ангилал, хураамжийн хэмжээ:

Ангилал	Тодорхойлолт	Төлбөрийн хэмжээ
		(юань) (авто/км)
I	≤2 тонн	0.4
II	2-5 тонн	0.6
III	5-10 тонн	0.85
IV	10-15 тонн, 20 футын чингэлэг тээвэрлэгч	1.1
V	15-25 тонн, 40 футын чингэлэг тээвэрлэгч	1.3
VI	25 тонноос их (хэтэрсэн тонн тутамд)	0.1

Хүснэгт 11. Хэбэй мужийн нутаг дэвсгэр дэх хурдны замаар зорчиход төлөх төлбөрийн ангилал, хураамжийн хэмжээ:

Ангилал	Тодорхойлолт	Төлбөрийн хэмжээ
---------	--------------	------------------



		(юань) (авто/км)
I	≤2 тонн	0.4
II	2-5 тонн	0.7
III	5-10 тонн	1.1
IV	10-15 тонн, 20 футийн чингэлэг тээвэрлэгч	1.32
V	15-25 тонн, 40 футийн чингэлэг тээвэрлэгч	0.08

Хүснэгт 12. Бээжин хотод хурдны замаар зорчиход төлөх төлбөрийн ангилал, хураамжийн хэмжээ:

Ангилал	Тодорхойлолт	Төлбөрийн хэмжээ
		(юань) (авто/км)
I	≤2 тонн	0.5
II	2-5 тонн	1
III	5-10 тонн	1.5
IV	10-15 тонн, 20 футийн чингэлэг тээвэрлэгч	1.8
V	15-25 тонн, 40 футийн чингэлэг тээвэрлэгч	2

Хүснэгт 12. Тяньжинд хурдны замаар зорчиход төлөх төлбөрийн ангилал, хураамжийн хэмжээ:

Ангилал	Тодорхойлолт	Төлбөрийн хэмжээ
		(юань) (авто/км)
I	≤2 тонн	0.31
II	2-5 тонн	0.44
III	5-10 тонн	0.57
IV	10-15 тонн, 20 футийн чингэлэг тээвэрлэгч	0.75
V	15-25 тонн, 40 футийн чингэлэг тээвэрлэгч	0.75

#### **Төлбөр төлөх аргууд:**

- Хурдны авто замуудын төлбөр төлөх цэгүүд: бэлэн мөнгөөр (юань), эсхүл замын төлбөрийн цахим картаар
- Нэгдүгээр зэргийн авто зам: зөвхөн бэлэн мөнгөөр (юань).

#### **Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто зам (АН-4)**

#### **АН-4 авто замын талаарх мэдээлэл**

Такашикен боомт – Үрэмчи – Хонгираф - 2320.2 км

320 дугаар авто зам: Такашикен боомт – Фуюнь - 138.3 км

G216 дугаар авто зам: Фуюнь – Үрэмчи – 436.9 км

314 дүгээр авто зам: Үрэмчи – Кашгар – 1451 км

314 дүгээр авто зам: кашгар – Хонгираф – 294 км.

Хүснэгт 14: Азийн авто замын ангилал

<b>Замын нэр</b>	<b>Ангилал</b>	<b>Эгнээний тоо</b>	<b>Замын нөхцөл байдал</b>
320 (мужийн)	1-р ангилал	4 эгнээ	Сайн
216 (улсын)	1-р ангилал	4 эгнээ	Сайн
314 (улсын)	1-р ангилал	4 эгнээ	Сайн

#### **Такашикен хилийн шалган нэвтрүүлэх боомт**

Такашикен боомт нь Хятад, Монголын хоорондох хил дээр байрладаг бөгөөд жилд 50000 тонн ачаа болон 30000 зорчигч нэвтрүүлэх хүчин чадалтай. Одоогийн байдлаар Такашикен боомт нь жилийн турш ажилладаг. Ажлын цаг нь 10:00-14:00, 15:00-19:00 цаг байна.

#### **Такашикен боомтын дэд бүтэц**

Такашикен боомтод нэгдсэн оффис, 2222 квадрат метр талбай бүхий хүлээн авах байгууламж, 350 квадрат талбай бүхий хамтарсан хяналт, шалгалтын танхим болон бусад байгууламжууд байрладаг. Дэд бүтцэд: хяналтын байгууллагын оффис болон хурлын танхим, зорчигч нэвтрэх бүс, татваргүй барааны дэлгүүр, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх бүс, хилийн хорио, цээрийн хяналтын бүс, хоолны газар, амрах хэсгийг багтаасан үйлчилгээний бүс болон хяналтаар орох гэж хүлээж буй зорчигчдод зориулсан хүлээлгийн танхим багтана. 2.16 Га талбай нь тээврийн үйлчилгээнд зориулагдсан бөгөөд үүнд тээврийн хэрэгслийн орох, гарах хаалга, үзлэгийн талбай болон зогсоол гэх мэт байгууламжууд багтдаг. Боомт нь нээгдсэн цагаасаа хойш 340000 зорчигч, 61000 тээврийн хэрэгслийг бүрдүүлэлт хийсэн байна. Такашикен боомт Монгол Улстай хил залгаж буй хоёр дахь том гарц бөгөөд Шинжиан Уйгарын Өөртөө Засах Орны хувьд Монгол Улстай хил залгаж буй хамгийн том боомт юм.

*Гаалийн бүрдүүлэлтийн цэг:* хорио, цээрийн хяналтын бүсэд орж ирж буй тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх цэг байрладаг; түүнчлэн хилээр орж ирж буй хүмүүс болон тээврийн хэрэгслийг шалгах үзлэгийн бүс байрладаг; нэгдсэн хяналтын танхимын орох хэсэгт зорчигчид орох болон гарах хоёр коридор байдаг. Коридор болгонд хилийн хяналтад зориулсан 4 цонх, гаалийн хоёр пост болон хорио, цээрийн хоёр цонх байрладаг. Хамтарсан хяналт шалгалтын танхимын

хойд болон урд талд орж, гарч буй тээврийн хэрэгсэлд үзлэг хийх танхим, албан байртай хяналтын бүс байрладаг бөгөөд тэр бүгдэд гаалийн хорио, цээрийн цэг, хилийн болон тээврийн хяналт шалгалтын цэгүүд хийгдсэн; Хилийн боомтын баруун талд гаалийн хяналтын Н986 систем байрладаг бөгөөд тэр нь орж, гарч буй тээврийн хэрэгслийн хяналтыг хариуцдаг.

*Мэргэжлийн хяналтын тоног төхөөрөмж:* хорио, цээрийн бүс нь шүрших төрлийн сувган халдваргүйжүүлэлтийн автомат тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг; хилийн шалган нэвтрүүлэх цэг нь хүн болон ачааг шалгах рентген аппарат, паспорт шалгах төхөөрөмж, хүний биеийн үзлэг болон бусад хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг. Хилийн шалган нэвтрүүлэх цэг нь дэлбэрэлтээс хамгаалах багаж хэрэгслээр, гааль нь ачааг шалгах рентген аппаратаар, хорио, цээрийн бүс нь ерөнхий температур хэмжих автомат мэрэгчээр тоноглогдсон байна. Тээврийн хэрэгслийн орох болон гарах хэсэг нь компьютерийн сүлжээгээр холбогдсон, гаалийн бүс нь электрон жин хэмжигчээр тоноглогдсон, үйл ажиллагааны удирдлагын хэсэг нь тээврийн хэрэгслийн бодит(тухайн үеийн) цагийн хөдөлгөөний хянах системээр тоноглогдсон байдаг бөгөөд Такашикен боомтоос цааш 14 км-ийн зайд 50 м тутамд олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын Н986 системийн мэдрэгчүүд суурилагдсан байдаг.

### **Хилийн шалган нэвтрүүлэх Хонгираф боомт (Хонгираф дүүрэг)**

Хонгираф боомт нь Пакистан Улстай хиллэдэг хятадын Шинжиан-Ташкурғаны Таджикийн автономт мужийн Кашгар дүүрэгт 4733 м-ийн өндөрт байрладаг. Нэгдүгээр зэрэглэлийн энэхүү боомт нь БНХАУ болон Пакистаныг холбодог үндсэн тээврийн зангилаа төв юм. Энэ нь Ташкурған хотоос 130 км, Кашгар хотоос 420 км, Үрэмчи хотоос 1890 км-т хятадын хил дээр байрладаг. Хонгираф хилийн боомт нь улирлын чанартай боомт юм. Хятад болон Пакистаны хооронд байгуулсан хоёр талт хэлэлцээрийн дагуу цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан 4 дүгээр сарын 1-ээс 30-ны хооронд 24 цагийн турш ажилладаг.

### **Хонгираф хилийн боомтын дэд бүтэц**

Хонгираф боомтын үндсэн барилга, байгууламжид хил, гаалийн, хорио, цээрийн, мал, амьтны хорио, цээрийн алба болон бараа, бүтээгдэхүүний хяналтын цэг байрладаг. Хонгираф боомтын талбайд 10000 квадрат метр талбай бүхий хяналт, шалгалтын танхим байгуулагдсан; ус, цахилгаан, халаалт, харилцаа холбоо зэрэг нь ерөнхийдөө бүх хэрэгцээг хангадаг.

*Гаалийн бүрдүүлэлтийн цэг:* хорио, цээрийн хяналтын бүсэд орж ирж буй тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх цэг байрладаг; түүнчлэн хилээр орж ирж буй хүмүүс болон тээврийн хэрэгслийг шалгах үзлэгийн бүс байрладаг; нэгдсэн хяналтын танхимын орох хэсэгт зорчигчид орох болон гарах 2 коридор байдаг. Коридор болгонд хилийн хяналтад зориулсан 2 цонх, гаалийн хоёр пост болон хорио, цээрийн 2 цонх байрладаг. Хамтарсан хяналт шалгалтын танхимын хойд болон урд талд орж, гарч буй тээврийн хэрэгсэлд үзлэг хийх танхим, албан байртай хяналтын бүс байрладаг бөгөөд тэр бүгдэд гаалийн хорио, цээрийн цэг, хилийн болон тээврийн хяналт шалгалтын цэгүүд хийгдсэн; Хилийн боомтын

хойд хэсэгт гаалийн хяналтын Н986 систем байрладаг бөгөөд тэр нь орж, гарч буй тээврийн хэрэгслийн хяналтыг хариуцдаг.

*Мэргэжлийн хяналтын тоног төхөөрөмж:* чингэлэгт тээвэрлэж буй ачаа, барааг шалгах зорилгоор гаалийн хяналтын компьютерчлагдсан Н996 систем ашигладаг; хорио, цээрийн бүс нь шүрших хэлбэрийн сувган халдваргүйжүүлэлтийн автомат тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг; хилийн шалган нэвтрүүлэх цэг нь хүн болон ачааг шалгах рентген аппарат, паспорт шалгах төхөөрөмж, хүний биеийн үзлэг болон бусад хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг. Хилийн шалган нэвтрүүлэх цэг нь дэлбэрэлтээс хамгаалах багаж хэрэгслээр, гааль нь ачааг шалгах рентген аппаратаар, хорио, цээрийн бүс нь ерөнхий температур хэмжих автомат мэргэчээр тоноглогдсон байна. Тээврийн хэрэгслийн орох болон гарах хэсэг нь компьютерийн сүлжээгээр холбогдсон, гаалийн бүс нь электрон жин хэмжигчээр тоноглогдсон, үйл ажиллагааны удирдлагын хэсэг нь тээврийн хэрэгслийн бодит(тухайн үеийн) цагийн хөдөлгөөний хянах системээр тоноглогдсон байдаг бөгөөд Такашкен боомтоос цааш 14 км-ийн зайд 50 м тутамд олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын Н986 системийн мэдрэгчүүд суурилагдсан байдаг.

Хүснэгт 15. Хилийн боомтын хяналт, шалгалтын үйл ажиллагаа

№	Хяналтын байгууллага	Хяналтын агуулга	Төлбөр, хураамж
1	Тээврийн эрх бүхий байгууллага	<ol style="list-style-type: none"> <li>1. Жолооны үнэмлэх</li> <li>2. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ</li> <li>3. Тээвэрлэгчийн гэрчилгээ</li> <li>4. Тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичиг</li> <li>5. Ачааны дагалдах хуудас</li> <li>6. Тооцооны хуудас</li> <li>7. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар</li> <li>8. Маршрутын самбар</li> <li>9. Тээврийн хэрэгслийн овор хэмжээ</li> </ol>	
2	Хяналт шалгалт ба хорио цээр	<ol style="list-style-type: none"> <li>1. Triplicate form</li> <li>2. Тээврийн хэрэгслийн хорио цээрийн хуудас</li> </ol>	Гаалийн бүрдүүлэлтийн хураамж
3	Гааль	<ol style="list-style-type: none"> <li>1. Triplicate form</li> <li>2. Паспорт</li> <li>3. Нэвтрэх карт</li> </ol>	
4	Гадаадын иргэн, харьяат	<ol style="list-style-type: none"> <li>1. Хяналтын мэдүүлгийн маягт</li> <li>2. Цэцэрлэгийн хэлбэр</li> <li>3. Экспресс карт</li> </ol>	

## Хилийн шалган нэвтрүүлэх Эрээн боомтын гаалийн бүрдүүлэлтийн үндсэн үе шатууд

### Гадаадын иргэн, харьяатын албаны бүрдүүлэлтийн процесс:

- (1) Хилээр нэвтрэн орох тээврийн хэрэгслийг хил нэвтрэхээс нь өмнө хилийн гадна халдваржуулалт хийнэ;
- (2) Хилээр орсны дараа тээврийн хэрэгсэл болон багийн гишүүд хяналтын үйл ажиллагааны шат болгонд нэгэн зэрэг хяналтаар ордог;
- (3) Тээврийн хэрэгсэл болон багийн гишүүдийн хяналт, шалгалтын ажлыг хуулиар тогтоосон хугацааны дагуу хийдэг.

### Гарахад хийгдэж гаалийн бүрдүүлэлт:

- (1) Хилээр гарч буй тээврийн хэрэгсэл болон багийн гишүүд нь хил гарахаас өмнө тээвэрлэн гарч буй ачааг хяналтын ерөнхий танхимд байрлах мэргэжлийн хяналтын байгууллагаар бүртгүүлж, баталгаажуулна.
- (2) Хяналтын шат болгонд тээврийн хэрэгслийн болон багийн(экипаж) бүрдүүлэлт нь хяналтын битүү талбайд нэгэн зэрэг явагдана.
- (3) Хилээр гарч буй тээврийн хэрэгсэл болон багийн гишүүдийн хяналт, шалгалтын ажлыг хуулиар тогтоосон хугацааны дагуу хийдэг.

### АН-3 авто замын дагуух ослын болон тусламж үзүүлэх газрууд

Такашикен болон Хонгираф боомтуудыг холбосон АН-4 чиглэлийн авто замд 41 шатахуун түгээх станц, 135 хийгээр цэнэглэх станц байрладаг.

Хүснэгт 16: АН-4 чиглэлийн авто замын дагуух үйлчилгээний цэгүүдийн жагсаалт

№	Үйлчилгээний бүс	Газар зүйн байршил	Авто зам дагуух байршил (км)
<b>G216 дугаар авто зам: Фуюнь – Үрэмчи</b>			
1	“Colorful Bay” үйлчилгээний бүс	Чангжи Хуй автономит мужийн Жимассар хошуу	(S11) 22
2	Дахуаншань үйлчилгээний бүс	Чангжи Хуй автономит мужийн Фукан хот	(G216) 604
3	Фукан үйлчилгээний бүс	Чангжи Хуй автономит мужийн Фукан хот	G216) 604
<b>G314 дүгээр авто зам: Үрэмчи – Хонгираф</b>			
4	Токсун үйлчилгээний бүс	Туфан мужийн Тохан хошуу	(G3012) 33
5	Юссиактал үйлчилгээний бүс	Баянгол автономт мужийн Хешую хошуу	(G3012) 210
6	Янцы үйлчилгээний бүс	Баянгол автономт мужийн Янчи Хуй	(G3012) 286
7	Корла үйлчилгээний бүс	Баянгол автономт мужийн Баянгол хот, Корла	(G3012) 585

8	Шянсия үйлчилгээний бүс	Баянгол автономт мужийн Лунтай хошуу	(G3012) 470
9	Кугы үйлчилгээний бүс	Акесу дүүрэг, Кугы хошуу	(G3012) 585
10	Синхэ үйлчилгээний бүс	Лючиу Тан Тан хотхон	(G3012) 650
11	Гоатукуке үйлчилгээний бүс	Акесу дүүрэг, Синхэ хошуу	(G3012) 749
12	Шяму үйлчилгээний бүс	Акесу дүүргийн Вэньсу хошуу	(G3012) 825
13	Кухле үйлчилгээний бүс	Акесу дүүрэг, Акесу хот	(G3012) 883
14	Аква үйлчилгээний бүс	Акесу дүүргийн Кельпин хошуу	(G3012) 988
15	Санчакоу үйлчилгээний бүс	Каши мужийн Бачу хошуу, Three fork town	(G3012) 1083
16	Циркель үйлчилгээний бүс	Баруун Керр Кули хотхон	(G3012) 1174
17	Атух үйлчилгээний бүс	Киргизийн автономт дүүрэг, Атух	(G3012) 1258

Хүснэгт 17. АН-4 авто замын дагуух шатахуун түгээх станциудын жагсаалт:

№	Шатахуун түгээх станц, эсхүл цэнэглэх станцын нэр	№	Шатахуун түгээх станц, эсхүл цэнэглэх станцын нэр
<b>S320, Такашкен - Фуюнь</b>		<b>G314, Үрэмчи – Хонгироф</b>	
1	“Чайна петролиум” ШТС Цинхай	17	“Чайна петрохимикал” ШТС Токелсон
2	Кайюань боомт дахь ШТС	18	Чангсиний үйлчилгээ ШТС
3	“Петрочайна грин ривер” Агаобао ШТС	19	Хийгээр цэнэглэх станц “Синопек” (Кумиши дүүрэг)
<b>G216, Фуюнь – Үрэмчи</b>		20	“Чайна петрохимикал” Кумиши ШТС
4	Хийгээр цэнэглэх станц “Чукулту”, Фуюнь	21	Хийгээр цэнэглэх станц “Петрочайна” (Кумиши дүүрэг)
5	Хийгээр цэнэглэх станц “Карст”, Фуюнь	22	“ПетроЧайна” дахь талбайн Шинэ Хуалийн шатахуун цэнэглэх станц, Уршталын үйлчилгээний бүс
6	Хийгээр цэнэглэх станц Фенхуа Чангшун	23	Хийгээр цэнэглэх станц “CNOOC oil” Юссиактал
7	Хийгээр цэнэглэх станц “Петрочайна лаки”	24	Хийгээр цэнэглэх станц “Петрочайна”, Шуобэй үйлчилгээний бүс
8	ШТС Дахуаншань	25	Хийгээр цэнэглэх станц “Чайнапетрохимикал”, Янцы үйлчилгээний бүс
9	“Синопек”, Ганхези, дэд-гарц	26	“Чайнапетролиум” ШТС Корла үйлчилгээний бүс

10	“Синопек”, Фукан, дүүргийн хийн станц	27	Хийгээр цэнэглэх станц “Синопек” (Корла дүүрэг)
11	Шатахуун түгээх станц “Синопек”, Лонгюу	28	Хийгээр цэнэглэх станц “Синопек” (Корла дүүрэг)
12	Карсон булангийн баруун тал	29	Хийгээр цэнэглэх станц Ханьцзинь (Корла)
13	Шатахуун түгээх станц Хонгшунлонг	30	Хийгээр цэнэглэх станц “Чайна петролиум” Шанху
14	Шатахуун түгээх станц “Петрочайна шипинг”	31	Хийгээр цэнэглэх станц КорлаСипу
15	Хийгээр цэнэглэх станц Донгфу	32	шатахуун цэнэглэх станц КорлаСипу
16	Хийгээр цэнэглэх станц “Петрочайна Куньлунь”		

Хүснэгт 18. АН-4 авто замын дагуух эмнэлгийн жагсаалт

Муж	Дүүрэг	Эмнэлгийн байгууллага	Хаяг	Утасны дугаар
Шиньжан Уйгарын Өөртөө Засах Орон	Чихай муж	Чинхэ мужийн ардын эмнэлэг	№68 Френдшип урд зам, Алтай	0906-8821734
	Фукан хот	Фукан ардын эмнэлэг	Фукан дүүрэг, Нянхуа зам, 726 тоот	0994-3230370
	Үрэмчи хот	Шиньжан Уйгарын Өөртөө Засах Орны ардын эмнэлэг	Тянь-Шань хот, Тянь-Шань зам, 91 тоот	0991-8561965
	Токсун хошуу	Таксун хошууны ардын эмнэлэг	Турфан хот, Токсун хошуу, Ист гудамж	0995-8808305
	Корла хот	Корла хотын нэгдүгээр ардын эмнэлэг	Корла хот, Тянзциний урд зам, 10 тоот	0996-2052139
	Куга	Куга мужийн ардын эмнэлэг	Аксу, Куга муж, Цзефан зам, 16 тоот	0997-7137120
	Аксу хот	Аксу хотын нэгдүгээр ардын эмнэлэг	Шиньжан Уйгарын Өөртөө Засах Орон, Аксу хот, Ист гудамж, 14 тоот	0997-2132692
	Кашгар хот	Кашгар хотын Хоуп эмнэлэг	Айзирете зам, 220 тоот	0998-2929998

Хүсэнт 19: АН-4 авто замын дагуух галын хэсгүүд

№	Нэр	Хаяг
<b>G216, Фуюнь – Үрэмчи</b>		
1	Джимасар хошууны гал түймэртэй тэмцэх хэсэг	Чжижи Хуй автономит мужийн Жимсар хошууны Сюү зам
2	Фукан хотын гал түймэртэй тэмцэх хэсэг	Чэнжи Хуй автономит мужийн Фүкан хот, Зэнсинг баруун зам
<b>G314, Үрэмчи – Хонгираф</b>		
3	Дабанчэн дүүргийн гал түймэртэй тэмцэх хэсэг	Урумчи, Дабанчэн дүүргийн Шинэ хороолол, Хуучин Таун гудамж
<b>G6 (хурдны), Жанжхүү - Бээжин</b>		
4	Жанжхүү хотын гал түймэртэй тэмцэх хэсэг	Хэбэй мужийн Жанжхүү хотын Шеньхуа замын зүүн талд
5	Турпан хотын гал түймэртэй тэмцэх хэсэг	Турпан хот, Блэйез уулын зам
6	Хоршуд мужийн галын хэсэг	Баянгол, Монголын автономит муж, Хоршуд дүүрэг, Стоун өргөн чөлөө
7	Янчи Хуй автономит тойргийн галын хэсэг	Баянгол, Монгол автономит муж, Кайду голын авто зам, Янчи Хуй автономит тойрог
8	Баянгол хотын галын хэсэг	Баянгол, Монгол автономит муж, Баянгол хот, Сокраб зам
9	Аксу дүүргийн хотын галын хэсэг	Акесу дүүрэг, Чангжианы зам
10	Синхэ мужийн галын хэсэг	Синхэ дүүрэг, Акесу хот, Синхэ зам
11	Бачу хотын галын хэсэг	Бачу мужийн Кашгар дүүрэг, Гангминг хойд зам

### Авто замын төлбөр

Шиньжан Уйгарын Өөртөө Засах Орны (ШУӨЗО) хурдны замын ачааны тээврийн хэрэгслийн жинд суурилсан төлбөр.

Суурь үнэ: хурдны зам болон нэгдүгээр зэргийн авто зам 0.07 юань/тн\*км, хоёрдугаар зэргийн авто замд 0.05 юань/тн\*км, нэмэлт том гүүр, хонгилд 0.25 юань / тонн • км.

Өөр өөр зэрэглэлийн хурдны замуудаас бүрдсэн хурдны замуудын хувьд хурдны зам тус бүрээр зорчсон зайнаас хамааран тэдгээрийн хувийн жинд оногдоно. Олон зэрэглэлийн замаас бүрдсэн холимог замын суурь төлбөр нь өөр өөр зэрэглэлийн хурдны замуудын бүх суурь төлбөрийн жигнэсэн дунджаар тооцогдоно.

Бүх хууль ёсны бичиг, баримттай даацын хувьд стандартын шаардлага хангасан ердийн тээврийн хэрэгслийн хувьд (цаашид "ердийн тээврийн хэрэгсэл" гэх) хувьд дараах дүрмийн дагуу тээврийн хэрэгслийн жинд суурилсан төлбөрийн системийг дагаж мөрдөх болно.



Төлбөрийн суурь үнийг бүх жин (БЖ) нь 10 тонноос бага тээврийн хэрэгсэлд ашиглах бөгөөд нийт төлбөр нь жин болон замаар зорчсон зайнаас хамаарч бодогдоно. Бүх жин нь 4 тонноос бага тээврийн хэрэгслийн жинг 4 хүртэл тонноор бүхэлтгэнэ. Бүх жин нь 10 тонноос их 40 тонноос бага (40 тонн орно) тээврийн хэрэгслийн хувьд нийт төлбөр нь хоёр хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэг нь 10 хүртэл тонн бүхий бүх жинд төлбөрийн суурь түвшинг хэрэглэнэ. Хоёр дахь хэсэг нь 11 тоноос 40 тонн бүхий бүх жинд төлбөрийн суурь түвшингөөс эхлэх бөгөөд суурь үнээс шугаман байдлаар 50 хувь хүртэл бууруулна. Бүх жин нь 40 тонноос их тээврийн хэрэгслийн хувьд нийт төлбөр нь гурван хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэг нь 10 хүртэл тонн бүхий бүх жинд суурь үнийг хэрэглэнэ. Хоёр дахь хэсэг нь 11 тонноос 40 тонн бүхий бүх жинд суурь үнээс эхлэх бөгөөд суурь үнээс шугаман байдлаар 50 хувь хүртэл бууруулна. Гурав дахь хэсэг нь 40 тонноос их бүх жинд суурь үнийн 50 %-тай тэнцүү байна.

Хүснэгт 20: Жингээс хамааран энгийн тээврийн хэрэгсэлд зориулсан авто замын төлбөр

Бүх жин (БЖ) тонноор	Төлбөр (Юаниар)
Бүх жин $\leq 4$	Төлбөр I
Бүх жин $\leq 10$	Төлбөр I
$10 < \text{БЖ} \leq 40$	Төлбөр I + Төлбөр II
БЖ $> 40$	Төлбөр I + Төлбөр II + Төлбөр III

Тайлбар:

1. Энгийн тээврийн хэрэгсэл: Ачааны даацын хувьд стандартын шаардлагыг хангасан, тээврийн хэрэгсэл болон ачааны бүх холбогдох бичиг баримт бүрэн тээврийн хэрэгсэл;
2. Бүх жин: тээвэрлэж буй ачаа болон тээврийн хэрэгслийн нийт жин;
3. Бүх жин нь 4 тонноос бага тээврийн хэрэгслийн хувьд 4 тонн хүртэл бүхэлтгэнэ;
4. Төлбөр I: Бүх жин нь 10 тонноос бага (10 тонн орно) тээврийн хэрэгслийн хувьд суурь үнийг хэрэглэх бөгөөд нийт төлбөр нь жин болон явсан зайнаас хамаарч тооцогдоно;
5. Төлбөр II: Суурь үнээс эхлэх бөгөөд суурь үнээс шугаман байдлаар 50 хүртэл %-иар буурах бөгөөд нийт төлбөр нь явсан зай болон жингээс хамаарч тооцогдоно;
6. Төлбөр III: Суурь үнийн 50 %-тай тэнцэх бөгөөд нийт төлбөр нь явсан зай болон жингээс хамаарч тооцогдоно;
7. Ачааны автомашины ангилалд хамаарах фургон болон пикапын хувьд төлбөрийн хэмжээ нь жингээс хамаарч тооцогдоно.
8. Төлбөрийн хэмжээг тооцохын тулд 0.5-аас бага бүх аравтын бутархай хэсгийг хасч, 0.5-ыг оруулаад 0.5-аас дээш аравтын бутархай юанийг 1 юаниар бүхэлтгэж тооцно. 5 юаниас бага бүх төлбөрийг 5 юаниар тооцон авна.
9. Тээврийн хэрэгслийн бүх жингээс хамаарсан төлбөртэй авто замын хувьд бүх жинг тээврийн хэрэгслийг тээвэрлэж буй ачаатай хамт жинлэсэн бодит жингээр тооцно.

10.Төлбөр авах систем нь ажиллахгүй, тээврийн хэрэгслийн жинг хэмжих боломжгүй тохиолдолд түүний оронд тээврийн хэрэгслийн төрөл, ангиллаар тооцон төлбөр төлөх системд шилжүүлэн бодно.

#### **Төлбөр төлөх аргууд**

Авто зам дээрх төлбөр хураах цэгүүд: бэлнээр (юаниар) болон авто замын төлбөр төлөх цахим картууд.

Нэгдүгээр зэрэглэлийн авто зам: Зөвхөн бэлнээр (Юаниар).

## МОНГОЛ УЛС

### **Тээврийн эрх бүхий байгууллага**

**Автотээврийн тухай гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах, автотээврийн салбарын удирдлага зохион байгуулалтаар хангах, зөвшөөрөл олгох ажлыг хариуцах эрх бүхий байгууллага**

### **Зам, тээврийн хөгжлийн яам**

Зам, тээврийн хөгжлийн яам нь эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох чиглэлээр шийдвэр гаргадаг үндсэн байгууллага юм. Зам, тээврийн хөгжлийн яам нь авто зам, төмөр зам, далайн болон агаарын тээвэр зэрэг голлох тээврийн сүлжээг өргөжүүлэн сайжруулах, мөн түүнчлэн тээврийн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор тээврийн салбарын бодлого, төлөвлөлт болон эрх зүйн актыг боловсруулж, хэрэгжүүлдэг.

### **“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ (АТҮТ)**

“АТҮТ” ТӨҮГ нь Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх автотээврийн талаар бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит үйлдвэрийн газар юм. “АТҮТ” ТӨҮГ нь Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн дагуу улс хоорондын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийг олгох эрх олгогдсон байгууллага юм.

### **Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТМ)**

Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо нь тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын ачаа, зорчигч тээвэрлэлтийн бизнесийн үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, ашиг сонирхлыг хамгаалах, автотээврийн салбарын хууль, дүрэм, журам болон автотээврийн харилцааны тухай гэрээ, хэлэлцээр байгуулахад тээвэрчдийн санал бодлыг тусгах, мөн түүнчлэн Засгийн газартай харьцах харилцааг бататгах, тээвэрлэгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, олон улсын автотээврийн холбоодуутай хамтран ажиллах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо нь ТИР дэвтэр болон БНХАУ-аас бусад Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр бүхий улсууд руу олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийг олгодог эрх олгогдсон байгууллага юм.

### **Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх хамгийн их овор хэмжээ болон жингийн зохицуулалт**

Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх хамгийн их овор хэмжээ болон жингийн хэмжээг “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага. MNS 4598:2011” стандартаар тогтоосон. MNS 4598:2011 стандартад заасны дагуу ачааг тээвэрлэх явцад түүнийг бүрэн бүтэн, гэмтэлгүй хүргэх болон бороо,

цас, тоос, шороо зэрэг байгалийн бусад нөлөөллөөс хамгаалахаар сайтар битүүмжлэгдсэн, түргэн муудаж гэмтдэг хүнсний зүйлийг тээхэд илч тусгаарлагч битүү тэвштэй, эсхүл хөргөгч бүхий /рефрижератор/ битүү бүрхүүлтэй, овор ихтэй, хүнд, урт ачааг тээвэрлэхэд найдвартай бэхэлгээгээр хангасан байна.

Чиргүүл, хагас чиргүүл нь найдвартай тоормосны системээр тоноглогдсон байх бөгөөд гэрэлтүүлэх болон дохиоллын хэрэгсэл бүрэн ажиллагаатай байх, чиргүүл, хагас чиргүүлийн холбоос нь техникийн хувьд бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангасан байна.

Хүснэгт 21: Зөвшөөрөгдөх хамгийн их овор, хэмжээ

Хамгийн их оврын хэмжээ	Тээврийн хэрэгслийн төрөл	Үзүүлэлэт
Урт	Ачааны автомашин	12.00 м
	Угсраа тээврийн хэрэгсэл	18.75 м
Өргөн	Бүх төрлийн тээврийн хэрэгсэл	2.50 м
Өндөр	Бүх төрлийн тээврийн хэрэгсэл	4.00 м

Хүснэгт 22: Зөвшөөрөгдөх хамгийн их жин

Тээврийн хэрэгслийн төрөл	Жин
Хоёр голтой тээврийн хэрэгсэл	18.00 т
Гурван голтой тээврийн хэрэгсэл	25.00 т
Дөрвөн голтой тээврийн хэрэгсэл	38.00 т
Таван голтой тээврийн хэрэгсэл	40.00 т
Зургаан голтой тээврийн хэрэгсэл	44.00 т

Хүснэгт 23: Тэнхлэг дээрх хамгийн их ачаалал

Хөтлөх тэнхлэг	11.50 т
Хөтлөгдөх тэнхлэг	10.00 т

### **Овор хэмжээ болон жингийн хязгаарлалтыг хэтрүүлсэн зөрчилд оногдуулах торгуулийн хэмжээ**

Хилээр нэвтрэхэд ачааны жинг шалгадаг бөгөөд тээвэрлэж буй ачааны жин нь холбогдох баримт бичигт заасан хэмжээтэй тохирч байх ёстой.

Тээврийн хэрэгслийн бүх жин болон овор хэмжээ нь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд онцгой зөвшөөрөл авах шаардлагатай.

Дээрх овор хэмжээ, жингийн тогтоосон хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд үүнээс үүдэн гарсан хохирлыг тухайн этгээд төлөх бөгөөд дараах торгуулийг ногдуулна.

- a) Хувь хүн – 150000 төгрөг;
- b) Хуулийн этгээд – 1500000 төгрөг.

## **Авто зам дээрх хяналт, шалгалт**

Тээврийн цагдаагийн алба, хяналтын байцаагчид авто замаар олон улсын болон дотоодын тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийг шалгах эрхтэй.

АН-3 болон АН-4 чиглэлийн авто замын хэсгүүдэд тээврийн хэрэгслийг жинлэх (пүүлэх) байнгын ажиллагаатай постууд ажилладаг бөгөөд цаашид хэд хэдэн цэгт байнгын ажиллагаатай жин хэмжих хяналтын цэг байгуулахаар төлөвлөж байна.

Авто замын тухай хуулийн 29.3.5 дахь хэсэгт “тусгай хамгаалалтгүй, эсвэл зөвшөөрөлгүйгээр гинжит болон тухайн авто замын үзүүлэлтээс хэтэрсэн овор, хэмжээ, даацтай тээврийн хэрэгсэл зорчуулах” гэж, 23.3.7 дахь хэсэгт “авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор, даацтай болон тусгай хамгаалалтгүй гинжит дугуйтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих” гэж заасан.

## **Овор хэмжээ ихтэй болон хүнд даацын тээврийн хэрэгслийн зохицуулалт**

Овор хэмжээ ихтэй болон хүнд жинтэй ачаа тээвэрлэлт нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явагддаг.

Овор хэмжээ ихтэй ачаа гэж тээврийн хэрэгслийн ачаатай үеийн овор хэмжээ (урт, өргөн, өндөр) нь авто замаар хөдөлгөөнд оролцоход зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн ачааг хэлнэ.

Хүнд жинтэй ачаа гэж тээврийн хэрэгслийн бүх жин, эсхүл тэнхлэг дээрх ачаалал нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тогтоосон хэмжээнээс хэтэрсэн ачааг хэлнэ.

Дээр дурдсан ачааг тээвэрлэхэд онцгой зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд зөвшөөрөлд тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл болон ачааны хэмжээ, үзүүлэлт, түүнчлэн шаардлагатай бол тээврийн маршрутыг багтаасан тусгай хөдөлгөөн зохицуулалтын талаарх мэдээллийг тусгасан байна.

## **Аюултай ачааны тээвэрлэлтэд тавих шаардлага**

Монгол Улсын нутаг дэвсгэрт аюултай ачааны тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь Зам, тээврийн сайдын тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”, “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага. MNS 4978” стандарт болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулдаг.

Аюултай ачааны тээвэрлэлтийг тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл болон аюултай ачаа тээвэрлэхэд зориулж тусгай тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

Тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хортой болон халдвар тараах бодис зэрэг аюултай ачааг тээвэрлэхэд 5 болон түүнээс дээш тээврийн хэрэгслийн цуваагаар

явж болох бөгөөд цувааг тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоногдсон автотээврийн хэрэгсэл хамгаалан явж болно.

### **Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл**

Монгол Улсын нутаг дэвсгэрт аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл авахад аюултай ачааны төрөл, ангиллаас хамаарч холбогдох яам болон Цагдаагийн байгууллагад хандана.

### **Аюултай ачаа тээвэрлэлт**

Аюултай ачаа тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийн урд болон ард "Аюултай ачаа" таних тэмдгийг байрлуулна. "Аюултай ачаа" таних тэмдэг нь хар хүрээтэй (өргөн нь 15 мм), 700 мм х 300 мм хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэртэй байна.

Улс хооронд аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийг байнга тээврийн хэрэгсэлд авч явна.

АН-3 болон АН-4 чиглэлийн авто замаар Монгол Улсын нутаг дэвсгэрт аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх нь маш эрсдэлтэйд тооцогддог. Учир нь энэхүү авто замууд хүн ам ихээр суурьшсан суурин газрууд болон хол зайтай бөгөөд ямар нэгэн осол аваарын үед хурдан шуурхай тусламж үзүүлэх боломж хязгаарлагдмал юм.

### **Жолоочийн ажил, амралтын хугацааны зохицуулалт**

Зам, тээврийн сайдын 2015 оны 339 дүгээр тушаалаар "Жолоочийн хөдөлмөр, амралтын дэглэмийг мөрдөх тухай зөвлөмж"-ийг баталсан. Энэхүү зөвлөмжийг хотын доторх, олон улсын болон хот хоорондын ачаа, зорчигчийн тээвэрлэлт гүйцэтгэж буй жолооч нарын хөдөлмөр, амралтын дэглэмийг тогтооход хэрэглэдэг. Энэхүү зөвлөмжийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу улсын харьяалал харгалзахгүй бүх жолооч нар дагаж мөрдөнө.

Жолоочийн ажлын цаг:

- Долоо хоногт ажлын 5 өдөртэй жолооч нарын хувьд өдрийн ажиллах хугацаа 8 цагаас, долоо хоногт ажлын 6 өдөртэй жолооч нарын хувьд долоо хоногийн ажиллах цаг нь Хөдөлмөрийн хуульд заасан үзүүлэлтээс хэтрэхгүй байна.
- Улс, хот хоорондын тээвэрлэлтийн үед жолооч нь амрах газартаа зайлшгүй хүрэх шаардлагатай, эсхүл хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан бол ажлын цагийн үргэлжлэл нь 12 цаг хүртэл байж болно.
- Замын хүндрүүлсэн нөхцөлд 9.5 м-ээс илүүл автобус болон урт, овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэх бол ажлын цагийн үргэлжлэл нь 8 цагаас хэтрүүлэхгүй байна.

Жолоочийн амрах хугацаа:

- Улс, хот хоорондын тээвэрлэлт гүйцэтгэхдээ автотээврийн хэрэгсэл жолоодож эхэлснээс хойш тасралтгүй 4 хүртэл цаг үргэлжилсний араа 15

минутаас багагүй хугацаагаар завсарлага авч амрах ба үүнээс хойш 2 цаг тутамд 15 минутаас доошгүй хугацаагаар завсарлага хийж байх шаардлагатай.

### **Хяналт, шалгалт хийх байгууллага:**

Улс, хот хоорондын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж нь дээр дурдсан жолоочийн хөдөлмөр, амралтын дэглэмийг өөрийн компанид байгууллагын дотоод дүрэм, журам, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж хэрэгжүүлнэ.

Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, Автотээврийн хяналтын байцаагчид, тээврийн цагдаагийн алба хариуцан гүйцэтгэнэ.

Хяналт тавих арга замууд:

Автотээврийн хэрэгсэл нь тахографаар тоноглогдсон байна. Жолоочийн ажил, амралтын хугацааг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг хариуцсан эрх бүхий этгээд дараах чиглэлээр хяналт хийж, зөвлөмж гаргана. Үүнд:

- Хяналтын төхөөрөмж зөв ажиллаж байгаа эсэх;
- Хяналтын төхөөрөмж дээр баталгаажуулалтын гэрчилгээний тэмдэг байгаа эсэх;
- Лацны бүрэн бүтэн байдал;
- Жолооч ажил, амралтын горимын бүртгэл хөтөлсөн эсэх.

**Тээврийн хэрэгсэлд зориулагдсан хиймэл дагуулын хяналтын системд тавигдах шаардлагууд болон дамжин өнгөрөх тээврийн аюулгүй байдлын нэмэлт хэрэгслүүд**

**Тээврийн хэрэгсэлд суурилуулсан хиймэл дагуулын байршлыг тодорхойлох систем**

Улс, хот хоорондын зорчигч тээвэрлэлт, улс хоорондын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд хиймэл дагуулын байршил тогтоох төхөөрөмжийг суурилуулсан байх шаардлагатай.

Гэхдээ олон улсын болон дотоодын, дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл нь байршил тогтоох GPS төхөөрөмжтэй байх бөгөөд энэхүү төхөөрөмж нь “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын хөдөлгөөн удирдлагын хэлтсийн хяналтын төвтэй холбогдох боломжтой байна. Энэхүү төхөөрөмж нь жолоочид цаг агаарын байдал болон замын нөхцөл байдлын талаарх мэдээллийг өгнө.

### **Яаралтай түргэн тусламжийн байгууллагуудын утас**

Онцгой байдлын үед ойрын аймаг, сум, дүүргийн онцгой байдлын алба,, эмнэлгийн яаралтай тусламжийн төв, цагдаагийн байгууллагатай холбогдоно. АН-3 болон АН-4 чиглэлийн авто замын дагуу суурин газруудаас бусад цэгт

суурин утас байхгүй. Хэрэв үүрэн холбооны операторуудын сүлжээ барьж байгаа газарт осол гарах, тусламж авах шаардлага (гал түймэр, үер, газар хөдлөлт, цасан болон шороон шуурга гэх мэт) гарвал дараах утсаар дуудлага өгнө:

101 болон 105 онцгой байдлын нэгдсэн дугаар;

102 – цагдаа;

103 – эмнэлгийн түргэн тусламж;

108 – хүүхдэд зориулсан дуудлагын утас;

19001234 – Автотээврийн үндэсний төв.

## **Авто замын засвар, арчлалтын ажил**

### **Авто замын засварын ажил болон тэдгээрийг мэдээлэх**

2017 онд Авто замын тухай хууль шинэчлэн батлагдсан нь авто замын салбарын хууль эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Энэхүү хууль нь замын барилгын ажил, засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалт, санхүүжилт, хяналтын асуудлуудыг зохицуулдаг бөгөөд түүнчлэн төр болон зам ашиглагч нарын хоорондох харилцааг зохицуулдаг.

Зам, тээврийн хөгжлийн яамны харьяанд авто замын засвар арчлалт хариуцсан байгууллага ажилладаг. Урсгал засвар болон ээлжит засварын ажлууд, мөн түүнчлэн осол аваарын үеийн замын засварын ажлыг хариуцсан холбогдох байгууллага хийж гүйцэтгэдэг. Улсын хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн зам засвар, арчлалтын 28 компани ажилладаг.

Авто замын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт “Авто замыг эзэмшигч нь авто замын арчлалт, засварын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана” гэж заасан. Олон улсын болон улсын чанартай авто замын засвар арчлалтыг Авто замын тухай хуулийн 17.2 дахь хэсэгт заасны дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнээс эрх олгосон этгээд хариуцна.

Зам засвар, арчлалтын ажил хийгдэх үед тухай зам хариуцагч байгууллага нь замын хэсгийг хэсэгчлэн хаах, холбогдох мэдээлэх тэмдгийг байршуулах гэх мэт шаардлагатай арга хэмжээ авна.

### **Улирлын чанартай хязгаарлалт**

Нийслэлийн Засаг даргын 2008 оны А/191 тоот захирамжийн хүрээнд жил бүрийн гурав дугаар сарын 20-ноос дөрөвдүгээр сарын 20, аравдугаар сарын 20-ноос арваннэгдүгээр сарын 20-ныг хүртэл замын хөдөллт, гэсэлтийн үед Улаанбаатар хотод том оврын болон хүнд даацын авто машины хөдөлгөөнийг тээврийн хэрэгслийн бүх жингээс хамааруулан түр хугацаагаар хязгаарладаг. Мөн шаардлагатай үед хязгаарлалт тогтоодог. Өвөл цаг агаар хүндэрсэн үед засвар, арчлалт хариуцдаг байгууллагууд замын хөдөлгөөнийг хэсэгчлэн хаах, замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох, мөсдөлт үүсэхээс сэргийлж замын хажуугаар элс, хайрга байршуулах, зам дээр давс цацах зэрэг шаардлагатай арга хэмжээг авдаг.



Цасан шуурга болон бусад байгалийн гамшигт үзэгдлийн үед олон улсын болон улсын чанартай авто замыг цэвэрлэх, зам дээр үүссэн саатлыг арилгах үүрэгтэй 42 түргэн тусламжийн баг ажилладаг.

Цас, үер усны аюулаас шалтгаалан авто зам, замын байгууламжийг хаасан, замын хөдөлгөөний түр хугацаагаар зогсоосон тухай бодит мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон интернетээс авах боломжтой.

### **Замын аюултай хэсгүүд болон тэдгээрийг мэдээлэх**

Ихэнхдээ цаг агаарын хүндрэлээс шалтгаалан зам дээр аюултай байдал үүсдэг. Цаг агаарын хүндрэл болон эрс тэс уур амьсгал нь замын ашиглалтын байдалд сөргөөр нөлөөлж, авто замын гадаргууд эвдрэл үүсгэж, аюулгүй хэсгүүдийг бий болгодог.

### **Төлбөр төлөх арга замууд**

Хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх төрлийн худалдаа, үйлчилгээний төлбөрийг зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр хийдэг. Үүний дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт төлөгдөх төлбөр, хураамж, татвар зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр төлөгдөнө. Авто замын төлбөр хураах цэг болон замын дагуух үйлчилгээний төвүүд, хоолны газрууд болон нийтийн бие засах газрууд зөвхөн бэлэн мөнгөөр буюу төгрөгөөр төлбөр тооцоог хийнэ.

АН-3 болон АН-4 чиглэлийн авто замын дагуу зөвхөн аймаг, сумын төв, Улаанбаатар гэх мэт төвлөрсөн суурин газруудаас бусад газарт банк, АТМ байхгүй бөгөөд зөвхөн бэлэн мөнгөөр төлбөр тооцоог хийх боломжтой.

### **Авто зам ашигласны хураамж**

Авто зам ашигласны хураамжийн хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 24: Замын хураамжийн хэмжээ

<b>Тээврийн хэрэгслийн төрөл</b>	<b>Ангилал</b>	<b>Төлбөрийн хэмжээ /төгрөг/</b>
Зорчигч тээврийн хэрэгсэл	12 хүртэл хүний суудалтай	1000
	12-24 хүний суудалтай	2000
	24-өөс дээш хүний суудалтай	3000
Ачаа тээврийн хэрэгсэл	2 тэнхлэгтэй 3.5 тн хүртэл бодит жинтэй	2000
	2 тэнхлэгтэй 3.5-18 тн хүртэл бодит жинтэй	3000
	3 тэнхлэгтэй 18 тн хүртэл бодит жинтэй	4000
	3 тэнхлэгтэй 18-25 тн хүртэл бодит жинтэй	5000

	4-өөс дээш тэнхлэгтэй 25 тн хүртэл бодит жинтэй	6000
	4-өөс дээш тэнхлэгтэй 25 тн-оос дээш бодит жинтэй	10000
Бусад	Механизм	10000
	Мотоцикл	500

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газрын 2016 оны 103 дугаар тогтоол

Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын чанартай авто зам, авто байгууламжийг ашигласан тээврийн хэрэгслээс авах зам ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 103 дугаар тогтоолын 2-р хавсралтаар тогтоосон.

### **АН-3 болон АН-4 чиглэлийн авто замын дагуу шалган нэвтрүүлэх авто замын хилийн боомтууд**

#### **Монгол Улсын хилийн боомтод хяналт, шалгалт хийдэг байгууллагууд**

Монгол Улсын хилийн тухай хуульд заасны дагуу хилийн боомтод зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх зорилгоор хилийн боомтод улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллага, виз бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаадын иргэн, харьяатын байгууллага ажилладаг.

#### Мэргэжлийн хяналтын ерөнхий газар:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь Олон улсын гэрээ хэлэлцээр, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Олон улсын түвшинд мэдээлэх хүний хөл хориот халдварт өвчин, мал, амьтаны гаралтай гоц халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй өвчин хог ургамал хилээр нэвтрэх, дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, бараа, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангуулах, аливаа сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хяналт шалгалтыг олон улсын жишигт нийцүүлэн улсын хилийн боомт, гүний хяналтын талбайд хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

#### Хил хамгаалах ерөнхий газар:

Улсын хил хамгаалах байгууллага нь улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, Монгол Улсын олон улсын гэрээнд хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, улсын хилийн шугам, тэмдэг, холбоосны байршлыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байж, хилийн асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх, улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу нэвтрүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### Гаалийн ерөнхий газар:

Гаалийн ерөнхий газар нь Сангийн яаманд харьяалагддаг Засгийн газрын агентлаг юм. Гаалийн ерөнхий газар нь Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах, Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

### Гадаадын иргэн харьяатын газар:

Гадаадын иргэн харьяатын газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэхжүүлэх, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, Иргэний харьяалал, цагаачлал, гадаадын гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх, Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх зэрэг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрсөн, хориглосон барааны жагсаалт болон тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтыг баталсан.

### МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТ

№	Барааны төрөл	Хууль тогтоомж	Нэвтрүүлэх ялгаа
1	Хориглосон болон зохих зөвшөөрөлгүй озон задлах бодис	Агаарын тухай хуулийн 25.2 ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоол	оруулах
2	Зохих зөвшөөрөлгүй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13.1.5, 13.1.7, 13.1.8	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
3	Туршилт, судалгааны ажлаас бусад мод, сөөгний тарьц, суулгац	Ойн тухай хуулийн 29.1.11	оруулах
4	Тамхины бүх төрлийн зар сурталчилгааны материал	Тамхины хяналтын тухай хуулийн 8.2	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх

5	Согтууруулах ундааны зар сурталчилгааны материал	Архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 9.3	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
6	Монгол улсад ашиглахыг хориглосон болон зохих зөвшөөрөлгүй химийн хорт болон аюултай бодис	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5.1, 6.4, 15.4 ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоол	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
7	Ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор аюултай хог хаягдал	Хог хаягдлын тухай хуулийн 17.1	оруулах
8	Зэвсгийн зориулалттай цөмийн материал	Цөмийн энергийн тухай хуулийн 33.2	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
9	Монгол Улсын хуулиар хориглосон болон зохих зөвшөөрөлгүй цөмийн материал, цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи	Цөмийн энергийн тухай хуулийн 37.2.1, 41.1, 41.2	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
10	Хуурамч эм	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11.1.7	оруулах
11	Зохих зөвшөөрөлгүй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15.9.3	оруулах
12	Ашиг олох зорилгоор цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн	Донорын тухай хуулийн 13.1	оруулах, гаргах
13	Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйл	Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5.3	оруулах, гаргах
14	Судалгаа, шинжилгээний зориулалттайгаас бусад этилийн спирт	УИХ-ын 05 дугаар тогтоол ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	оруулах
15	Пиво ундааны хаягдал лаазнаас бусад хаягдал хар болон өнгөт төмөрлөг /ширэм, төмөр, ган, зэс, гууль, хөнгөн цагаан, тэдгээрийн хайлш/, цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй хар болон өнгөт төмөрлөг, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн	УИХ-ын 05 дугаар тогтоол	гаргах

16	Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 1 дүгээр хавсралтад нэр заагдсан амьтан, ургамал	зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц	оруулах, гаргах
17	Зохих зөвшөөрөлгүй ургамал, ургамлын олон наст үндэс, үндэслэг иш, булцуу	Байгалийн ургамлын тухай хуулийн 17.1, 17.3	гаргах
18	Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйл	Байгалийн ургамлын тухай хуулийн 17.4, 17.5	гаргах
19	Жижиглэн савалгаатай, 25%-аас дээш концентрацитай, хүнсний зориулалттай цууны хүчил (Acetic acid)	ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	оруулах
20	Шөрмөсөн чулуу агуулсан бүтээгдэхүүн. Үүнээс: асбест агуулсан тоормозны накладка (Brake pads containing asbestos)	ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	оруулах
21	Озоны давхарга, дэлхийн дулааралд сөрөг нөлөө бүхий HCFC-22, HCFC-1416 бодисоор хөөцөндөр үйлдвэрлэх тоног төхөөрөмж	Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протокол ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	оруулах
22	Пиротехникийн хэрэгсэл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль ЗГ-ын 2006 оны 149 дүгээр тогтоол	гаргах

**МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ТАРИФЫН БУС ХЯЗГААРЛАЛТТАЙ НЭВТРҮҮЛЭХ  
БАРААНЫ БҮЛЭГ ЖАГСААЛТ**

№	Барааны нэр	Хууль эрх зүйн актууд	Нэвтрүүлэх ялгаа	Зөвшөөрөл олгох байгууллага
1	Үржлийн мал, амьтан	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	гаргах	ХХААХҮЯ Мал эмнэлэг

				үржлийн газар
2	Нэн ховор амьд амьтан	Амьтны тухай хуулийн 36.1	гаргах	БОАЖЯ
3	Нэн ховор амьтнаас бусад амьд амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны сорьц, дээж	Амьтны тухай хуулийн 36.2	гаргах	БОАЖЯ
4	Ургамал, ургамлын олон наст үндэс, үндэслэг иш, булцуу	Байгалийн ургамлын тухай хуулийн 17.1, 17.3	гаргах	БОАЖЯ
5	Судалгаа, шинжилгээний зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосон нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйл	Байгалийн ургамлын тухай хуулийн 17.4, 17.5	гаргах	БОАЖЯ
6	Озон задлах бодис	Агаарын тухай хууль Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоол	оруулах	Озоны үндэсний алба
7	Согтууруулах ундаа	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах	ХХААХҮЯ
8	Тамхи	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах	ХХААХҮЯ
9	Бүх төрлийн шатахуун	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах	АМГТГ
10	Малын эм, эмнэлгийн хэрэгсэл	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах	Мал эмнэлэг үржлийн газар
11	Ургамал хамгаалахад ашиглах бодис	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль	оруулах	ХХААЯ, БОАЖЯ

12	Гадаадаас сайжруулагч мал, амьтан	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах	ХХААЯ
13	Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж протез	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах	Эрүүл мэндийн яам
14	Биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүн	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах	Эрүүл мэндийн яам
15	Туршилт судалгааны зориулалттай мод, сөөгний тарьц, суулгац	Байгалийн ургамлын тухай хууль	оруулах	БОАЖЯ
16	Пиротехникийн хэрэгсэл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль ЗГ-ын 2006 оны 149 дүгээр тогтоол	оруулах	Уул уурхайн яам
17	Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл	Галт зэвсгийн тухай хууль Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоол	оруулах, гаргах	ЦЕГ, ХЗЯ
18	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн угтвар бодис	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тухай хууль	оруулах, гаргах	Эрүүл мэндийн яам
19	Өвчин үүсгэгч нян, түүний хор	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	оруулах, гаргах	Эрүүл мэндийн яам
20	Цөмийн бодис	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Цөмийн энергийн тухай хууль	оруулах, гаргах	ЦЭК
21	Цацраг идэвхт ашигт малтмал, цацрагийн үүсгүүр	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Цөмийн энергийн тухай хууль	оруулах, гаргах	ЦЭК

22	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, түүхий эд	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай хууль	оруулах, гаргах	Уул уурхайн яам
23	Стратегийн хүнс	Хүнсний тухай хууль	оруулах, гаргах	ХХААХҮЯ
24	Зөвхөн эмчилгээний зориулалтаар баталгаажсан эд, эрхтэн	Донорын тухай хууль	оруулах, гаргах	Эрүүл мэндийн яам
25	Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	оруулах, гаргах	БСШУЯ
26	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйл 2 дугаар хавсралт	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц	оруулах, гаргах	БОАЖЯ
27	Цахилгаан	Эрчим хүчний тухай хуулийн 12.1.10	оруулах, гаргах	Эрчим хүчний яам
28	Химийн хорт болон аюултай бодис	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоол	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх	БОАЖЯ

### **Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто зам**

#### **АН-3 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл**

Энэ чиглэлийн авто зам нь Оросын Холбооны Улстай хиллэдэг Алтанбулаг боомтоос БНХАУ-ын хиллэдэг Замын-Үүд боомтыг холбосон 1041 км урттай авто зам юм.

А0401: Алтанбулаг хилийн боомтоос Улаанбаатар хот хүртэл – 326.3 км;

А0101: Улаанбаатар хотоос Чойр хүртэл – 230 км;

А0102: Чойроос Сайншанд хүртэл – 229 км;

А0103: Сайншандаас Замын-Үүд боомт хүртэл – 218.9 км.



## **Алтанбулаг хилийн боомтын дэд бүтэц болон боомтод мөрдөх журам**

Алтанбулаг боомт – энэ нь Монголын хойд талд АН-3 чиглэлийн авто замын дагуу байрладаг хилийн боомт бөгөөд ОХУ-тай хиллэдэг 29 боомтоос хамгийн гол боомт юм. Алтанбулаг боомт нь 24 цагийн ажиллагаатай. Алтанбулаг боомтод бүх үүрэн холбооны операторуудын сүлжээ ажилладаг. Нэвтрүүлэх хүчин чадал нь хоногт 2300 зорчигч, 500 тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх боломжтой. Автотээврийн хэрэгслээр тээвэрлэгдэж буй ачааг Гаалийн тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллагууд шалган нэвтрүүлнэ.

## **Олон улсын автотээвэрлэлтэд хийгддэг хяналт, шалгалтын процедур**

Хоёр талын ачаа тээвэрлэлтэд хилийн боомтын хяналт, шалгалт дараах журмаар явагдана.

1. Автотээврийн байгууллагаас олгосон олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх албан ёсны зөвшөөрлийн бичиг;
2. Улсын хилээр нэвтрэхэд холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон хураамж төлнө;
3. Тээврийн хэрэгслийн баримт бичгийн бүрдэл, тээврийн хэрэгслийг жолоодож буй хүний паспортыг хил хамгаалах байгууллага шалгана;
4. Ачааг гаалийн хяналтын рентген аппаратаар шалгана;
5. Рентген аппаратын хяналтын үр дүнг зургаар буулган хилийн боомт руу илгээнэ. Рентген аппаратаар шалгах үйл явц ойролцоогоор 3 минут үргэлжилнэ.
6. Ачаагүй хоосон тээврийн хэрэгсэл 8000 төгрөг, бодит жин нь 20 хүртэл тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 10000 төгрөг, бодит жин нь 20-оос дээш тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 15000 төгрөг төлнө.
7. Шаардлагатай бол ачаатай тээврийн хэрэгслийг гаалийн жингийн хяналтаар оруулна. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийн жинг тооцохгүй.
8. Жингийн хяналтын дараа Мэргэжлийн хяналтын байцаагч хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтын дараа хяналт, шалгалт хийсэн тухай баталгааны тэмдэглэгээг хийнэ.
9. Үүний дараа гаалийн байгууллагад бүртгүүлнэ.
10. Гаалийн байцаагч гаалийн сүлжээнд бүртгэж, шалгалтаа дуусгана.
11. Төгсгөлд нь хил хамгаалах байгууллага паспортын хяналтыг хийж, хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

Энэхүү процедур нь 10-15 мин үргэлжлэх бөгөөд ачааны шинж чанараас хамаарч уртсаж болно.

Дамжин өнгөрөх ачааны хувьд хилийн боомтод дараах хяналтын процедур явагдана.

1. Хилийн хяналтын байгууллага паспортыг шалгаж, тамга дарж, ОХУ-аас орж ирсэн тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичгийг шалгана.
2. Ачаа нь гаалийн байгууллагын жингийн хяналтаар орж, бүртгэлд бүртгэгдэнэ.

3. ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагаас гаргасан гаалийн манифест ба дагалдах баримт, бичгүүдийг шалгана.
4. Гаалийн байцаагч эдгээр баримт бичгийг бүртгэж, хуудсыг дугаарлаж, гаалийн гарах бүрдүүлэлтийг хаана хийхийг тодорхойлж, сүлжээндээ тэмдэглэнэ. Дараа нь тэр хилийн боомт дахь гаалийн газарт гаалийн хяналт шалгалт хийсэн тухайгаа мэдээлнэ.
5. Дамжин өнгөрөх ачааг рентген аппаратаар оруулж шалгана.
6. Ачааны машины гадна талын ерөнхий үзлэгийг хийж, ачааны хэсгийг гаалийн тамгаар тамгална.
7. Монгол Улсад дамжин өнгөрөх ачааны гаалийн бүрдүүлэлтэд их хугацаа шаардагдахгүй.
8. МХЕГ нь дамжин өнгөрөх барааны хяналт, шалгалтад оролцдоггүй.
9. Гаалийн ахлах байцаагч дамжин өнгөрөх ачаа нь гаалийн сүлжээнд бүртгэгдсэн эсэхийг шалгаж, тамга дарж, дагалдах бичиг баримтыг шалгаж, ачааны автомашин гаалийн итгэмжлэгдсэн тээврийн компанид хамаарах, эсхүл дамжин өнгөрөх тээвэрлэлт хийх зөвшөөрөл байгаа эсэхийг шалгана.
10. Аюултай ачааг рентген сканераар шалгана.
  - Аюултай ачааны гаалийн хяналтыг рентген сканераар хийнэ.
  - Гаалийн алба эдгээр ачааг цагдаагийн газар, тагнуулын байгууллагад мэдэгдэж, хүлээлгэн өгнө.
  - Аюултай ачааг Цагдаагийн байгууллагын хяналт дор явуулна.

Гаалийн тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл болон ачааны дараах баримт, бичгийг шаардаж болно.

- Тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг;
- Тээврийн хэрэгслийн даатгалын хуудас;
- Улсын дугаарын тэмдэг болон ялгах тэмдэг;
- Тээвэрлэгчийн бүртгэлийн бичиг, баримт;
- Худалдааны гэрээ;
- Тооцооны хуудас;
- Нэхэмжлэх;
- Сав баглаа боодлын ачааны жагсаалт (packing list).

### **Хилийн шалган нэвтрүүлэх Замын-Үүд боомтын дэд бүтэц болон мөрдөх журам**

Замын-Үүд боомт нь БНХАУ-тай хиллэдэг 13 боомтоос хамгийн чухал боомт юм. Замын-Үүд боомт нь өвлийн улиралд 09.00-17.00 цагийн хооронд, зуны улиралд 09.00-19.00 цагийн хооронд ажилладаг.

Автотээврийн хэрэгслээр тээвэрлэгдэж буй ачааг Гаалийн тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллагууд шалган нэвтрүүлнэ.

## **Олон улсын автотээвэрлэлтэд хийгддэг хяналт, шалгалтын процедур**

Хоёр талын ачаа тээвэрлэлтэд хилийн боомтын хяналт, шалгалт дараах журмаар явагдана.

1. Автотээврийн байгууллагаас олгосон олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх албан ёсны зөвшөөрлийн бичиг;
2. Улсын хилээр нэвтрэхэд холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон хураамж төлнө;
3. Тээврийн хэрэгслийн баримт бичгийн бүрдэл, тээврийн хэрэгслийг жолоодож буй хүний паспортыг хил хамгаалах байгууллага шалгана.
4. Ачааг гаалийн хяналтын рентген аппаратаар шалгана;
5. Рентген аппаратын хяналтын үр дүнг зургаар буулган хилийн боомт руу илгээнэ. Рентген аппаратаар шалгах үйл явц ойролцоогоор 3 минут үргэлжилнэ.
6. Ачаагүй хоосон тээврийн хэрэгсэл 8000 төгрөг, бодит жин нь 20 хүртэл тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 10000 төгрөг, бодит жин нь 20-оос дээш тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 15000 төгрөг төлнө.
7. Шаардлагатай бол ачаатай тээврийн хэрэгслийг гаалийн жингийн хяналтаар оруулна. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийн жинг тооцохгүй.
8. Жингийн хяналтын дараа Мэргэжлийн хяналтын байцаагч хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтын дараа хяналт, шалгалт хийсэн тухай баталгааны тэмдэглэгээг хийнэ.
9. Үүний дараа гаалийн байгууллагад бүртгүүлнэ.
10. Гаалийн байцаагч гаалийн сүлжээнд бүртгэж, шалгалтаа дуусгана.
11. Төгсгөлд нь хил хамгаалах байгууллага паспортын хяналтыг хийж, хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

Энэхүү процедур нь 10-15 мин үргэлжлэх бөгөөд ачааны шинж чанараас хамаарч уртсаж болно.

Дамжин өнгөрөх ачааны хувьд хилийн боомтод дараах хяналтын процедур явагдана.

1. Хилийн хяналтын байгууллага паспортыг шалгаж, тамга дарж, БНХАУ-аас орж ирсэн тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичгийг шалгана.
2. Ачаа нь гаалийн байгууллагын жингийн хяналтаар орж, бүртгэлд бүртгэгдэнэ.
3. ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагаас гаргасан гаалийн манифест ба дагалдах баримтуудыг шалгана.
4. Гаалийн байцаагч эдгээр баримт бичгийг бүртгэж, хуудсыг дугаарлаж, гаалийн гарах бүрдүүлэлтийг хаана хийхийг тодорхойлж, сүлжээндээ тэмдэглэнэ. Дараа нь тэр хилийн боомт дахь гаалийн газарт гаалийн хяналт шалгалт хийсэн тухайгаа мэдээлнэ.
5. Дамжин өнгөрөх ачааг рентген аппаратаар оруулна шалгана.
6. Ачааны машины гадна талын ерөнхий үзлэгийг хийж, ачааны хэсгийг гаалийн тамгаар тамгална.

7. Монгол Улсад дамжин өнгөрөх ачааны гаалийн бүрдүүлэлтэд их хугацаа шаардагдахгүй.
8. МХЕГ нь дамжин өнгөрөх барааны хяналт, шалгалтад оролцдоггүй.
9. Гаалийн ахлах байцаагч дамжин өнгөрөх ачаа нь гаалийн сүлжээнд бүртгэгдсэн эсэхийг шалгаж, тамга дарж, дагалдах бичиг баримтыг шалгаж, ачааны автомашин гаалийн итгэмжлэгдсэн тээврийн компанид хамаарах, эсхүл дамжин өнгөрөх тээвэрлэлт хийх зөвшөөрөл байгаа эсэхийг шалгана.
10. Аюултай ачааг рентген сканераар шалгана.
  - Аюултай ачааны гаалийн хяналтыг рентген сканераар хийнэ.
  - Гаалийн алба эдгээр ачааг цагдаагийн газар, тагнуулын байгууллагад мэдэгдэж, хүлээлгэн өгнө.
  - Аюултай ачааг Цагдаагийн байгууллагын хяналт дор явуулна.

Гаалийн тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл болон ачааны дараах баримт, бичгийг шаардана болно.

- Тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг;
- Тээврийн хэрэгслийн даатгалын хуудас;
- Улсын дугаарын тэмдэг болон ялгах тэмдэг;
- Тээвэрлэгчийн бүртгэлийн бичиг, баримт;
- Худалдааны гэрээ;
- Тооцооны хуудас;
- Нэхэмжлэх;
- Сав баглаа боодлын ачааны жагсаалт(packing list).

### **Замын тэмдэг, тэмдэглэгээ**

Замын тэмдэг, тэмдэглэгээ нь Монгол Улсын стандартчилал, хэмжил зүйн газрын баталсан “Замын тэмдэг, тэмдэглэгээнд тавих шаардлага”-н дагуу хийгдсэн.

Хүснэгт 25: Замын тэмдэг, тэмдэглэгээ

№	Тайлбар, мэдээлэл
1.	Улаанбаатар хотоос Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.
2.	Улаанбаатараас Замын-Үүд хүртэлх замын ихэнх хэсэг нь шинээр баригдсан тул эвдрэл, сэрэмжлүүлэг тэмдэг, тэмдэглэгээ маш цөөн байна. Замын хажуугийн 2 талаар 2-3 км тутамд 278 замын тэмдэг, тэмдэглэгээг нийт 566 ширхэг байрлуулсан байна. Нэмж хэлэхэд, энэ чиглэлд байрлах газруудын нэр, зайг харуулсан илүү самбар байв.

### **Авто замын төлбөр хураах цэгүүд /ТХЦ/**

АН-3 чиглэлийн авто замын дагуу төлбөр хураах 6 цэг байрлаж байна.

1. Хоолтын төлбөр хураах цэг;
2. Замын-Үүдийн төлбөр хураах цэг;

3. Рашаантын төлбөр хураах цэг;
4. Дарханы төлбөр хураах цэг;
5. Дулаанхааны төлбөр хураах цэг;
6. Айрагын төлбөр хураах цэг.

Засгийн газраас авто зам барих шинэ төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан зам ашигласны төлбөр хураах цэгийн тоо нэмэгдэх болно. Одоо байгаа төлбөр хураах цэгүүдийн ерөнхий байдал олон улсын стандартын шаардлагад нийцээгүй хэвээр байна. Доорх хүснэгтэд АН-3 дээр ажиллаж байгаа төлбөр хураах цэгүүдийн талаарх мэдээллийг үзүүлсэн болно.

Хүснэгт 26: төлбөр хураах цэгүүдийн байршил

№	Авто замын дугаар	Чиглэл	ТХЦ-ын байршил	Эхлэл ба төгсгөлийн цэгүүд		Замын урт (км)
				Эхлэх цэг	Төгсөх цэг	
1	A0101	Налайх-Чойр	Хоолтын давааны эсрэг талд Улаанбатараа с 40 км-т	Налайх-Чойр чиглэлийн замын уулзвар	Чойр	198
2	A0103	Сайншанд-Замын-Үүд	Замын-Үүд сум	Сайншанд	Замын-Үүд	218
3	A0401	Улаанбаатар-Дархан	Рашаантын уулзвар	Улаанбаатараа с 19 км-т	Дархан	206
4	A0402	Улаанбаатар-Дархан	Дархан-Эрдэнэтийн замын уулзвар	Дархан	Улаанбаатараа с 19 км-т	168
5	A0402 A0403	Дархан-Сүхбаатар	Дулаанхааны 4 замын уулзвар	Дархан	Алтанбулаг	113
6	A0102	Чойр-Сайншанд-Замын-Үүд	Айраг сум	Айраг	Замын-Үүд	342

### АН-3 чиглэлийн авто зам дагуух яаралтай тусламжийн байгууллагууд

Онцгой байдлын үед жолооч хамгийн ойрын аймаг, сумын төвтэй холбогдох шаардлагатай. Энэхүү чиглэлийн авто замын дагуу суурин газруудаас бусад газарт суурин утас байхгүй.

Хүснэгт 28: АН-3 чиглэлийн дагуух аймаг, сумдын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

№	Нэр	Зай (км)	Эмнэлгийн яаралтай тусламж	Онцгой байдлын алба	Цагдаа

1	Замын-Үүд сум – Эрдэнэт сум (Дорноговь аймаг)	121,35	96693103 96613109	7052101	7052102
2	Эрдэнэт сум – Өргөн сум (Дорноговь аймаг)	139,47	98219738 99746266		
3	Өргөн сум – Сайншанд (Дорноговь аймаг)	59,22	93122103 95519309		
4	Сайншанд – Айраг сум (Дорноговь аймаг)	126,55	7052103 70523986		
5	Айраг сум – Даланжаргалан сум (Дорноговь аймаг)	22,71	0252414355 93039208		
6	Даланжаргалан сум – Шивээговь сум (Дорноговь аймаг)	51,15	0252414150 91660689		
7	Шивээговь сум – Чойр (Говьсүмбэр аймаг)	34,77	91546103		
8	Чойр - Баянтал (Говьсүмбэр аймаг)	26,16	7054103 99577103		
9	Багахангай дүүрэг (Төв аймаг) – Налайх (Улаанбаатар хот)	67,45	022103	101	102
10	Налайх дүүрэг (Улаанбаатар хот) - Улаанбаатар	43,43	70232448 70232427		
11	Улаанбаатар – Баянчандмань сум (Төв аймаг)	69,78	103		
12	Баянчандмань сум – Борнуур сум (Төв аймаг)	36,07	80277595	7027101	7027102
13	Борнуур сум (Төв аймаг) – Баруун хараа (Сэлэнгэ аймаг)	62,78	80801663		
14	Баруун хараа (Сэлэнгэ аймаг) – Хонгор сум (Дархан Уул аймаг)	49,62	70369103	7036101	7036102
15	Хонгор сум (Дархан Уул аймаг) - Дархан	20,53	99086819	7037101	7037102
16	Дархан – Жавхлант сум (Сэлэнгэ аймаг)	47,47	99378818 99016144 0137224358		
17	Жавхлант сум (Сэлэнгэ аймаг) – Сүхбаатар (Сэлэнгэ аймаг)	66,24	99629872	7036101	7036102
	Сүхбаатар (Сэлэнгэ аймаг) – Алтанбулаг (Сүхбаатар)	24,37	70362559 70363586 70366028		

АН-3 чиглэлийн авто зам нь 5 аймгийн 19 сумын нутгаар дайран өнгөрдөг. Тиймээс яаралтай тохиолдолд хамгийн ойрхон аймаг, сумын төв нь дунджаар 30 км-ийн зайд байдаг.

Төслийн хүрээнд нийслэл хотод түргэн тусламжийн дуудлага хүлээн авч, шаардлагатай яаралтай тусламж үзүүлэх нэгдсэн (эмнэлэг, гал түймэр, цагдаа гэх мэт) төвийг 2010 онд байгуулсан бөгөөд уг төв нь зөвхөн нийслэлд яаралтай тусламжийг үзүүлнэ. Яаралтай тусламжийн хэсэг нь яаралтай тусламжийн дуудлага хүлээн авч, шуурхай бүлэг ослын газарт ажиллаж байх үед байнгын холбооны операторыг томилон ажиллуулдаг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой байдлын алба, Онцгой байдлын газрын удирдах хэсэг нь GPS ашиглан ослын байршлыг тодорхойлдог бөгөөд ослын газрын байршлын талаарх мэдээллийг координат солилцож, тогтоодог.

Цаашид энэ төрлийн онцгой байдлын нэгдсэн төвийг аймаг / аймгуудын төвд байгуулахаар төлөвлөж байна. Замын дагуух баг, сум гэх жижиг засаг захиргааны нэгжид тусгай аврах мэргэшсэн анги байхгүй. Харин эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хувийн эмнэлгүүд ажилладаг бөгөөд тэдгээрийн утасны дугаарыг дээрх хүснэгтэд үзүүлсэн.

Осол гарсан тохиолдолд замын дагуу яаралтай түргэн тусламжийн цэг байдаггүй тул эмнэлгийн яаралтай тусламжийг авахад ихээхэн хүндрэл үүсдэг.

### **АН-3 чиглэлийн авто замын дагуух үйлчилгээний газрууд**

Монгол Улсад 2016 онд “Замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал. Үндсэн шаардлага. MNS 5537:2016” стандарт батлагдсан бөгөөд уг стандартын дагуу үйлчилгээний байгууламжуудын хооронд зай нь 250 км-ээс ихгүй, ашиглалтын хугацаа нь 15 жилээс багагүй байна гэж заасан.

АН-3 чиглэлийн авто замын дагуух үйлчилгээний байгууламжуудын талаарх мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 29: Улаанбаатараас Алтанбулаг чиглэлийн авто замын дагуух үйлчилгээний байгууламжуудын жагсаалт

<b>№</b>	<b>Нэр ба зай</b>	<b>Авч болох үйлчилгээ</b>
1	Улаанбаатар хотоос 97 км-т байрлах “Бамбарууш” үйлчилгээний цэг	<ul style="list-style-type: none"> <li>- Ресторан</li> <li>- Зогсоол</li> <li>- Төлбөртэй нийтийн бие засах өрөө. Бие засах өрөөний төлбөр 200 төгрөг.</li> <li>- Улаанбаатар хот руу чиглэсэн талд байрладаг</li> <li>- Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээний цэг баригдсан боловч ажилладаггүй.</li> </ul>
2	Улаанбаатар хотоос 100 км-т байрлах “Урьхан” үйлчилгээний цэг	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөрт ойролцоогоор 1000 хүнд үйлчилдэг</li> <li>- Зогсоолын талбай</li> <li>- Хоолны газар нь нэгэн зэрэг 250 хүн хүлээн авах боломжтой</li> <li>- Халуун ус болон цахилгаан</li> <li>- Төлбөртэй нийтийн бие засах өрөө. Бие засах өрөөний төлбөр 200 төгрөг.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Зочид буудлын өрөө</li> <li>- Дугуй засвар</li> <li>- Супермаркет</li> <li>- Хяналтын камертай</li> <li>- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх жижиг эмийн сантай</li> <li>- ШТС</li> <li>- Банкны бэлэн мөнгөний машин болон сүлжээгүй интернет бий болгохоор төлөвлөж байна.</li> </ul>
3	Улаанбаатар хотоос 100 км-т байрлах үйлчилгээний цэг	<ul style="list-style-type: none"> <li>- Зогсоол</li> <li>- Зоогийн газар</li> <li>- Төлбөртэй нийтийн бие засах газар</li> <li>- Утасны сүлжээтэй.</li> </ul>

Улаанбаатараас Алтанбулаг чиглэлийн авто замын 100 дахь км-т эхний амрах цэг байрладаг. Баруунхараа сум нь Улаанбаатар хотоос 169 дэх км-т байрладаг. Баруунхараа нь төвлөрсөн суурин газар тул амрах байр, нийтийн бие засах газар, техникийн үйлчилгээний газар, АТМ гэх мэт бүх үйлчилгээг авах боломжтой юм.

Баруунхараа сумаас Дархан хот хүртэл 70 км зайтай бөгөөд энэ хооронд амрах газар байхгүй, харин Дархан хотод шаардлагатай бүх үйлчилгээг авах боломжтой.

Дархан-Уул аймгаас Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот хүртэл ойролцоогоор 98 км-ийн зайтай бөгөөд уг замын дагуу зориулалтын амрах газар байдаггүй. Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатарт шаардлагатай бүх үйлчилгээг авах боломжтой. Сүхбаатар сумаас Алтанбулаг сум буюу хил хүртэл 24 км зайтай бөгөөд уг замын дагуу хоол идэх, амрах зориулалтын газар байдаггүй.

Ерөнхийдөө замын хажуугийн үйлчилгээний цогцолборууд нь жолооч, зорчигчдын бүрэн ая тухтай байдлыг хангаж чадахгүй байна. Мөн түүнчлэн зогсоолын талбай болон техникийн үйлчилгээний засварын талбай хангалтгүй байна. жолооч, зорчигч нар хоол идэх зорилгоор зам хөндлөн гарч байгаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй байна.

Улаанбаатар хотоос Алтанбулаг сум чиглэлийн авто замд хоолны газраас бусад зориулалтын зогсоол байхгүй байна. Улаанбаатар хотоос Алтанбулаг хүртэлх зам нь 2 эгнээтэй зам юм. Тээврийн хэрэгсэл эвдэрсэн тохиолдолд зогсоож, засвар хийх, эсхүл зам дагуу түр амрахад тохиромжтой зориулалтын газар байхгүй. Иймд тээврийн хэрэгсэл эвдэрч зогссон тохиолдолд замын хөдөлгөөнд саад учруулж болзошгүй тул уг зам нь эрсдэлтэй зам гэж тооцогддог.

Улаанбаатар хотоос 22 км, 23 км, 24,2 км, 37 км, 52 км, 69 км, 70 км, 100 км, 152 км, 155 км, 157 км, 199 км, 204 км, 212 км, 220 км, 221 км, 308 км, 317 км, 319 км-т шатахуун түгээх станц байрладаг.

Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн замын нэг хэсэг болох Чойроос Замын-Үүд чиглэлийн авто зам нь сүүлд баригдсан тул түр зогсох



хангалттай талбайтай. Техникийн засвар, үйлчилгээний цэгүүд нь төв суурин газруудад байрладаг. Түүнчлэн суурин газруудад жижиг зочид буудлууд болон хоолны газрууд ажилладаг.

Улаанбаатар хотоос 41 км, 98 км, 101 км, 200 км, 223-227 км, 291 км, 299 км, 326 км, 452 км, 554 км, 621 км, 630 км-т шатахуун түгээх станцуудыг байрладаг.

Хүснэгт 30: Улаанбаатараас Замын-Үүд сумын чиглэлийн авто замын дагуу байрлах үйлчилгээний цогцолборуудын жагсаалт

№	Нэр	Зай (км)	Үйлчилгээ
1	Хоолт	41	- Төлбөр хураах цэг - Зогсоолын талбай - Гадна байрлах бие засах газар
2	Оорцог уулзавар	173	- Жижиг зогсоол
3	18 дугаар уулзавар	200	- Зоогийн газар, зогсоол - Гадаа бие засах газар
4	Говьсүмбэр аймгийн Чойр сумын цагдаагийн пост	223	6 жилийн өмнө байгуулагдсан. “Төв азза” ХХК-ийн хяналтан дор үйл ажиллагаа явуулдаг. Интернет, үүрэн операторын сүлжээ ашиглах боломжтой. Хяналтын цэгээс 4 км-ийн зайд шилэн кабель, шатахуун түгээх станц, дэлгүүр, дугуй засвар, хоолны газар, ачааны машин, авто зогсоолын засвар үйлчилгээний газрууд ажилладаг.
5	Шивээговь	259	- Автобусны зогсоол
6	Шивээговь	260	- Ачааны машины зогсоол
7	Өлзийт зөрлөг	277	- Ачааны автомашины зогсоол, үүрэн холбооны сүлжээтэй
8	Өлзийт зөрлөг	290	- Ачааны машины зогсоол
9	Дорноговь аймгийн Даланжаргалан сум	301	- Ачааны машины зогсоол
10	Дорноговь аймгийн Айраг сум	326	- Замын хоёр талд зогсоолын талбайтай - ШТС - Зоогийн газар - Гадаа байрлах бие засах газар
11	30 дугаар зөрлөг	353	- Ачааны автомашины зогсоол, зоогийн газар, утасны сүлжээ
12	31 дүгээр зөрлөг	369	- Ачааны автомашины зогсоол, зоогийн газар, утасны сүлжээ
13	33 дугаар зөрлөг	393	- Ачааны автомашины зогсоол, зоогийн газар, утасны сүлжээ
14	35 дугаар зөрлөг	417	- Ачааны автомашины зогсоол

15	Дорноговь аймгийн Сайншанд	434	- ШТС, хяналтын төв
16		475	- Ачааны автомашины зогсоол
17	“80”	580	- “80” зоогийн газар
18	Шаргын зоо	637	- Шилэн кабель, цахилгаантай холбогдох боломжтой

## **Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто зам**

### **АН-4 чиглэлийн авто замын талаарх мэдээлэл**

Уг авто зам нь Оросын Холбооны Улстай хиллэдэг Цагааннуур боомтоос БНХАУ-тай хиллэдэг Булган боомт хүртэл Монгол Улсын нутаг дэвсгэрээр 756 км үргэлжилдэг.

Энэхүү авто зам нь Азийн авто замын сүлжээний 3 дугаар зэрэглэлийн замын стандартын шаардлагыг хангасан авто зам юм. Замын өргөн нь 7 метр, замын хажуугийн хөвөөний өргөн 1.5-2 метр, замын далангийн өргөн 10-11 метр байна. Ашиглалтын хугацаа нь 20 жил.

Азийн авто замын сүлжээний АН-4 коридорын Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг 756 км авто замын 730.2 км буюу 95.8 хувийг хатуу хучилттай авто зам болгон барьж байгуулсан. Үлдсэн 25,8 км авто замыг 2020 онд ашиглалтад оруулна.

Дээрх авто замын дагуу 25-30 км тутамд түр зогсоолын зогсоолын талбай байгуулахаар төлөвлөж байна. Газар зүйн байршлаас шалтгаалан огцом эргэлт болон өндөр даваа гүвээтэй тул Замын хөдөлгөөний дүрмийг баримтлан хөдөлгөөний хурдыг тохируулж явах шаардлагатай.

### **Цагааннуур хилийн боомтын дэд бүтэц болон мөрдөх журам**

Цагааннуур боомт нь олон улсын чанартай хилийн боомт бөгөөд долоо хоногийн Даваагаас Бямба гарагт 09.00-өөс 18.00 цагийн хооронд ажилладаг. Энэхүү боомт нь Баян-Өлгий аймгийн Цагааннуур сумын нутагт Улаанбаатар хотоос 1900 гаруй км-ийн зайд байрладаг. Цагааннуур хилийн боомт анх 1924 онд байгуулагдсан.

Хилийн нэвтрүүлэх хүчин чадал:

- Орох, гарах тээврийн хэрэгсэлд зориулсан 2 эгнээ авто зам;
- Тээврийн хэрэгсэл болон ачаанд шалгалт хийх тусгай талбай;
- Нэгэн зэрэг 8 тээврийн хэрэгсэл шалгах боломжтой;
- Жин хэмжих 100 тонны даацтай электрон пүү.

2016 онд Цагааннуур боомтоор 113485 зорчигч, 33645 тээврийн хэрэгсэл, 71816,4 тонн ачаа нэвтэрсэн байна.

Цагааннуур боомтоор өдөрт 100 автомашин (80 ачааны автомашин, 20 автобус болон суудлын автомашин) нэвтрүүлнэ.

Татвар, хураамжийг Хаан банкны салбарт төлөх боломжтой. Энд “Туушин” ХХК болон “Өлзийнаран” ХХК-ийн гаалийн мэргэжилтэн ажилладаг.

Мөн энд цахилгаан эрчим хүчийг хангах зорилгоор дизелийн түлшээр ажилладаг цахилгаан үүсгэвэр гаргагч генератор ажилладаг. Мобиком компанийн гар утасны сүлжээ болон Монголын цахилгаан холбоо компанийн суурин утасны сүлжээгээр дамжуулан утас ашиглах боломжтой. Монголын цахилгаан холбоо компанийн телеконтролын системээр холбосон бөгөөд хиймэл дагуулын холбооны системээр шууд дуудлага хийх, компьютерийн сүлжээнд холбогдох боломжтой. Энд бас интернетэд нэвтрэх боломжтой.

Цагааннуур хилийн боомтод гаалийн хяналт, шалгалтад тээврийн хэрэгслийн цацраг идэвхт бодис илрүүлэгч, онлайн хяналтын камер, INCOMNET бага оврын хиймэл дагуулын станц, 100 тонны даацтай автомашины жин хэмжин электрон пүү зэрэг багаж хэрэгсэл ашигладаг.

Хоёр талын ачаа тээвэрлэлтэд хилийн боомтын хяналт, шалгалт дараах журмаар явагдана.

1. Автотээврийн байгууллагаас олгосон олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх албан ёсны зөвшөөрлийн бичиг;
2. Улсын хилээр нэвтрэхэд хураамж төлнө;
3. Тээврийн хэрэгслийн баримт бичгийн бүрдэл, тээврийн хэрэгслийг жолоодож буй хүний паспортыг хил хамгаалах байгууллага шалгана.
4. Ачааг гаалийн хяналтын рентген аппаратаар шалгана;
5. Рентген аппаратын хяналтын үр дүнг зургаар буулган хилийн боомт руу илгээнэ. Рентген аппаратаар шалгах үйл явц ойролцоогоор 3 минут үргэлжилнэ.
6. Ачаагүй хоосон тээврийн хэрэгсэл 8000 төгрөг, бодит жин нь 20 хүртэл тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 10000 төгрөг, бодит жин нь 20-оос дээш тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 15000 төгрөг төлнө.
7. Шаардлагатай бол ачаатай тээврийн хэрэгслийг гаалийн жингийн хяналтаар оруулна. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийн жинг тооцохгүй.
8. Жингийн хяналтын дараа Мэргэжлийн хяналтын байцаагч хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтын дараа хяналт, шалгалт хийсэн тухай баталгааны тэмдэглэгээг хийнэ.
9. Үүний дараа гаалийн байгууллагад бүртгүүлнэ.
10. Гаалийн байцаагч гаалийн сүлжээнд бүртгэж, шалгалтаа дуусгана.
11. Төгсгөлд нь хил хамгаалах байгууллага паспортын хяналтыг хийж, хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

Энэхүү процедур нь 10-15 мин үргэлжлэх бөгөөд ачааны шинж чанараас хамаарч уртсаж болно.

Дамжин өнгөрөх ачааны хувьд хилийн боомтод дараах хяналтын процедур явагдана.

1. Хилийн хяналтын байгууллага паспортыг шалгаж, тамга дарж, ОХУ-аас орж ирсэн тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичгийг шалгана.
2. Ачаа нь гаалийн байгууллагын жингийн хяналтаар орж, бүртгэлд бүртгэгдэнэ.
3. ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагаас гаргасан гаалийн манифест ба дагалдах баримтуудыг шалгана.
4. Гаалийн байцаагч эдгээр баримт бичгийг бүртгэж, хуудсыг дугаарлаж, гаалийн гарах бүрдүүлэлтийг хаана хийхийг тодорхойлж, сүлжээндээ тэмдэглэнэ. Дараа нь тэр хилийн боомт дахь гаалийн газарт гаалийн хяналт шалгалт хийсэн тухайгаа мэдээлнэ.
5. Дамжин өнгөрөх ачааг рентген аппаратаар оруулна шалгана.
6. Ачааны машины гадна талын ерөнхий үзлэгийг хийж, ачааны хэсгийг гаалийн тамгаар тамгалана.
7. Монгол Улсад дамжин өнгөрөх ачааны гаалийн бүрдүүлэлтэд их хугацаа шаардагдахгүй.
8. МХЕГ нь дамжин өнгөрөх барааны хяналт, шалгалтад оролцдоггүй.
9. Гаалийн ахлах байцаагч дамжин өнгөрөх ачаа нь гаалийн сүлжээнд бүртгэгдсэн эсэхийг шалгаж, тамга дарж, дагалдах бичиг баримтыг шалгаж, ачааны автомашин гаалийн итгэмжлэгдсэн тээврийн компанид хамаарах, эсхүл дамжин өнгөрөх тээвэрлэлт хийх зөвшөөрөл байгаа эсэхийг шалгана.
10. Аюултай ачааг рентген сканераар шалгана.
  - Аюултай ачааны гаалийн хяналтыг рентген сканнераар хийнэ.
  - Гаалийн алба эдгээр ачааг цагдаагийн газар, тагнуулын байгууллагад мэдэгдэж, хүлээлгэн өгнө.
  - Аюултай ачааг Цагдаагийн газрын хяналт дор явуулна.

Гаалийн тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл болон ачааны дараах баримт, бичгийг шаардана болно.

- Тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг;
- Тээврийн хэрэгслийн даатгалын хуудас;
- Улсын дугаарын тэмдэг болон ялгах тэмдэг;
- Тээвэрлэгчийн бүртгэлийн бичиг, баримт;
- Худалдааны гэрээ;
- Тооцооны хуудас;
- Нэхэмжлэх;
- Сав баглаа боодлын ачааны жагсаалт(packing list).

### **Хилийн шалган нэвтрүүлэх Булган боомтын дэд бүтэц болон мөрдөх журам**

Булган боомт нь Ховд аймгийн Булган сумын нутагт Булган сумаас 45 км-ийн зайд, Улаанбаатар хотоос ойролцоогоос 1760 км-ийн зайд байрлах бөгөөд БНХАУ-ын ШУӨЗО-ны Цинхэ дүүрэгтэй хиллэдэг. Булган боомт нь анх 1991 оны 07 дугаар сарын 04-ний өдөр албан ёсоор нээгдэж, 2011 онд олон улсын чанартай хилийн боомт болон өөрчлөгдсөн. Байнгын ажиллагаатай боомт юм. Булган сумаас боомт хүртэлх авто зам нь асфальтан хучилттай авто зам юм.

Энэ боомтод цахилгаан эрчим хүчийг хангах зорилгоор дизель цахилгаан үүсгүүр (генератор) ажилладаг. Мобиком компаний гар утасны сүлжээ болон Монголын цахилгаан холбоо компанийн суурин утасны сүлжээгээр дамжуулан утас ашиглах боломжтой. Монголын цахилгаан холбоо компанийн телеконтролын системээр холбосон бөгөөд хиймэл дагуулын холбооны системээр шууд дуудлага хийх, компьютерийн сүлжээнд холбогдох боломжтой. Энд бас интернетэд нэвтрэх боломжтой.

Уг боомтоор 2014 онд 11544 тээврийн хэрэгсэл, 165790 зорчигч, 97007,9 тонн ачаа, 2015 онд 15596 тээврийн хэрэгсэл, 202793 зорчигч, 427682,2 тонн ачаа, 2016 онд 13710 тээврийн хэрэгсэл, 1760130 зорчигч, 377019,4 тонн ачаа нэвтэрсэн байна.

Гаалийн хяналт, шалгалтад нэмэлтээр тусгай бэлтгэгдсэн нохой ажилладаг. Хилийн боомтод МХЕГ, ГЕГ, ГИХГ, ХХЕГ-ын албууд ажилладаг.

Татвар, хураамжийг Хаан банкны салбарт төлөх боломжтой. Энд “Туушин” ХХК болон “Өлзийнаран” ХХК-ийн гаалийн мэргэжилтэн ажилладаг.

Хоёр талын ачаа тээвэрлэлтэд хилийн боомтын хяналт, шалгалт дараах журмаар явагдана.

1. Автотээврийн байгууллагаас олгосон олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх албан ёсны зөвшөөрлийн бичиг;
2. Улсын хилээр нэвтрэхэд хураамж төлнө;
3. Тээврийн хэрэгслийн баримт бичгийн бүрдэл, тээврийн хэрэгслийг жолоодож буй хүний паспортыг хил хамгаалах байгууллага шалгана.
4. Ачааг гаалийн хяналтын рентген аппаратаар шалгана;
5. Рентген аппаратын хяналтын үр дүнг зургаар буулган хилийн боомт руу илгээнэ. Рентген аппаратаар шалгах үйл явц ойролцоогоор 3 минут үргэлжилнэ.
6. Ачаагүй хоосон тээврийн хэрэгсэл 8000 төгрөг, бодит жин нь 20 хүртэл тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 10000 төгрөг, бодит жин нь 20-оос дээш тонн жинтэй ачаатай тээврийн хэрэгсэл 15000 төгрөг төлнө.
7. Шаардлагатай бол ачаатай тээврийн хэрэгслийг гаалийн жингийн хяналтаар оруулна. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийн жинг тооцохгүй.
8. Жингийн хяналтын дараа Мэргэжлийн хяналтын байцаагч хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтын дараа хяналт, шалгалт хийсэн тухай баталгааны тэмдэглэгээг хийнэ.
9. Үүний дараа гаалийн байгууллагад бүртгүүлнэ.
10. Гаалийн байцаагч гаалийн сүлжээнд бүртгэж, шалгалтаа дуусгана.
11. Төгсгөлд нь хил хамгаалах байгууллага паспортын хяналтыг хийж, хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

Энэхүү процедур нь 10-15 мин үргэлжлэх бөгөөд ачааны шинж чанараас хамаарч уртсаж болно.

Дамжин өнгөрөх ачааны хувьд хилийн боомтод дараах хяналтын процедур явагдана.

1. Хилийн хяналтын байгууллага паспортыг шалгаж, тамга дарж, ОХУ-аас орж ирсэн тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичгийг шалгана.
2. Ачаа нь гаалийн байгууллагын жингийн хяналтаар орж, бүртгэлд бүртгэгдэнэ.
3. ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагаас гаргасан гаалийн манифест ба дагалдах баримтуудыг шалгана.
4. Гаалийн байцаагч эдгээр баримт бичгийг бүртгэж, хуудсыг дугаарлаж, гаалийн гарах бүрдүүлэлтийг хаана хийхийг тодорхойлж, сүлжээндээ тэмдэглэнэ. Дараа нь тэр хилийн боомт дахь гаалийн газарт гаалийн хяналт шалгалт хийсэн тухайгаа мэдээлнэ.
5. Дамжин өнгөрөх ачааг рентген аппаратаар оруулна шалгана.
6. Ачааны машины гадна талын ерөнхий үзлэгийг хийж, ачааны хэсгийг гаалийн тамгаар тамгална.
7. Монгол Улсад дамжин өнгөрөх ачааны гаалийн бүрдүүлэлтэд их хугацаа шаардагдахгүй.
8. МХЕГ нь дамжин өнгөрөх барааны хяналт, шалгалтад оролцдоггүй.
9. Гаалийн ахлах байцаагч дамжин өнгөрөх ачаа нь гаалийн сүлжээнд бүртгэгдсэн эсэхийг шалгаж, тамга дарж, дагалдах бичиг баримтыг шалгаж, ачааны автомашин гаалийн итгэмжлэгдсэн тээврийн компанид хамаарах, эсхүл дамжин өнгөрөх тээвэрлэлт хийх зөвшөөрөл байгаа эсэхийг шалгана.
10. Аюултай ачааг рентген сканнераар шалгана.
  - Аюултай ачааны гаалийн хяналтыг рентген сканнераар хийнэ.
  - Гаалийн алба эдгээр ачааг цагдаагийн газар, тагнуулын байгууллагад мэдэгдэж, хүлээлгэн өгнө.
  - Аюултай ачааг Цагдаагийн газрын хяналт дор явуулна.

Гаалийн тухай хуульд заасны дагуу тээврийн хэрэгсэл болон ачааны дараах баримт, бичгийг шаардана болно.

- Тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичиг;
- Тээврийн хэрэгслийн даатгалын хуудас;
- Улсын дугаарын тэмдэг болон ялгах тэмдэг;
- Тээвэрлэгчийн бүртгэлийн бичиг, баримт;
- Худалдааны гэрээ;
- Тооцооны хуудас;
- Нэхэмжлэх;
- Сав баглаа боодлын ачааны жагсаалт.

### **Замын тэмдэг, тэмдэглэгээ**

Замын тэмдэг, тэмдэглэгээ нь Монгол Улсын стандартчилал, хэмжил зүйн газрын баталсан “Замын тэмдэг, тэмдэглэгээнд тавих шаардлага”-н дагуу хийгдсэн.

Хүснэгт 31: АН-4 чиглэлийн авто замын тэмдэг, тэмдэглэгээ

№	Тайлбар, мэдээлэл
1	Уулархаг газар зүйн байршлаас шалтгаалан огцом эргэлт, өндөр даваа гүвээ ихтэй тул Цагааннуур боомтоос Булган боомт чиглэлийн авто зам дээр анхааруулах тэмдэг, мэдээлэх самбар, уулын нуралтаас хамгаалсан туузан хашлагуудыг байрлуулсан. Змын нэг талдаа 2-3 км тутамд нийт 186 тэмдэг болон мэдээлэх самбар (хоёр талдаа нийт 372) байруулсан.

**Төлбөр хураах цэгүүд**

Монгол Улсын Булган хилийн боомтоос Цагааннуур хилийн боомт хүртэлх АН-4 чиглэлийн авто замд нийт 2 төлбөр хураах цэг ажиллаж байна.

- Баян-Өлгий аймгийн Өлгий хотоос Ховд аймаг руу явдаг чиглэлд Цагааннуур хилийн боомтоос 100 км зайд электрон пүүгээр тоноглогдсон Өлгий сумын төлбөр хураах цэг.
- Булган боомтоос 45 км-т байрлах электрон пүүгээр тоноглогдсон Булган сумын төлбөр хураах цэг.

**АН-4 чиглэлийн авто зам дагуух яаралтай тусламжийн байгууллагууд**

Онцгой байдлын үед жолооч хамгийн ойрын аймаг, сумын төвтэй холбогдох шаардлагатай. Энэхүү чиглэлийн авто замын дагуу суурин газруудаас бусад газарт суурин утас байхгүй. Гар утасны сүлжээтэй газруудад онцгой байдлын үед (гал түймэр, үер, газар хөдлөлт, цасан болон шороон шуурга) жолооч нь 101 болон 105, цагдаа 102, эмнэлгийн тусламж 103, хүүхдийн тусламж 108 дугаарт залгаж, осол аваар гарсан газрын байршлын талаар болон бусад мэдээллийг өгнө.

Хүснэгт 28: АН4 чиглэлийн дагуух аймаг, сумдын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

№	Нэр	Зай (км)	Эмнэлгийн яаралтай тусламж	Онцгой байдлын алба	Цагдаа
1	Булган боом – Булган сум (Ховд аймаг)	41	95946209 7043103		
2	Булган сум (Ховд аймаг) – Үенч сум (Ховд аймаг)	35	7043103	7043101	7043102
3	Үенч сум (Ховд аймаг) – Алтай сум (Ховд аймаг)	50			
4	Алтай сум (Ховд аймаг) – Манхан сум (Ховд аймаг)	83			

5	Манхан сум (Ховд аймаг) – Ховд (Ховд аймаг)	189,7			
6	Ховд (Ховд аймаг) – Толбо сум (Баян-Өлгий аймаг)	51	7042103 70422769	7042101	7042102
7	Өлгий (Баян-Өлгий аймаг) – Цагааннуур сум Өлгий (Баян-Өлгий аймаг)	65,4	7042103		

АН-4 чиглэлийн авто зам нь Монгол Улсын нутгаар 2 аймгийн 8 сумын нутгаар дайран өнгөрдөг бөгөөд онцгой байдлын үед хамгийн ойрхон аймаг, сумын төв нь дунджаар 70 км-ийн зайд байдаг.

Төслийн хүрээнд нийслэл хотод түргэн тусламжийн дуудлага хүлээн авч, шаардлагатай яаралтай тусламж үзүүлэх нэгдсэн (эмнэлэг, гал түймэр, цагдаа гэх мэт) төвийг 2010 онд байгуулсан бөгөөд уг төв нь зөвхөн нийслэлд яаралтай тусламжийг үзүүлнэ. Яаралтай тусламжийн хэсэг нь яаралтай тусламжийн дуудлага хүлээн авч, шуурхай бүлэг ослын газарт ажиллаж байх үед байнгын холбооны операторыг томилон ажиллуулдаг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой байдлын алба, Онцгой байдлын газрын удирдах хэсэг нь GPS ашиглан ослын байршлыг тодорхойлдог бөгөөд ослын газрын байршлын талаарх мэдээллийг координат солилцож, тогтоодог.

Цаашид ийм төрлийн онцгой байдлын нэгдсэн төвийг аймаг / аймгуудын төвд байгуулахаар төлөвлөж байна. Замын дагуу баг, сум гэх жижиг засаг захиргааны нэгжид тусгай аврах мэргэшсэн анги байхгүй. Харин эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хувийн эмнэлгүүд ажилладаг бөгөөд тэдгээрийн утсыг дээрх хүснэгтэд үзүүлсэн.

Осол гарсан тохиолдолд замын дагуу яаралтай түргэн тусламжийн цэг байдаггүй тул эмнэлгийн яаралтай тусламжийг авахад ихээхэн хүндрэл үүсдэг.

#### **АН-4 чиглэлийн авто замын дагуу үйлчилгээний цэгүүд**

АН-4 чиглэлийн авто замын дагуу түр зогсох зогсоол хангалттай байдаг. Харин хооллох, амрах газрууд болон үйлчилгээний газрууд байдаггүй. Замын дагуу цөөн тооны зочид буудал, кафе байрладаг. Булган-Цагааннуур боомт хүртэлх авто замын дагуу 5-6 шатахуун түгээх станц байдаг бөгөөд шатахууны үнэ Улаанбаатарт зарагдаж буй шатахууны үнээс 150-200 төгрөгөөр илүү байдаг.

Хүснэгт 33: Цагааннуур боомтоос Булган боомт чиглэлийн авто замын дагуу байрлах үйлчилгээний цогцолборуудын жагсаалт

№	Нэр ба зай	Тайлбар
1	Цагааннуур боомтоос 200 болон 350 км-т хэд хэдэн зочид буудал, кафе байдаг	Авто зогсоол 2-3 кафе Нийтийн бие засах газар



2	Цагааннуур боомтоос Булган боомт чиглэлийн авто замын дагуу 6 ШТС байдаг	Цагааннуур боомтоос 53 км, 159 км, 305 км, 447 км, 598 км-т шатахуун түгээх станцууд байрладаг
---	--	--

## ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

### Тээврийн эрх бүхий байгууллага

#### Автотээврийн гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд

Оросын Холбооны Улсын Тээврийн яам.

[https://mintrans.ru/english\\_version/](https://mintrans.ru/english_version/)

Хаяг: ОХУ-ын 109012, Москва хот, Рождественска гудамж, 1-р хороо.

Утас: +7 (499) 495-00-00

Факс: +7 (499) 495-00-10

E-Mail: [info@mintrans.ru](mailto:info@mintrans.ru)

### Олон улсын автотээвэрчдын холбоо (АСМАП)

1974 онд байгуулагдсан төрийн бус байгууллага юм. АСМАП дотоодын болон олон улсын ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэдэг 1600 орчим байгууллагыг өөртөө нэгтгэсэн. Холбооны гол зорилго нь ОХУ болон үндэсний тээврийн үйлчилгээ эрхлэгч компаниудын эрх ашгийг хамгаалах, олон улсын авто тээврийн үйл ажиллагаанд таатай нөхцөлийг бүрдүүлэх, дотоодын тээвэрлэгчдийн олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

<http://www.asmap.ru/>

Хаяг: Марксистская гудамж, 34 тоот. 9, Москва, 109017, ОХУ.

Утас: +7 (495) 622-0000

Факс: +7 (495) 622-0003

E-mail: [asmap@asmap.ru](mailto:asmap@asmap.ru)

### Олон улсын тээврийн зөвшөөрөл олгодог байгууллага

Зөвшөөрлийн бичиг солилцох дэгийг хоёр улсын тээврийн хамтарсан комиссын жилийн бүрийн хуралдаанаар хэлэлцэн тохирсоны дагуу зохион байгуулдаг. Зөвшөөрлийн бичгийг хоёр улсын Тээврийн яамны түвшинд солилцдог бөгөөд түүний дараа тухай улсын яам нь зөвшөөрлийн бичиг олгох журмыг тогтоодог. Тээвэрлэгч нар олон улсын тээврийн зөвшөөрлийн бичгийг өөрийн улсад авдаг.

### Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх хамгийн их жин, овор хэмжээний зохицуулалт

"Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх журам батлах тухай" ОХУ-ын Засгийн газрын 2011 оны 04 дүгээр сарын 15-ны 272 дугаар тогтоол (22.12.2016 оны нэмэлт өөрчлөлт)-оор тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн овор хэмжээ, жинг тогтоосон.

Хүснэгт 34: Зөвшөөрөгдөх хамгийн их овор, хэмжээ

Хамгийн хэмжээ	их	Тээврийн хэрэгслий төрөл	Хэмжээ
Урт		Дан тээврийн хэрэгсэл	12.00 м
		Авто угсраа	20.00 м
Өргөн		Бүх тээврийн хэрэгсэл	2.6 м
Өндөр		Бүх тээврийн хэрэгсэл	4.00 м

Хүснэгт 35: Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх жин

Дан тээврийн хэрэгслүүд	Жин
2 тэнхлэгтэй	18.00 т
3 тэнхлэгтэй	25.00 т
4 тэнхлэгтэй	32.00 т
5 тэнхлэгтэй	35.00 т
Эмээлт автоугсраа болон чиргүүлтэй тээврийн хэрэгслүүд	Жин
3 тэнхлэгтэй	28.00 т
4 тэнхлэгтэй	36.00 т
5 тэнхлэгтэй	40.00 т
6 болон түүнээс дээш тэнхлэгтэй	44.00 т

Хүснэгт 35: Тэнхлэг дээрх хамгийн их жин

	Тэнхлэг хоорондын зай (метр)	Тэнхлэг дэх дугуйны тоо болон тэнхлэгийн ачаалал (тоцоологдсон)-аас хамаарсан дугуйт тээврийн хэрэгслийн тэнхлэгийн зөвшөөрөгдөх ачаалал		
		Нэг тэнхлэг дээрх ачааллыг 6 тонноор тооцсон авто замуудад	Нэг тэнхлэг дээрх ачааллыг 10 тонноор тооцсон авто замуудад	Нэг тэнхлэг дээрх ачааллыг 11 тонноор тооцсон авто замуудад
Нэг тэнхлэгтэй	2.5-аас дээш	5.5 (6)	9 (10)	10.5 (11.5)
Хоёр тэнхлэгтэй, тэнхлэг хоорондын зай	1 хүртэл /1 орно/	8 (9)	10 (11)	11.5 (12.5)
	1-ээс их 1.3 хүртэл /1.3 орно/	9 (10)	13 (14)	14 (16)
	1.3-аас их 1.8 хүртэл /1.8 орно/	10 (11)	15 (16)	17 (18)
	1.8-аас их 2.5 хүртэл /2.5 орно/	11 (12)	17 (18)	18 (20)
Гурван тэнхлэгтэй,	1 хүртэл /1 орно/	11 (12)	15 (16.5)	17 (18)

тэнхлэг хоорондын зай	1-ээс их 1.3 хүртэл /1.3 орно/	12 (13)	18 (19.5)	20 (21)
	1.3-аас их 1.8 хүртэл /1.8 орно/	13.5 (15)	21 (22.5*)	23.5 (24)
	1.8-аас их 2.5 хүртэл /2.5 орно/	15 (16)	22 (23)	25 (26)
3-аас дээш тэнхлэгтэй, тэнхлэг хоорондын зай	1 хүртэл /1 орно/	3.5 (4)	5 (5.5)	5.5 (6)
	1-ээс их 1.3 хүртэл /1.3 орно/	4 (4.5)	6 (6.5)	6.5 (7)
	1.3-аас их 1.8 хүртэл /1.8 орно/	4.5 (5)	6.5 (7)	7.5 (8)
	1.8-аас их 2.5 хүртэл /2.5 орно/	5 (5.5)	7 (7.5)	8.5 (9)
Тэнхлэг бүр нь 8 ба түүнээс дээш дугуйтай тээврийн хэрэгслийн тэнхлэгүүд (нэг тэнхлэг дээрх ачаалал)	1 хүртэл /1 орно/	6	9.5	11
	1-ээс их 1.3 хүртэл /1.3 орно/	6.5	10.5	12
	1.3-аас их 1.8 хүртэл /1.8 орно/	7.5	12	14
	1.8-аас их 2.5 хүртэл /2.5 орно/	8.5	13.5	16
*хаалтан доторх хэмжээ нь давхар дугуйнд, хаалтны гаднах хэмжээ нь дан дугуйнд зориулсан. **хийн болон түүнтэй адилтгах амортизатортай дан дугуйтэй тэнхлэгт зориулсан.				

### **Овор, хэмжээ болон жингийн нормыг дагаж мөрдөөгүй зөрчилд оногдуулах торгуулийн заалтууд**

Зөрчилд хүлээлгэх хариуцлага ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12.21.1-р зүйлд заасны дагуу зохицуулагддаг бөгөөд зөрчлийн хэлбэрээс хамаарч торгуулийг жолоочид болон хуулийн этгээдэд, эсхүл албан тушаалтанд оногдуулна. (Хавсралт 1)

#### **Авто зам дээрх хяналт, шалгалт**

АН-3 болон АН-4 авто замын дагуу жингийн хяналт тавих байнгын ажиллагаатай цэгүүд байрладаг. Түүнчлэн хөдөлгөөнт станцуудыг байнга ашигладаг.

ОХУ-ын Тээврийн яамны Тээврийн хяналт, шалгалтын улсын байгууллага нь ОХУ-ын автотээврийн салбарын хууль, тогтоомж болон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах (хянах) ажлыг хэрэгжүүлдэг эрх бүхий төрийн байгууллага юм.

- “Мария-Ра” хүнсний дэлгүүр - Новосибирск муж, Черепаново, Романовагийн гудамж, 35, GPS-ийн координат: 54.220407, 83.359627
- “Водолей” хүнсний дэлгүүр - Новосибирск муж, Черепаново, Романова гудамж, 38, GPS-ийн координат: 54.220821, 83.360464
- Супермаркет “Холди дискаунтер” - Алтайн нутаг, Талменка, Вокзалная гудамж 18А, GPS-ийн координат: 53.817226, 83.564585
- Хүнсний дэлгүүр “Красный” - Алтайн хязгаар, Новоалтайск, Советовын гудамж 22А, GPS-ийн координат: 53.455534, 83.908716
- “Мария-Ра” хүнсний дэлгүүр - Алтайн хязгаар, Баюуновские Ключи, Луговая гудамж, 1, GPS-ийн координат: 53.329298, 84.180737
- Зогсоол / амрах байр - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Черга суурин, Заречная гудамж, 4, GPS-ийн координат: 51.577094, 85.580071

- “Шинкор” хүнсний дэлгүүр - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Шебалино, Федорва гудамж, 18, GPS-ийн координат: 51.295283, 85.675096
- Хүнсний дэлгүүр “Минутка” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Онгудай, GPS-ийн координатууд: 50.753168, 86.137228
- “Мария-Ра” хүнсний дэлгүүр - Алтайн хязгаар, Онгудай, Советская гудамж, GPS-ийн координат: 50.749657, 86.134543
- “Маяк” хүнсний дэлгүүр - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Заводская гудамж 157А, GPS координат: 52.032613, 85.913511
- “Подгорный” хүнсний дэлгүүр - Алтайн хязгаар, Майма, Советская гудамж, 65, GPS-ийн координат: 52.022582, 85.906342
- “Водолей” хүнсний дэлгүүр - Алтайн хязгаар, Майма, Детсадовская гудамж , 21А, GPS-ийн координат: 52.018264, 85.910827
- Хүнсний дэлгүүр “Парламент” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Подгорная гудамж, 1В, GPS-ийн координат: 52.018436, 85.916534
- Хүнсний дэлгүүр “Стрелец” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Подгорная гудамж, 28В, GPS-ийн координат: 52.017010, 85.917371
- Хүнсний дэлгүүр “Белый айст” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Подгорная гудамж 59А, GPS-ийн координат: 52.015425, 85.914882
- “Талисман” хүнсний дэлгүүр - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Подгорная гудамж, 34, GPS-ийн координат: 52.012876, 85.912994
- “Мария-Ра” хүнсний дэлгүүр - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Подгорная гудамж, 35, GPS-ийн координат: 52.012242, 85.912586
- “Весна” хүнсний дэлгүүр - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Лениний гудамж, 105А, GPS-ийн координат: 51.991462, 85.880075
- Худалдааны төв “ЦУМ” - Алтайн хязгаар, Горно-Алтайск, Коммунистичный Ав., 76, GPS-ийн координат: 51.955353, 85.935865
- “Горный-2” худалдааны төв - Алтайн хязгаар, Горно-Алтайск, Коммунистичкийн авто зам, 109, GPS-ийн координат: 51.962176, 85.912347
- “Корзинка Уют” супермаркет - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Кош-Агач, Чуйский зам, 25, GPS-ийн координат: 49.995039, 88.665061.

### ***Ариун цэврийн өрөө (бие засах газар), ундны ус, кафе / ресторан***

- Ресторан “Папа Жонс” / Кафе “Баранжар” - Новосибирск муж., Новосибирск, Ядринцевская гудамж, 21, GPS-ийн координат: 55.030358, 82.917089, утас: +7 (383) 202-22-22
- Ресторан “Вилка-Ложка” - Новосибирск муж, Новосибирск, Фрунзийн гудамж, 2, GPS-ийн координат: 55.036070, 82.915641, утас: +7 (383) 222-17-10
- Кафе “Тифлис” - Новосибирск муж., Новосибирск, Зөвлөлтийн гудамж, 65, GPS-ийн координат: 55.035289, 82.914761, утас: +7 (383) 222-81-81
- Кафе “Эклер” - Новосибирск муж., Новосибирск, Ядринцевская гудамж, 21, GPS-ийн координат: 55.033223, 82.921391, утас: +7 (383) 285-88-31
- Ресторан “McDonald's” - Хурдны зам Р-256 / АН-4; Новосибирск муж, Новосибирск, Красный өргөн чөлөө, 88, GPS-ийн координат: 55.050694, 82.915834, утас: +7 (383) 228-13-12
- Ресторан “проспект” / кафе “Хлебосол” - хурдны зам Р-256 / АН-4; Новосибирск муж, Новосибирск, Красный өргөн чөлөө, 86, GPS-ийн координат: 55.049317, 82.915995, утас: +7 (383) 224-74-50

- Кафе “Парус” - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск хот, Красный өргөн чөлөө, 75, GPS-ийн координат: 55.047062, 82.914836, утас: +7 (383) 221-88-58
- Арт кафе - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Красный өргөн чөлөө, 167, GPS-ийн координат: 55.063998, 82.911008, утас: +7 (383) 236-77-88
- “ШашлыкоФФ” зоогийн газар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск хот, Красный өргөн чөлөө, 200, GPS-ийн координат: 55.063384, 82.912942, утас: +7 (383) 335-77-55
- Кафе/Ресторан “Райский сад” - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Красный өргөн чөлөө, 218/2, GPS-ийн координат: 55.065731, 82.912081, утас: +7 (383) 236-14-00
- “Аред” кафе - Новосибирск муж, Новосибирск хот, Гүржийн 1-р гудамж, 28 / 1к1, GPS-ийн координат: 55.120240, 82.919744, утас: +7 (383) 203-88-00
- Ресторан Империя восходящего солнца - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Большевицкая гудамж, 43, GPS-ийн координат: 55.010062, 82.935183, утас: +7 (383) 375-28-90
- “Подорожник” кафе - Новосибирск муж., Новосибирск, Новая заря гудамж, 20, GPS-ийн координат: 55.010536, 82.939775, утас: 8 (800) 200-07-35
- Ресторан “McDonald's” - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск хот, Большевицкая гудамж, 3, GPS-ийн координат: 55.008690, 82.937168, утас: +7 (383) 383-08-61
- Ресторан Вилка-Ложка - Хурдны зам Р-256 / АН-4; Новосибирск муж, Новосибирск хот, Большевицкая гудамж, 12, GPS-ийн координат: 55.007773, 82.936009, утас: +7 (383) 344-98-57
- Прага кафе - Хурдны зам Р-256 / АН-4; Новосибирск муж, Новосибирск, Большевицкая гудамж, 101, GPS-ийн координат: 55.004832, 82.945772
- Рестораны Бургер Кинг - Хурдны зам Р-256 / АН-4; Новосибирск муж, Новосибирск хот, Большевицкая гудамж, 137, GPS-ийн координат: 54.997669, 82.964848, утас: +7 (495) 544-50-00
- Кафе “Хуторок” - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Бердск хот, Вокзальная гудамж, 1/1, GPS-ийн координат: 54.770337, 83.104167, утас: +7 (913) 899-31-11
- Cafe “Smile City” - Новосибирск муж, Бердск, Ленинский гудамж, 90, GPS-ийн координат: 54.758713, 83.109338, утас: +7 (983) 305-55-65
- Кафе “Пицца Компанелла” - Новосибирск муж, Бердск хот, Ленинский гудамж, 98, GPS координат: 54.756880, 83.117320, утас: +7 (913) 981-33-33
- Кафк “Сарканд” - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Бердск хот, Барнаульская гудамж, 13, GPS-ийн координат: 54.752410, 83.141438
- Кафе “Аленка” - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Евсино, Мира гудамж, 36, GPS-ийн координат: 54.505338, 83.334202, утас: +7 891 358-44-53
- Кафе “Uncle Doner” - Новосибирск муж, Черепаново, Романовагийн гудамж, 3, GPS-ийн координат: 54.221637, 83.372287, утас: +7 (383) 349-93-89
- Кафе “Печка-Лавочки” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Сростки, Чуйскийн зам, 5, GPS координат: 52.421751, 85.714404, утас: +7 (909) 505-11-14
- Кафе “Дилижанс” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Талменка, GPS-ийн координат: 53.803076, 83.514124, утас: +7 (385) 912-80-00

- “Таверна дяди Вита” хоолны газар - Р-256 / АН-4 зам; Алтайн хязгаар, Талменка, Садовая гудамж, 22, GPS-ийн координат: 53.802962, 83.518394, утас: +7 (923) 161-33-33
- “Заправка” кафе - Алтайн хязгаар, Талменка, Советская гудамж, 14, GPS-ийн координат: 53.811044, 83.545188
- “Лакомка” кафе - Алтайн хязгаар, Талменка, Школьный эгнээ, 8G, GPS координат: 53.810676, 83.546819, утас: +7 (385) 912-80-91
- “Пепперони пиццерия” - Алтайн хязгаар, Талменка, Вокзальная гудамж, 17, GPS-ийн координат: 53.815782, 83.563684
- “Осколита” кафе - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Саузга тосгон, Тракторная гудамж, 44, GPS-ийн координат: 51.886982, 85.850997, утас: +7 (903) 996-74-96
- “Вилка-Ложка” кафе - Алтайн хязгаар, Барнаул, Лениний гудамж, 10, GPS-ийн координат: 53.333914, 83.793141, утас: +7 (385) 253-84-82
- Ресторан “Мощерелла” - Алтайн хязгаар, Барнаул, Ленина гудамж, 21, GPS-ийн координат: 53.336169, 83.789536, утас: +7 (385) 235-39-31
- “Титан” ресторан - Алтайн хязгаар, Барнаул, Красная армия гудамж, 47А, GPS-ийн координат: 53.335196, 83.775889, утас: +7 (385) 268-12-78
- “Де Лафайе” кафе - Алтайн хязгаар, Барнаул, Ав. Sotcialniy, 46, GPS-ийн координат: 53.337656, 83.783098, утас: +7 (385) 265-84-97
- “Subway” кафе - Алтайн хязгаар, Барнаул, Красноармейский гудамж, 94 а, GPS-ийн координатууд: 53.342477, 83.769429, утас: +7 (385) 255-58-89
- “Синюха” кафе - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Манжерок суурин, Найрамдлын гудамж, 38, GPS-ийн координат: 51.833097, 85.780737, утас: +7 (913) 999-08-19
- Кафе “Рузанна” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Манжерок суурин, Совхозная гудамж, 2, GPS-ийн координат: 51.833130, 85.769869, утас: +7 (983) 582-70-70
- “Чайный дом” кафе - Р-369 авто зам; Алтайн хязгаар, Черга суурин, Октябрьская гудамж, GPS-ийн координат: 51.573120, 85.569771
- Хоолны газар - Алтайн хязгаар, Онгудай, Эрзумашевын гудамж, GPS-ийн координат: 50.750601, 86.134747
- “Сказка” кафе - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Подгорная гудамж, 4G, GPS координат: 52.009072, 85.911299, утас: +7 (903) 919-02-81
- “Блин-Грилл” ресторан - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Подгорная гудамж, 1Б, GPS координат: 52.005584, 85.907401, утас: +7 (913) 698-94-09
- “Жемчужина” кафе - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Ленин гудамж, 1/1, GPS-ийн координат: 52.004401, 85.905910, утас: +7 (388) 442-12-64
- Кафе “Круиз” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Лениний гудамж 10А, GPS координат: 52.003827, 85.899559, утас: +7 (388) 442-49-95
- кафе “Солнечный” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн хязгаар, Майма, Лениний гудамж, 87, GPS-ийн координат: 51.994276, 85.884882
- Кафе “Пристань” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Майма, Лениний гудамж, 62, GPS-ийн координат: 51.993734, 85.882479, утас: +7 (388) 442-28-75

- Ресторан “Любимый” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Майма, Лениний гудамж, 125, GPS-ийн координат: 51.989331, 85.875537, утас: +7 (923) 662-56-66
- Кафе “Камелот” - Р-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Майма, Тракторная гудамж, 15, GPS-ийн координат: 51.981012, 85.854675, утас: +7 (913) 998-39-23
- Ресторан “Галакси” - Алтайн Бүгд Найрамдах Улс, Горно-Алтайск, Коммунистический гудамж, 101, GPS-ийн координат: 51.959425, 85.914707, утас: +7 (388) 226-41-22
- Кафе “Гурман” - Алтайн Бүгд Найрамдах Улс, Горно-Алтайск, Коммунистический гудамж, 139, GPS-ийн координат: 51.967754, 85.900735, утас: +7 (388) 226-41-88.

### **Банк ба АТМ**

- Сбербанкны салбар - Новосибирск муж., Новосибирск, Земниуховын гудамж, 5/2, GPS-ийн координат: 55.108682, 82.955610
- АТМ Сбербанк - Новосибирск муж., Новосибирск, Аэропорт гудамж, 2/4, GPS-ийн координат: 55.080424, 82.909177
- Совкомбанкны салбар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Красный авто зам, 59, GPS-ийн координат: 55.040490, 82.917186
- Альфа-Банкны салбар / Сбербанкны салбар - Новосибирск муж, Новосибирск, Мичуриний гудамж, 23, GPS-ийн координат: 55.041468, 82.922057
- Райффайзенбанкны салбар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Крылова гудамж, 7, GPS-ийн координат: 55.040460, 82.918699
- Росбанкны салбар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Красный өргөн чөлөө, 76, GPS-ийн координат: 55.045328, 82.917014
- Газпромбанкны салбар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Кавалери, .., 2, GPS-ийн координат: 55.055992, 82.915952
- Банк ВТБ24 - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск, Красный өргөн чөлөө, 179/2, GPS-ийн координат: 55.060510, 82.913130
- АТМ ВТБ24 - Новосибирск муж, Новосибирск, Зуриановская гудамж, 32, GPS-ийн координат: 55.009557, 82.939002
- Связьбанкны салбар - Новосибирск муж, Новосибирск, Серебряниковская гудамж, 2, GPS-ийн координат: 55.017678, 82.928627
- Сбербанкны АТМ - Новосибирск муж, Новосибирск, Серебряниковская гудамж, 3, GPS-ийн координат: 55.016823, 82.928509
- Сбербанкны АТМ - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Бердск, Барнаульская гудамж, 19, GPS-ийн координат: 54.750218, 83.145172
- Сбербанкны салбар - Алтайн нутаг, Бийск хот, Красноярская гудамж, 123, GPS-ийн координат: 52.528451, 85.253244
- Сбербанкны салбар - Алтайн хязгаар, Бийск хот, Горькийн гудамж, 69, GPS-ийн координат: 52.525605, 85.225520
- Сбербанкны салбар - Алтайн нутаг, Сростки хот, Пионерийн гудамж, 31, GPS-ийн координат: 52.421952, 85.697878

- Сбербанкны салбар - Алтайн нутаг, Талменка, Партизанская гудамж, 49, GPS-ийн координат: 53.816859, 83.557011
- Сбербанкны АТМ - Алтайн хязгаар, Новоалтайск, Белоярская гудамж, 149, GPS-ийн координат: 53.453451, 83.905132
- Банкны орон сууцны зээл - Алтайн нутаг, Барнаул, Лениний өргөн чөлөө, 2, GPS-ийн координат: 53.330787, 83.796271, утас: +7 (385) 265-93-57
- Альфа банкны АТМ - Алтайн хязгаар, Барнаул, Лениний өргөн чөлөө, 10, GPS-ийн координат: 53.333760, 83.792879, утас: 8 (800) 200-00-00
- ВТБ Банк - Алтайн нутаг, Барнаул хот, Короленко гудамж, 97, GPS-ийн координат: 53.331304, 83.782558, утас: +7 (385) 239-91-61
- UniCredit Bank - Алтайн нутаг, Барнаул хот, Лениний өргөн чөлөө, 28, GPS-ийн координат: 53.338501, 83.787754, утас: +7 (385) 263-00-21
- Русский стандарт банк - Алтайн нутаг, Барнаул хот, Лениний өргөн чөлөө, 47, GPS-ийн координат: 53.343500, 83.780970, утас: 8 (800) 200-62-00
- Банк ОТП - Алтайн нутаг, Барнаул хот, Кировын гудамж, 51А, GPS координат: 53.344017, 83.783568, утас: +7 (385) 250-05-10
- Банк Сбербанк - Алтайн нутаг, Барнаул, Красноармейскийн гудамж, 15, GPS-ийн координат: 53.327199, 83.785505, утас: +7 (385) 222-91-44
- Сбербанкны салбар - Алтай улс, Манжерок суурин, Лениний гудамж, 2, GPS-ийн координат: 51.826334, 85.777272
- Сбербанкны салбар - R-369 дугаар авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Черга суурин, Октябрьская гудамж, GPS-ийн координат: 51.571997, 85.570232
- Сбербанкны салбар - Алтайн Бүгд Найрамдах Улс, Черга суурин, Октябрьская гудамж, 124, GPS-ийн координат: 51.569683, 85.567990
- Сбербанкны салбар - Алтайн Бүгд Найрамдах Улс, Онгудай, Советская гудамж, 84, GPS-ийн координат: 50.747750, 86.135069
- Мособлбанкны салбар - P-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Майма, Ленин гудамж, 5, GPS-ийн координат: 52.004798, 85.903110
- Сбербанкны салбар - P-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Майма, Лениний гудамж, 11, GPS-ийн координат: 52.003001, 85.899119
- Сбербанкны салбар - Алтай улс, Акташ суурин, Мира гудамж, 20/1, GPS-ийн координат: 50.312586, 87.603402
- Сбербанкны салбар - P-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Кош-Агач, Хоршооны гудамж, 40, GPS-ийн координат: 49.994908, 88.659482

Альфа-Банк: +7 (800) 2000-000

Сбербанк 900: +7 (800) 555-55-50

Райффайзенбанк: +7 (800) 700-91-00

Мособлбанк: +7 (800) 200-14-15

Связь банк: + 7 (800) 500-00-80

Росбанк: +7 (800) 200-54-34

Газпромбанк: +7 (800) 100-07-01

Совкомбанк: +7 (800) 200-66-96

### **Яаралтай үед холбоо барих харилцаа холбооны төхөөрөмж**

Замын хажуугаар суурин утас байхгүй байна. АН4 чиглэлийн авто замын дагуу байрлах орон сууцны хорооллуудад дараах утсаар холбогдох боломжтой.

- ОХУ-ын Шуудангийн хэлтэс - Новосибирск муж, Новосибирск, Курчатовагийн гудамж, 3/4, GPS-ийн координат: 55.106386, 82.962133
- Оросын шуудангийн салбар - Новосибирск мужийн П-256 / АН-4 авто замын салбар, Новосибирск, Мочищенскийн өргөн чөлөө, 18, GPS-ийн координат: 55.075247, 82.907256
- ОХУ-ын шуудангийн салбар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Новосибирск хот, Красный авто зам, 159, GPS-ийн координат: 55.060163, 82.911419
- Шуудангийн дугаар 59 - Новосибирск муж., Новосибирск, Узерная гудамж, 7, GPS-ийн координат: 54.924420, 83.080491
- Оросын шуудангийн газар - Новосибирск муж, Новосибирск, Барилгачидын гудамж, 15, GPS-ийн координат: 54.859903, 83.083409
- 116 тоот шуудангийн салбар - Новосибирск муж, Новосибирск, Лесная гудамж, 6А, GPS координат: 54.811596, 83.094052
- ОХУ-ын шуудангийн салбар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, хот., Большевицкая гудамж, 153, GPS-ийн координат: 54.996371, 82.967380
- Оросын шуудангийн салбар - Р-256 / АН-4 авто зам; Новосибирск муж, Искитим, Өмнөд микрор., 6А, GPS-ийн координатууд: 54.612732, 83.279516
- Оросын Шуудангийн салбар - Новосибирск муж, Искитим хот, Нагорный гудамж, 9, GPS-ийн координат: 54.575461, 83.328697
- Шуудангийн 34 тоот - Алтай нутаг, Бийск, 15 Гвардейской Кавалерской Дивизиин гудамж, 69, GPS-ийн координат: 52.545157, 85.287147
- Оросын шуудангийн салбар - Алтайн хязгаар, Новоалтайск, Белоаярская гудамж, 148, GPS-ийн координат: 53.452899, 83.902339
- Оросын шуудангийн газар - Алтайн хязгаар, Барнаул, Ст. Аванесова, 44, GPS-ийн координат: 53.318118, 83.784169
- ОХУ-ын Шуудангийн хэлтэс - Алтайн хязгаар, Барнаул, Ленин проспект, 54, GPS-ийн координат: 53.346392, 83.779550
- Оросын Шуудангийн салбар - Алтайн нутаг, Барнаул, Петра Суховын гудамж, 32, GPS-ийн координат: 53.376370, 83.729605
- Оросын Шуудангийн салбар - Алтайн нутаг, Барнаул, Малахова гудамж, 57, GPS-ийн координат: 53.343721, 83.694961
- Оросын шуудангийн салбар - Р-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Саузга тосгон, Центральная гудамж, 23/4, GPS-ийн координат: 51.888597, 85.852797
- Оросын шуудангийн салбар - Р-256 / АН-4 авто зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Манжерок суурин, Друзбийн гудамж, 53, GPS-ийн координат: 51.834337, 85.780072
- Оросын шуудангийн салбар - Р-256 / АН-4 хурдны зам; Алтайн Бүгд Найрамдах Улс, Усть-Муна тосгон, Кашурниковын гудамж, 27, GPS-ийн координат: 51.725111, 85.749682
- ОХУ-ын Шуудангийн салбар - Алтайн Бүгд Найрамдах Улс, Черга суурин, Октябрьская гудамж, 108/2, GPS-ийн координат: 51.569389, 85.569535

- Оросын шуудан - Алтайн улсын газар, Майма, Ленин гудамж, 4, GPS-ийн координат: 52.004751, 85.902913
- ОХУ-ын Шуудангийн алба, Алтайн Бүгд Найрамдах Улс, Горно-Алтайск, Коммунистический Ав., 178, GPS-ийн координат: 51.964488, 85.910241
- ОХУ-ын Шуудангийн үйлчлүүлэгчдэд үйлчлэх төв - 8 800 2005 888

Ерөнхийдөө томоохон суурин газруудад үүрэн холбооны сүлжээг ашиглах боломжтой юм. Улсын чанартай авто зам нь томоохон суурин газруудаас хол үргэлжилдэг тул үүрэн холбооны операторуудын холбооны цамхаг цөөн байгаагаас шалтгаалан зарим газарт сүлжээ муу байдаг. Иймд харилцаа холбооны тал дээр хүнрэлтэй асуудал тугарч болзошгүй юм.

Одоогийн байдлаар ОХУ-ын Тээврийн яамнаас авто зам дагуух үүрэн холбооны оператор компаниудын сүлжээг бий болгох асуудлыг судалж байна.

Яаралтай тусламжийн автоматжуулсан систем болох 112 гэсэн дугаар нь SIM картгүй ямар ч гар утсаар дуудлага хийж болохыг тэмдэглэх нь зүйтэй.



## ХАВСРАЛТ

Хавсралт 1

### **ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ХУУЛЬ**

12.21 дүгээр зүйл. Ачаа тээвэрлэх дүрэм болон чирэх дүрмийн зөрчил

1. Ачаа тээвэрлэх дүрэм, түүнчлэн чирэх журам зөрчих – сануулах, эсхүл таван зуун рубльтэй тэнцэх хэмжээний захиргааны торгууль ногдуулна.

12.21.1 дүгээр зүйл. Хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэх дүрмийн зөрчил

1. Хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь онцгой зөвшөөрөлгүйгээр тогтоосон хэмжээг 10 см-ээс бага хэмжээгээр хэтрүүлсэн, эсхүл онцгой зөвшөөрөлд заасан хэмжээг 10 хүртэл см-ээр хэтрүүлсэн, эсхүл онцгой зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх жин, эсхүл тэнхлэг дээрх ачааллыг 2 хувиас 10% хүртэл хэмжээгээр хэтрүүлсэн, эсхүл онцгой зөвшөөрөлтэй хэдий ч тэнхлэг дээрх даацыг зөвшөөрөлд заасан хэмжээнээс 2 хувиас их хэмжээгээр хэтрүүлсэн, гэхдээ энэ нь тээврийн хэрэгслийн бүх жингийн 10 %-д хүрээгүй тохиолдолд – жолоочийг 1000-аас 1500 рублиэр, тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 10000-аас 15000 рублиэр, хуулийн этгээдийг 100000–аас 150 000 рублиэр, хэрэв зөрчлийг хяналтын камер, бүхий тусгай автомат тоног төхөөрөмжөөр илрүүлсэн бол тээврийн хэрэгсэл эзэмшигчийг 150000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

2. Хүнд, овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн овор хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс 10-аас 20 см хүртэл хэмжээгээр хэтэрсэн, эсхүл тээврийн хэрэгслийн бодит жин, эсхүл тэнхлэг дээрх бодит жин нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс 10-аас 20 хувь хүртэл хэмжээгээр хэтэрсэн бол - жолоочийг 3000-аас 4000 рублиэр, тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 25000-аас 30000 рублиэр, хуулийн этгээдийг 250000–аас 300 000 рублиэр, хэрэв зөрчлийг хяналтын камер, бүхий тусгай автомат тоног төхөөрөмжөөр илрүүлсэн бол тээврийн хэрэгсэл эзэмшигчийг 300000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

3. Онцгой зөвшөөрөлгүйгээр хүнд, овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн овор хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс 20-аас их, 50 см хүртэл хэмжээгээр хэтэрсэн, эсхүл тээврийн хэрэгслийн бодит жин, эсхүл тэнхлэг дээрх бодит жин нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс 20-аас их, 50 хувь хүртэл хэмжээгээр хэтэрсэн бол – жолоочийг 5000-аас 10000 рублиэр торгох, эсхүл 2 сараас 4 сар хүртэл хугацаагаар жолоо барих эрхийг хасах; тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 35000-аас 40000 рублиэр, хуулийн этгээдийг 350000–аас 400000 рублиэр, хэрэв зөрчлийг хяналтын камер, бүхий тусгай автомат тоног төхөөрөмжөөр илрүүлсэн бол тээврийн хэрэгсэл эзэмшигчийг 400000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

4. Хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн оврын хэмжээ нь онцгой зөвшөөрөлд заасан хэмжээнээс 10 см-ээс 20 см хүртэл хэмжээгээр хэтрүүлсэн, эсхүл тээврийн хэрэгслийн бодит жин, эсхүл тээврийн хэрэгслийн тэнхлэг дээрх ачаалал нь онцгой зөвшөөрөлд заасан хэмжээнээс 10-

аас 20 хувь хүртэл хэмжээгээр хэтрүүлсэн бол – жолоочийг 3000-аас 3500 рублиэр, тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 20000-аас 25000 рублиэр, хуулийн этгээдийг 200000–аас 250000 рублиэр, хэрэв зөрчлийг хяналтын камер, бүхий тусгай автомат тоног төхөөрөмжөөр илрүүлсэн бол тээврийн хэрэгсэл эзэмшигчийг 250000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

5. Хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн оврын хэмжээ нь онцгой зөвшөөрөлд заасан хэмжээнээс 20 см-ээс 50 см хүртэл хэмжээгээр хэтрүүлсэн, эсхүл тээврийн хэрэгслийн бодит жин, эсхүл тээврийн хэрэгслийн тэнхлэг дээрх ачаалал нь онцгой зөвшөөрөлд заасан хэмжээнээс 20-оос 50 хувь хүртэл хэмжээгээр хэтрүүлсэн бол – жолоочийг 4000-аас 5000 рублиэр, тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 30000-аас 40000 рублиэр, хуулийн этгээдийг 300000–аас 400000 рублиэр, хэрэв зөрчлийг хяналтын камер, бүхий тусгай автомат тоног төхөөрөмжөөр илрүүлсэн бол тээврийн хэрэгсэл эзэмшигчийг 400000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

6. Хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь онцгой зөвшөөрөлгүйгээр тогтоосон хэмжээг 50 см-ээс их хэмжээгээр хэтрүүлсэн, эсхүл онцгой зөвшөөрөлд заасан хэмжээг 50 см-ээр их хэмжээгээр хэтрүүлсэн, эсхүл онцгой зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх жин, эсхүл тэнхлэг дээрх ачааллыг 50 хувиас их хэмжээгээр хэтрүүлсэн, эсхүл онцгой зөвшөөрөлтэй хэдий ч тээврийн хэрэгслийн бодит жинг, эсхүл тэнхлэг дээрх даацыг зөвшөөрөлд заасан хэмжээнээс 50 хувиас их хэмжээгээр хэтрүүлсэн тохиолдолд – жолоочийг 7000-аас 10000 рублиэр, эсхүл жолооч барих эрхийг 4 сараас 6 сар хүртэл хугацаагаар хасах; тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 40000-аас 50000 рублиэр, хуулийн этгээдийг 400000–аас 500000 рублиэр, хэрэв зөрчлийг фото зураг, хяналтын камер бүхий тусгай автомат тоног төхөөрөмжөөр илрүүлсэн бол тээврийн хэрэгсэл эзэмшигчийг 500000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

7. хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь дээр дурдсан 1-ээс 6 дугаар зүйл зааснаас бусад зөрчил гаргасан бол - жолоочийг 1000-аас 1500 рублиэр, тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 5000-аас 10000 рублиэр, хуулийн этгээдийг 50000–аас 100000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

8. Хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэлтийн ачаа илгээгч нь тээвэрлэж буй ачааны жин, эсхүл овор хэмжээ, онцгой зөвшөөрлийн бичгийн дугаар, хүчинтэй хугацаа болон тээврийн маршрутын талаарх мэдээллийг онцгой зөвшөөрлийн бичигт тэмдэглээгүй, эсхүл худал тэмдэглэсэн, энэ нь энэхүү бүлгийн дээр дурдсан 1, 2, эсхүл 4 дүгээр зүйлд заасан зөрчлийг үүсгэсэн бол – иргэний 1000-аас 2000 рублиэр, албан тушаалтныг 15000-аас 20000 рублиэр, хуулийн этгээдийг 200000-аас 300000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

9. Хүнд болон овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэлтийн ачаа илгээгч нь тээвэрлэж буй ачааны жин, эсхүл овор хэмжээ, онцгой зөвшөөрлийн бичгийн дугаар, хүчинтэй хугацаа болон тээврийн маршрутын талаарх мэдээллийг онцгой зөвшөөрлийн бичигт тэмдэглээгүй, эсхүл худал тэмдэглэсэн, энэ нь дээр дурдсан 3, 5, 6 дүгээр зүйлд заасан зөрчлийг үүсгэсэн бол – иргэний 5000 рублиэр, албан тушаалтныг 25000-аас 30000 рублиэр, хуулийн этгээдийг 350000-аас 400000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

10. Ачаа, барааг тээврийн хэрэгсэлд ачих үйл ажиллагаа эрхэлдэг хувиараа аж ахуйн эрхлэгч, эсхүл хуулийн этгээд нь тээврийн хэрэгслийн жинг, эсхүл тэнхлэг дээрх даацыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлсэн, эсхүл тээврийн хэрэгслийн жинг болон тэнхлэг дээрх даацыг онцгой зөвшөөрлийн бичигт заасан хэмжээнээс хэтрүүлсэн бол - хувиараа аж ахуйн эрхлэгчийг 80000-аас 100000 рублиэр, хуулийн этгээдийг 250000-аас 400000 рублиэр торгох захиргааны шийтгэл ногдуулна.

11. Тээврийн хэрэгслийн бодит бүх жин, эсхүл тэнхлэг дээрх ачааллыг замын тэмдэгт заасан хэмжээнээс хэтрүүлсэн, замын хориглох тэмдэгийг зөрчиж, онцгой зөвшөөрөлгүйгээр тээвэрлэлт гүйцэтгэсэн бол – 50000 рублиэр торгох захиргааны шийтгэл ногдуулна.

Сануулга: Хуулийн этгээдийн бүртгэлгүй хувиараа үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь дээр дурдсан захиргааны зөрчлүүдийг үүсгэсэн тохиолдолд хуулийн этгээдтэй адил хэмжээний захиргааны шийтгэл ногдуулна.

12.21.2 дугаар зүйл. Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх дүрмийн зөрчил:

1. Аюултай ачаа тээвэрлэх жолооч нь аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн зохих сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй, аюултай ачааг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь аюултай ачаа тээвэрлэх онцгой зөвшөөрөлгүй, эсхүл тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй ослын үеийн аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийн системийн картгүй, эсхүл аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн хийц нь дүрмийн шаардлагад нийцээгүй, мөн шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдоогүй, эсхүл аюултай ачаа тээвэрлэх явцад гарч болзошгүй ослын үр дагаврыг арилгахад ашиглах тоног, төхөөрөмжгүй, эсхүл эдгээр дүрэмд заасны дагуу аюултай ачаа тээвэрлэх нөхцөлийг биелүүлээгүй бол (2007.11.08-ны өдрийн 257-ФЗ, 2015.07.13-ны өдрийн 248-ФЗ хуулиар өөрчлөлт орсон) – жолоочийг 2000-аас 2500 рублиэр торгох, эсхүл 4 сараас 6 сар хүртэл хугацаагаар жолоо барих эрхий хасах; тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 15000-аас 20000 рублиэр, хуулийн этгээдийг 400000–аас 500000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

2. Энэхүү бүлгийн 1 дүгээр зүйлд зааснаас бусад зөрчил гаргасан бол - жолоочийг 1000-аас 1500 рублиэр торгох; тээвэрлэлтийн асуудал хариуцсан албан тушаалтныг 5000-аас 10000 рублиэр, хуулийн этгээдийг 150000–аас 250000 рублиэр торгох захиргааны шийтгэл оногдуулна.

**“Авто замын тухай болон Оросын Холбооны Улсад замын үйл ажиллагааны тухай болон ОХУ-ын хууль тогтоомжийн зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 257-ФЗ Холбооны хууль.**

**31 дүгээр зүйл.** Хүнд, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа, мөн түүнчлэн аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл авто замаар зорчих хөдөлгөөн

1. Овор хэмжээ ихтэй ачаа, эсхүл Олон улсын авто замаар аюултай ачаа тээвэрлэх тухай (ADR) Европын хэлэлцээрийн дагуу аюултай ачаанд хамаарах аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь энэхүү зүйлд заасан журмын дагуу онцгой зөвшөөрөл авсны үндсэн дээр авто замаар тээвэрлэлт гүйцэтгэнэ.
2. Хүнд жинтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачаатай болон ачаагүй жин, эсхүл тэнхлэг дээрх ачаалал нь тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн жингээс, эсхүл тэнхлэг дээрх ачааллаас 2 хувиас их хэмжээгээр хэтэрсэн бол энэхүү зүйлд заасан журмын дагуу онцгой зөвшөөрөл авсны үндсэн дээр авто замаар тээвэрлэлт гүйцэтгэнэ.
5. Аюултай ачаа, эсхүл хүнд болон овор хэмжээ ихтэй ачааны тээвэрлэлтийг “Олон улсын автотээвэрлэлтэд төрийн хяналт, шалгалт хийх тухай болон тэдгээрийг гүйцэтгэхэд гаргасан зөрчилд ногдуулах хариуцлагын тухай” 1998 оны 127-ФЗ хуулийн дагуу зохион байгуулна.
6. энэхүү зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт онцгой зөвшөөрлийг авахад:
  - 1) Хүнд, эсхүл овор хэмжээ ихтэй ачааны тээвэрлэлт гүйцэтгэх маршрутыг энэхүү зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу зөвшилцөнө.
  - 2) Хүнд жинтэй ачаа тээвэрлэлтээс үүдэн гарсан хохирлыг энэхүү зүйлийн 12 хэсэгт заасны дагуу тээврийн хэрэгсэл эзэмшигч нь барагдуулна.
7. энэхүү зүйлийн 1 болон 2 дахь хэсэг заасан онцгой зөвшөөрөл олгодог байгууллага нь хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй, түүнчлэн аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх чиглэлийг тухайн дайран өнгөрөх авто замын эзэмшиг нартай зөвшилцөн тогтоох бөгөөд харин овор хэмжээ нь ОХУ-ын Засгийн газраас тогтоосон хэмжээнээс 2 хувиас дээш хэмжээгээр хэтэрсэн тохиолдолд замын хөдөлгөөний аюулгүй байдал хангах чиглэлийн эрх бүхий төрийн хяналт, шалгалт, зөвшөөрөл олгох чиг үүргийг хэрэгжүүлэг төрийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэлт явагдах чиглэлийн дагуух авто замын тодорхой хэсгүүдийг хүчитгэх, зөвшилцсөн чиглэлийн дагуух авто замын инженерийн байгууламжууд, шугам сүлжээг хамгаалах, тоноглох ажлыг замын хөдөлгөөний аюулгүй байдал хангах чиглэлийн эрх бүхий төрийн хяналт, шалгалт, зөвшөөрөл олгох чиг үүргийг хэрэгжүүлэг төрийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. Хүнд жинтэй, овор хэмжээ ихтэй ачаа болон аюултай ачаа тээвэрлэлтийн байнгын замналыг тогтоож болно. Хүнд жинтэй, эсвэл овор хэмжээ ихтэй болон аюултай ачаа тээвэрлэж буй

тээврийн хэрэгслийн хөдөлгөөний маршрутыг зөвшилцөхөд төлбөр авахыг хориглоно.

9. Энэхүү зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан онцгой зөвшөөрөл өгөх, хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа, түүнчлэн аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний замналыг зөвшилцөх, түүнчлэн хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн жин болон овор хэмжээний шалгалтыг зохион байгуулах цэгийн ажиллах журам, энэхүү хэсэгт заасан тээврийн хэрэгслийн байнгын тээврийн замналыг тогтоох журмыг ОХУ-ын Засгийн газрын эрх бүхий байгууллага тогтооно.
10. Энэхүү зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан онцгой зөвшөөрлийг:
- 1) Аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх буй тээврийн хэрэгслийн авто замаар зорчихтой холбоотой тээврийн салбарын хяналт, шалгалт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага олгоно;
  - 2) Хэрэв хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн зорчих маршрут, маршрутын зарим хэсэг нь улсын чанартай авто замаар зорчих тохиолдолд, эдгээр авто замын хэсгүүд нь ОХУ-ын хоёр болон түүнээс дээш засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх тохиолдолд авто замын салбарын өмчийг удирдах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага бие даан, эсхүл харьяа эрх бүхий байгууллагаар дамжуулан олгоно;
  - 3) Хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн зорчих маршрут, маршрутын зарим хэсэг нь хоёр болон түүнээс дээш хотын засаг захиргаа (хотын дүргүүд) нутаг дэвсгэрт байрлах орон нутгийн чанартай авто замаар дайран өнгөрөх тохиолдолд, түүнчлэн уг тээврийн хэрэгслийн зорчих маршрут нь улсын чанартай авто зам, замын хэсгээр дайран өнгөрөхгүй нөхцөлд ОХУ-ын субъектийн гүйцэтгэх засаглалын байгууллага бие даан, эсхүл түүний эрх олгосон харьяа байгууллагаар дамжуулан олгоно;
  - 4) Хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн зорчих маршрут, маршрутын зарим хэсэг нь улсын чанартай авто зам, бүс нутгийн, эсхүл мужийн чанартай авто зам, замын хэсгээр дайрахгүйгээр хоёр ба түүнээс дээш суурин газрын нутаг дэвсгэрт байрлах орон нутгийн чанартай авто замаар зорчих тохиолдолд хотын дүүргийн өөрөө удирдах байгууллага бие даан, эсхүл түүнээс эрх олгосон харьяа байгууллагаар дамжуулан олгоно;
  - 5) Хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн зорчих маршрут, маршрутын зарим хэсэг нь улсын чанартай авто зам, бүс нутгийн, эсхүл мужийн, хотын дүүргийн орон нутгийн чанартай авто зам, замын хэсгээр дайрахгүйгээр тухайн суурин, хотын орон нутгийн авто замаар зорчих тохиолдолд суурийн газрын өөрөө удирдах байгууллага бие даан, эсхүл түүнээс эрх олгосон харьяа байгууллага олгоно.
  - 6) Хүнд жинтэй, эсхүл овор хэмжээ ихтэй ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн зорчих маршрут, маршрутын хэсэг нь улсын, мужийн, эсхүл хот хоорондын чанартай авто зам, замын хэсгээр

дайрахгүйгээр зөвхөн хотын дүүргийн чанартай авто замаар зорчих тохиолдолд хотын дүүргийн өөрөө удирдах байгууллага бие даан, эсхүл түүнээс эрх олгосон байгууллагаар дамжуулан олгоно.

- 11) Энэ зүйлийн 10 дахь хэсгийн 1-6-д заасан тохиолдолд энэ зүйлийн 1, эсхүл 2 дахь хэсэгт заасан онцгой зөвшөөрөл олгоход Татвар, хураамж төлөх тухай ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу улсад хураамж төлнө.
- 12) Хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчсоны улмаас учирсан хэмжээг тогтоох, хохирлыг журмыг ОХУ-ын Засгийн газар тогтооно.
- 13) Хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчсоны улмаас учирсан хэмжээг дараах байдлаар тодорхойлно:
  - 1) Уг тээврийн хэрэгсэл нь улсын чанартай авто замаар зорчсон тохиолдолд ОХУ-ын Засгийн газар;
  - 2) Уг тээврийн хэрэгсэл нь бүс нутгийн болон хот хоорондын чанартай авто замаар зорчсон тохиолдолд ОХУ-ын тухайн субъектийн төрийн эрх барих дээд байгууллага;
  - 3) Уг тээврийн хэрэгсэл нь орон нутгийн чанартай авто замаар зорчсон тохиолдолд орон нутгийн өөрөө удирдах байгууллага;
  - 4) Уг тээврийн хэрэгсэл нь хувийн авто замаар зорчсон тохиолдолд тухай авто зам эзэмшигч.
- 14) Хэрэв хүнд жинтэй, эсхүл том оврын ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулан авто замын техникийн байдалд үнэлгээ хийх, шаардлагатай бол авто замын хэсгүүд, түүнчлэн зам хөндлөн гарч буй инженерийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хүчитгэх ажлыг энэхүү зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан онцгой зөвшөөрлийг авахаас өмнө хийж гүйцэтгэх бөгөөд тээвэрлэлт гүйцэтгэх хүсэлтэй этгээд нь эдгээр ажлыг хийж гүйцэтгэсэн хуулийн этгээд болон хувиараа үйл ажиллагаа эрхлэгч нарт төлбөрийг төлнө.

Хэрэв хүнд жинтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн жин, эсхүл тэнхлэг дээрх ачаалал нь тогтоосон хэмжээнээс 2-оос 10 хувь хүртэл хэмжээгээр хэтэрсэн тохиолдолд уг тээврийн хэрэгслийн зорчих онцгой зөвшөөрлийг цахим хэлбэрээр, хялбаршуулсан журмаар олгодог [.....]

**“Авто замын тухай болон Оросын Холбооны Улсад замын үйл ажиллагааны тухай болон ОХУ-ын хууль тогтоомжийн зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 257-ФЗ Холбооны хууль.**

**30 дугаар зүйл.** Авто замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах болон түр хязгаарлалт хийх

1. Дараах тохиолдолд авто замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах болон түр хязгаарлалт хийнэ:
  - 1) авто замын өргөтгөл, шинэчлэлт, засварын ажил хийх үед;
  - 2) цаг уурын таагүй нөхцөл байдал үүссэн үед авто замын хэсэг, түүний бүтцийн элементүүдийн даацын чадвар буурах болон бусад тохиолдолд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор;
    - 2.1) Баяр ёслолын өмнө болон бүх нийтээр амрах баяр ёслолын үеэр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим ихэссэн, түүнчлэн авто замын оргил цагаар;
  - 3) Суурин газрын хилийн дагуух бүс нутгийн болон хот хоорондын, орон нутгийн чанартай авто замын хувьд авто замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд уг асуудлыг ОХУ-ын субъектүүдийн хуулиар шийдвэрлэнэ.
2. Улсын болон хувийн авто зам дээрх хөдөлгөөнийг хаах, түр хугацааны хязгаарлалт хийх асуудлыг ОХУ-ын Засгийн газраас эрх олгосон байгууллагаас гаргасан журмаар шийдвэрлэнэ.
  - 2.1) Бүс нутгийн болон хот хоорондын, орон нутгийн чанартай авто замаар зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах, хаах асуудлыг ОХУ-ын субъектийн төрийн эрх барих дээд байгууллагаас тогтоосон журмаар явуулна.
  - 3) Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах, хаах тухай шийдвэр гарсан тохиолдолд авто замын аж ахуйн чиглэлээр төрийн үйлчилгээ үзүүлдэг, төрийн өмчийг удирдах чиг үүргийг гүйцэтгэдэг захиргааны байгууллага, ОХУ-ын субъектийн гүйцэтгэх засаглалын байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд замын хөдөлгөөний чиглэлээр шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд тэр дундаа тойрог зам гаргана.
  - 4) Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах, хаах тухай шийдвэр гарсан тохиолдолд зам эзэмшигчид нар энэ

хязгаарлалт хийх буюу тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох хугацаа, тойрон явах боломжийн талаарх мэдээллийг авто зам ашиглагчдад мэдэгдэх үүрэгтэй.



**Улсын чанартай авто зам болон хувийн авто зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах болон хаах журам батлах тухай ОХУ-ын Тээврийн яамны 2011 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр тушаал**

8. Хэрэв хязгаарлалт хийх тухай шийдвэр гарсан тохиолдолд улсын Авто замын агентлаг, ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, хувийн авто замын эзэмшигч, эрх бүхий байгууллага нь (цаашид – “эрх бүхий байгууллага” гэх) замын хөдөлгөөнийг зохион байгуулах арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд тэр дундаа энэхүү журмын III, V бүлэгт заасан тохиолдлуудад тойруу замаар явуулах ажлыг зохион байгуулна.

III. Авто замын өргөтгөл, шинэчлэлт, их засвар болон засварын ажлын үед хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах болон хаах

Авто замын өргөтгөл, шинэчлэлт, их засвар болон засварын ажлын үед хөдөлгөөнийг түр хязгаарлах, хаах шийдвэрийг тогтоосон журмын дагуу хийгдсэн зураг төслийн баримт, бичгийг үндэслэн гаргах бөгөөд энэ нь хөдөлгөөнийг түр хязгаарлах, хаах шаардлагатайг баталсан байна.

Хязгаарлалт хийж буй шийдвэр батлагдсаны дараа Улсын авто замын агентлаг, “Оросын авто зам” улсын компани, хувийн авто замын өмчлөгчид энэхүү шийдвэрийн хуулбар болон замын хөдөлгөөнийг зохион байгуулалтын схемийг ОХУ-ын Дотоод хэргийн яамны Авто замын аюулгүй байдлын хяналтын улсын холбогдох байгууллага, нэгжид хүргүүлнэ.

12. Авто замын өргөтгөл, шинэчлэлт, их засвар болон засварын ажлын үеэр хөдөлгөөнийг түр хязгаарлах, эсхүл хаах асуудлыг дараах байдлаар хийж гүйцэтгэнэ:

- Авто замын тодорхой хэсгийн хөдөлгөөнийг хаах болон хөдөлгөөнийг нийтийн эзэмшлийн замаар тойруулах асуудлыг тэдгээрийн эзэмшигч нартай зөвшилцөнө;
- Түр зуурын тойрог замыг байгуулах;
- Нэг чиглэлийн, эсхүл буцах чиглэлийн хөдөлгөөнийг зохион байгуулах;
- Тодорхой хугацаанд замын хөдөлгөөнийг хаах, энэ хугацаа нь хоногт 8 цагаас хэтрэх ёсгүй;
- Бүх жин, тэнхлэг дээрх ачаалал, түүнчлэн тэдгээрийн овор хэмжээ нь авто замын өргөтгөл, шинэчлэлт, их засвар болон засварын ажлын үед хийсэн түр зуурын хязгаарлалтаар тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгслийн (ачаатай болон ачаагүй) хөдөлгөөнийг хязгаарлах.

13. Түр хугацааны хязгаарлалт, эсхүл хөдөлгөөнийг хаах хугацааг зураг, төслийн баримт, бичгийн дагуу тогтооно. Хязгаарлалт үргэлжлэх хугацааг цаг агаарын тааламжгүй байдал, онцгой байдлын үед, давагдашгүй хүчин зүйл, хязгаарлалтын талаарх эрх зүйн актад нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд өөрчлөхийг зөвшөөрнө. Авто замын ашиглагчдад нэн даруй мэдээлнэ.

14. Түр хугацааны хязгаарлалт, эсхүл хөдөлгөөнийг хаах тухай актад заасан байгууллагууд зохих замын тэмдэг буюу замын хөдөлгөөний удирдлагын бусад техник хэрэгслийг суурилуулах замаар хязгаарлалтыг хийх, түүнчлэн зохицуулалт-хуваарилалтын арга хэмжээг авна.

15. Хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах болон хөдөлгөөнийг хаах шийдвэр нь хөдөлгөөнийг хязгаарлах, хаах хэсэгт замыг шинэчлэх, их засвар хийх, засварлах явцад замын ажил гүйцэтгэж буй зам барилга, зам засварын техник, хэрэгслийг тээвэрлэхэд хамаарахгүй.

IV. Цаг агаарын таагүй нөхцөл үүссэн үеэр зам, замын бүрэлдхүүн хэсгүүдийн даацын чанар буурсан тохиолдолд хөдөлгөөнийг түр хязгаарлах

16. Хаврын улиралд ус, чийгнээс шалтгаалан зам, замын бүрэлдэхүүн хэсгүүдийн даацын чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор (авто замын хучилтын бат бөх байдлын коэффициент нь нэгээс бага байх тохиолдолд замын техникийн байдлаас хамаарна) хөдөлгөөний түр хязгаарлалт хийдэг, түүнчлэн зуны улиралд өдрийн агаарын температур 32° С-ээс дээш гарахад асфальт-бетонон хучилттай авто замаар хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарлана.

[.....]

19. Хаврын улиралд тээврийн хэрэгслийн тэнхлэг дээрх ачаалал нь хөдөлгөөний хязгаарлалт хийх тухай шийдвэрээр тогтоосон зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тээврийн хэрэгслийг авто замаар зорчуулах асуудлыг хүнд даацын тээврийн хөдөлгөөнийг зохицуулсан Оросын Холбооны Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

20. Хаврын улиралд хөдөлгөөний түр хязгаарлалт дараах тохиолдолд үйлчлэхгүй.

- Олон улсын ачаа тээвэрлэлт;
- Автобусаар хийгдэж буй дотоодын болон олон улсын зорчигч тээвэрлэлт;
- Хүнсний бүтээгдэхүүн, амьтан, эм, эмийн бүтээгдэхүүн, шатахуун (бензин, дизель, хөлөг онгоцны түлш, тийрэлтэд хөдөлгүүрийн түлш, мазут, хийн түлш), үр тарианы нөөц бүрдүүлэх, шуудан болон илгээмжийн ачаа тээвэрлэлт;
- Байгалийн гамшиг болон онцгой байдлын үеийн нүүлгэн шилжүүлэлтийн ачаа тээвэрлэлт;
- Аваар ослын үед замын сэргээн - босголт засварт ашиглагдах зам барилгын тоног төхөөрөмж, материалын тээвэрлэхэд;

- Цэрэг, байлдааны хуульд заасан чиг үүргийг гүйцэтгэх байгууллагуудын тээврийн хэрэгсэл.

21. Хаврын улиралд авто зам дээр хийгдэх хөдөлгөөний хязгаарлалтын хугацаа нь 30 хоногоос хэтрэхгүй.

22. Зуны улиралд 5-р сарын 20-оос 8-р сарын 31-ний хооронд агаарын температур өдөртөө 32 хэмээс дээш байх үед асфальт бетон хучилттай авто зам дээр хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд түр хязгаарлалт хийнэ.

23. Зуны улиралд түр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний түр хязгаарлалтын үеэр хүнд жинтэй ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн жин, тэнхлэг дээрх даац нь ОХУ-д тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бол 22:00-10:00 цагийн хооронд асфальт-бетонон хучилттай авто замаар зорчихыг зөвшөөрнө.

[.....]

**"Автомашины шалган нэвтрүүлэх цэгүүдэд хүн, тээврийн хэрэгсэл, ачаа, бараа, амьтдыг ОХУ-ын улсын хилээр шалган нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах ерөнхий загвар схемийг батлах тухай" ОХУ-ын Тээврийн яамны 2014 оны 1-р сарын 24-ний өдрийн 23 дугаар тушаал**

[.....]

**II. ОХУ-ын нутаг дэвсгэрт нэвтрэх ачаа тээврийн хэрэгслээр ачигдан ирж буй хүн, ачаа, бараа, амьтан ирэхэд төрийн байгууллагуудын хийх хяналтын үндсэн үйл ажиллагааны дараалал.**

7. ОХУ-ын нутаг дэвсгэрт нэвтэрч буй ачааны автомашинд хилийн боомтод төрийн хяналт, шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааны дарааллыг дараах байдлаар тогтоосон:

7.1. Хүн, амьтны хорио-цээрийн хяналт (хүн амын эпидемиологийн хорион цээрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эрсдэл үүсч болзошгүй онцгой байдлын үед);

1) Эрүүл мэндийн талаарх гомдол байгаа эсэх талаар тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хүмүүсээс судалгаа авах;

2) Ариун цэврийн болон хорио цээрийн хяналтын баримт бичгийн шалгалт;

3) Шаардлагатай бол эрүүл ахуй-хорио цээрийн хяналтын чиглэлээр бусад холбогдох арга хэмжээ авах шийдвэр гаргах;

4) Онцгой аюултай халдварт өвчнөөр өвчилсөн гэж сэжиглэгдсэн өвчтөнийг илрүүлсэн тохиолдолд шуурхай ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

5) Эрүүл ахуйн хорио цээрийн хяналтын үр дүнг холбогдох мэдээллийн системд оруулах;

6) Хүмүүсийг цааш нь нэвтрүүлэх эсэх талаар шийдвэр гаргах.

7.2. Хилийн хяналт:

1) Жолооч болон ачааг дагалдан яваа хүмүүсийн улсын хил нэвтрэх зөвшөөрлийн бичиг, баримтын шалгалт;

2) Ачааны тээврийн хэрэгслийн үзлэг;

3) Ачаа тээврийн хэрэгсэлд шалгалт хийсэн тухай шийдвэрийн талаар гаалийн байгууллагын ээлжийн ахлах албан тушаалтанд мэдэгдэх;

4) Хилийн хяналтын үр дүнг холбогдох мэдээллийн системд оруулах;

5) Хүмүүс болон тээврийн хэрэгслийг цааш нь нэвтрүүлэх эсэх талаар шийдвэр гаргах.

7.3. Тээврийн хяналт:

1) ОХУ-ын нутаг дэвсгэр дээр, түүнчлэн Гаалийн холбооны бусад гишүүн орнууд, тэдгээрийн нутаг дэвсгэрт тогтоосон зөвшөөрөгдөх хамгийн их жин, тэнхлэгийн ачаалал болон тээврийн хэрэгслийн овор хэмжээн тохирч байгаа эсэхийг тогтоохын тулд тээврийн хэрэгслийн жин, овор хэмжээг хэмжинэ;

2) Тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн улсын бүртгэлийн дугаарыг тулгах болон ялгах тэмдгийг шалгах;

3) Тээврийн хяналттай холбоотой дараах бичиг, баримтын шалгалт: Жолооны үнэмлэх болон тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ; ОХУ-ын нутаг, дэвсгэрээр зорчих зөвшөөрлийн бичиг(гадны тээврийн хэрэгслийн хувьд); Гаалийн холбооны улсуудын нутаг дэвсгэрт зорчих зөвшөөрлийн бичиг; олон улсын тээвэрлэлт гүйцэтгэхийг зөвшөөрсөн карт; ОХУ-ын болон Гаалийн холбооны улсуудын нутаг дэвсгэрт хүнд жинтэй, овор хэмжээ ихтэй болон аюултай ачаа тээвэрлэх онцгой зөвшөөрөл; бараа-тээврийн баримт, бичиг; тээврийн хэрэгслийн жингийн олон улсын гэрчилгээ.

4) тогтоосон төлбөрийг төлсөн тухай мэдэгдэл гаргах;

5) Тээврийн хяналтын үр дүнг холбогдох мэдээллийн системд оруулах;

6) Тээврийн хэрэгслийг цааш нь нэвтрүүлэх эсэх талаар шийдвэр гаргах.

[.....]